

Авлига, ашиг сонирхлоос сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаа нь хууль өөрчлөх, хяналт шалгалт тавих, хариуцлага хүлээлгэх төдийхнөөр хязгаарлагдахгүй. Нэгэнтээ бий болсон нөхцөл байдалтай үндэсний хэмжээнд тэмцэх шаардлагатай болжээ. Иймд авлига, ашиг сонирхлоос сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх, нийгмийн бүхий л хүрээнд авлигыг үл тэвчих хандлага тогтооход чиглэгдсэн шинэ үзэл баримтлал, арга зам санал болгох шаардлагатай байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах. Авлигын эсрэг олон хэрэгслийг ашиглахгүй байна. Эдгээр хэрэгслийг ашиглахын тулд төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, иргэдийн хөдөлгөөнийг чадавхжуулах бүх хүчин чармайлтаа дайчлах хэрэгтэй. Энэ ажил нь улс төр, эдийн засгийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг сэргээх, бизнес эрхлэгчдийн итгэлийг бэхжүүлэх гол тулхүүр болно. Засгийн газраас лиценз, зөвшөөрөл олгох журмын ил тод, тодорхой байдлыг сайжруулах. Үүнийг ялангуяа мэргэжлийн хяналт, гааль зэрэг тэргүүлэх ач холбогдолтой, өндөр эрсдэлтэй салбаруудад хэрэгжүүлэх шаардлагатай байна. Засгийн газар, бизнесийн холбоод лиценз, зөвшөөрөл олгохтой холбоотой хууль тогтоомж, бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх ёстой. Салбарын болон бизнесийн холбоод нь зруул мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгэм, олон нийтийн оролцоо, мөн байгууллагын хариуцлага ба ёс зүйн чиглэлээр бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад санал санаачлагатай, манлайлагч байх ёстой.

Шүүхийн хараат бус байдал нь олон нийтийн итгэл ялангуяа шүүхийн шударга ёсны тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой. Хууль дээдэлдэг нийгэмд шүүх засаглал нь улс төрийн нөлөөнөөс хараат бус гэдэгт итгэх олон нийтийн итгэл амин чухал юм.

Шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг албан тушаалтан өөрийн үзэмжийн хүрээнд шийдвэрлэх бололцоо байсаар байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгаанд оролцсон шүүх болон шүүхийн захирагааны ажилтнууд Шүүхийн еренхий зөвлөлийг өргөн эрх мэдэлтэй гэж дүгнэсэн байна. Мөн Нээлттэй нийгэм форумын судалгаагаар шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаа, шүүгчид тавигдаж буй шалгуур бодитой, объектив болж чадаагүй, шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг албан тушаалтан өөрийн үзэмжийн хүрээнд шийдвэрлэх бололцоо байсаар байна гэж дүгнэсэн байна. Мөн шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөлтийн үед Үндсэн хуулийн дагуу шүүгч хугацаагүй томилогох зарчим зөрчигдэж, зарим шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, зарим шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүй шилжүүлэн томилсон тохиолдол гарсаар байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын тэргүүнийг нь төв засгийн оролцоогүйгээр сонгодог дэлхий нийтийн чиг хандлага Монгол Улсад ялгаатай байна. Орон нутгийн өөрийн удирдлагыг Үндсэн хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрч, орон нутгийн гүйцэтгэх засаглалын тэргүүнийг нь төв засгийн оролцоогүйгээр иргэдээс шууд, эсхүл зөвлөлөөс сонгох нь дэлхий нийтийн чиг хандлага болжээ. Харин манай улсад орон нутгийн Засаг даргыг томилоход төв засгийн оролцоо одоо хэр хэвээр байгаа, тэр ч байтугай Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно” гэсэн нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагад төв засгийн оролцоог хамгийн дээд түвшинд бататгасан заалт болжээ.

Олон улсын түвшинд нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг өөрөөр тодорхойлсон байна. Үндсэн хуулийн харьцуулсан эрх зүйн Оксфордын лавлахад “Орчин үеийн ихэнх төрт улсуудад нутгийн удирдлагыг чөлөөт, нууц, тэгш, бүх нийтийн сонгуулиар байгуулсан орон нутгийн өөрөө удирдах засгийн тусгай байгууллагууд (зөвлөл, ассемблей) хэрэгжүүлж байна. Орон нутгийн өөрийн удирдлага нь үндэсний парламентаас гадна легитим байдал нь сонгуульд үндэспэдэг цорын ганц эрх мэдлийн төв юм. Гэхдээ энэ бие даасан байдал автономит байдлаас ялгаатай нь орон нутгийн төлөөллийн

байгууллагуудад хууль тогтоох эрх байдагүй, хууль тогтоох дээд байгууллагаас гаргасан эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг" гэжээ. Дээрх тодорхойлолтуудыг Монголын нэхцэлтэй харьцуулахад Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллага гэж хүлээн зөвшөөрсөн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь нутгийн өөрөө удирдах байгууллага мөн үү гэдэг асуултыг тавихад хүргэж байна.

Үндэсний аюулгүй байдлын шинэ нэхцэл байдал нь хүн төвтэй, цогц, мэдлэгт сууринсан гэсэн суурь зарчмаар өөрчлөгдсөн. Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг 2010 оны 7-р сарын 15-ны өдөр УИХ баталсан билээ. Энэ Үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын чухал баримт бичиг юм. Үндэсний аюулгүй байдлын шинэ нэхцэл байдал нь аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгэж, шинэчилсэн үзэл баримтлал нь хүн төвтэй, цогц, мэдлэгт сууринсан гэсэн суурь зарчмаар өөрчлөгдсөн.

Аюулгүй байдалд хандах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томьёолж оршин тогтонохуйн аюулгүй байдал, здийн засгийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал гэсэн зургаан чиглэлээр цогц, консайленс хэлбэрээр харилцан уялдаатай хангах, нийгэм, иргэдийн хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах шаардлагатай болсон.

Монгол Улс олон төрлийн хямрал, мөргөлдөөн даамжирч болзошгүй эрсдэлтэй бүс нутагт оршдог. Манай орны оршин тогтнодог Ази, Номхон далайн бүс нутаг цэрэг зэвсгийн хүч ихээр төвлөрсөн, улс төр, үзэл суртлын эрс ялгаатай орнууд зэрэгцэн байрладаг, цөмийн зэвсгийн аюул бодитоор оршсоор байгаа зэрэг уламжлалт аюулаас гадна олон улсын терроризм, салан тусгаарлах, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа, хүний эрх, хүмүүнлэгийн хямрал зэрэг уламжлалт бус аюул ч даамжирч болзошгүй бүс нутаг болоод байгаа нь манай улсын аюулгүй байдлын гадаад орчинд нөлөө үзүүлэхээр байна.

Батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалтын төсөв хангалтгүй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын төсвөөс нийт 40.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв батлагдсанаас барилга байгууламж шинээр барихад 26.6 тэрбум төгрөг, барилга байгууламжийн их засварт 4.5 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 9.8 тэрбум төгрөг тус тус батлагдсан. Энэ нь улсын болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд батлан хамгаалах бодлогын чиглэлээр тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хэрэгцээтэй харьцуулахад батлагдаж буй хөрөнгө оруулалтын төсөв нь хангалтгүй үзүүлэлттэй байгаа юм.

Хүснэгт 12. Батлан хамгаалах салбарын төсөө, тэрбум төгрөг

Хөрөнгө оруулалтын ангилал	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт	Эзлэх хувь
Барилга, байгууламж	5.9	4.9	3.1	6.6	6.1	26.6	65.1
Их засвар			0.48	2	2	4.5	11.0
Тоног төхөөрөмж				6.9	2.9	9.8	24.0
Бүгд	5.9	4.9	3.6	15.5	11.0	40.9	

Эх сурвалж: Батлан хамгаалах яам

"Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр" нь хүний эрхийг эрх зүйн тулгуур баримт бичиг юм. Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан, хүний суурь эрхийг хангах, хамгаалах, үндэсний чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн 4 бүлэг 240 зүйл бүхий эрх зүйн тулгуур баримт бичиг юм. Уг хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих эрх бүхий Хороо нь төрийн болон ТББ, нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл оролцсон орон тооны бус 30 гишүүнтэй. "Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2009-2010 оны төлөвлөгөөнд нийт 49 зорилтын

хүрээнд 100 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд заалт тус бурийг чанд хэрэгжүүлэхэд төр, засгийн болон орон нутгийн байгууллагаас гадна ТББ, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог эрс сайжруулах шаардлагатай гэж үздэг

Монгол Улсад хүний эрхийн ноцтой зөрчлийн гаралт буурахгүй байна. Монгол улсын хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн асуудлуудад шүүхийн хараат бус байдалд заналхийлэх, цагдан хорих байгууллагуудын хүнд нөхцөл, нэр төр гутаах, гутгэх гэмт хэрэгтэй холбоотой зүйл заалт эрүүгийн хуульд хэвээр байгаа болон албан тушаалтуудын авлига, лесбиян, гей, бисексуал, трансжендер, интерсекс иргэдийн эсрэг заналхийлж, хүчирхийлэх болон хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэх зэрэг зөрчлүүд орж байна.

Эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн, эрх тэгш оролцоог хангах нь зөвхөн хүний эрхийн асуудал төдийгүй өргөн утгаараа тогтвортой хөгжил, ардчиллын үндэс суурь болдог. Улс орны түүх, соёлын онцлог, нийгэм-эдийн засгийн хөгжил, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зан байдлын ялгаа зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр нийгмийн амьдралын олон салбарт, тэр дундаа улс төрийн тавцанд жендерэйrin тэгш байдал хангагдахгүй байгаа нь статистик баримтаас харагддаг байна. Энэ байдал нь тэгш, хүртээмжтэй хөгжилд хүрэх гол саад бэрхшээлийн нэг болж байгаа тул ИУБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030”-д жендерэйrin тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охидыг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн зорилтуудыг тусгасан билээ.

Монгол Улсын улс төр дахь эмэгтэйчүүдийн манлайлал Азийн дунджаас доогуур байна. Монгол Улс эмэгтэй, эрэгтэй хүнд тэгш хандах үзэл санааг 1924, 1940, 1960, 1992 онд баталсан дервэн удаагийн Үндсэн хуульдаа тусгаж, мөн олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсон. 2012 оны сонгуулийн үр дүнгээр УИХ-ын нийт гишүүдийн 14.5 хувь нь эмэгтэйчүүд байсан 2016 оны сонгуулийн үр дүнгээр УИХ-ын нийт гишүүдийн 17.1 хувьд хурсэн. Энэ нь манай улсын хувьд түүхэн үзүүлэлт хэдий ч дэлхийн дундаж (2020 онд 24.9 хувь), Азийн дундаж (2020 онд 20.5 хувь)-аас доогуур хэвээр байна.

ИНБ-ийн эрх зүйн орчин дутагдалтай байна. Иргэний нийгэм, ТББ-ын одоогийн эрх зүйн орчин нэг талаар нийгмийн хэрэгцээ шаардлагаас хоцорч ИНБ-уудын өмнө тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэж чадахгүй негеэ талаар эрх зүйн шинэчлэлээс хоцорч, улмаар зохицуулалтын хувьд бусад хуулиудтай зөрчилдөхэд хүрсэн. Сүүлийн жилүүдэд батлагдсан зарим хууль тогтоомжид Засгийн газрын ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулахад ИНБ-ын үүргийг нэмэгдүүлэх зохицуулалт хийгдсэн. Гэвч хүчин төгөлдөр болоод удаагүй учир хуулийн хэрэгжилтийг хангахад хамтын хүчин чармайлт шаардлагатай байна.

5.3. Тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан

№	Агуулгын хүрээ	Асуудал	Шалтгаан
1	Тогтвортой засаглал	Эрх мэдэл хоорондын харилцан хяналт тэнцэл доголдсон	-Улсын Их Хурлын хяналтын механизм сул -Ерөнхийлөгчийн бүрэн эрх оновчтой бус -Үндсэн хуулийн цэцийн улс төрийн хамаарал
		Парламентын засаглал сонгодог утгаараа төлөвшеегүй	-Үндсэн хуулийн концепци, шинжлэх ухааны зүй тогтолыг гажуудулсан -Үндсэн хуулийн зохицуулалтыг практикт буруу тайлбарлаж хэрэглэх явдал нэмэгдсэн
		Засгийн газрын тогтвортой байдал	-Эрх мэдлийн тэнцвэргүй байдал -Эрх ашгийн эрэмбэ алдагдсан
		Шүүхийн бие даасан байдал хангалтгүй	-Бодлого боловсруулж төлөвлөхөд оролцоог нь хангадагтүй -Улс төрийн нелөөлөлд автдаг -Эдийн засгийн бие даасан байдал бүрэн хангагдаагүй
		Хариуцлага сул байдал	-Ес зүйн хариуцлага хүлээх соёл төлөвшеегүй -Хөндлөнгийн хяналт үр дүнтэй хэрэгждэгтүй -Эрх бүхий субъект хариуцлага хүлээлгэх чиг үүргээ хэрэгжүүлдэгтүй
		Хууль боловсруулалтын чанар муу	-Судалгаа, шинжилгээ хангалтгүй -Парламентын дотоод хяналт сул -Хууль санаачлах хүрээ хязгаарыг нарийн тогтоогоогүй -Үндсэн хуулийн үзэл санаанд бүрэн нийцүүлдэгтүй -Иргэд, олон нийтийн санаа бодлыг тусгадагтүй
		Чиг үүргийн давхардал	-Чиг үүргийн ялгаа зааг тодорхойгүй -Бүтэц оновчтой, уян хатан бус -Эрх мэдэл хэт төвлөрсөн
		Төрийн өмчит хуулийн эттээд үр ашиггүй	-Эдийн засаг дахь төрийн оролцоо, хүрээ хязгаарын талаарх нэгдсэн ойлголтгүй -Эрх зүйн орчиг, бүртгэл, хяналт сул -Удирдлагын томилгоо улс төрөөс хамаарлтай -Компанийн засаглал төлөвшеегүй -Алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг -Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлого зохицуулалт алдагдсан
		Босоо болон хэвтээ түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдаа сул	-Судалгаа, мэдээлэл хангалттай хийгдээгүй -Мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй
		Төлөвлөлт, төсвөлт хоорондоо уялддагтүй	-Төсвийн бодлогыг төлөвлөлттэй хольж хутгадаг -Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт хийгддэгтүй
		Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институутийн чадавх сул	-Бодлого боловсруулах хүний нөөц бүрдээгүй

			<ul style="list-style-type: none"> -Төлөвлөлтийн программ хангамж, ажиллах хүний нөөц дутмаг
		Сонгуулийн ирц хангалтгүй	<ul style="list-style-type: none"> -Сонгогчдын улс төрийн боловсрол бүрэн төлөвшөөгүй -Залуучуудын улс төрийн идэвх, оролцоо сул -Мэдээллийн хяналтгүй урсгал
		Сонгуулийн тогтолцоо нь төрийн үйл ажиллагааны тогтвортой байдалд сэргеөр нөлөөлж байна	<ul style="list-style-type: none"> -Эрх зүйн орчин бүрдээгүй -Үндэсний онцлогт суурилаагүй -Санхүүжилт
		Намын дотоод ардчилал сул	<ul style="list-style-type: none"> -Эрх зүйн орчин сул -Улс төрийн соёлыг намд төлөвшүүлээгүй -Хатуу гишүүнчлэлийн бодлого үйлчилдэг -Бодлогын нам болж төлөвшөөгүй
		Намын санхүүжилт ил тод бус, бүлэглэлийн нөлөөгөөр санхүүждэг	<ul style="list-style-type: none"> -Эрх зүйн зохицуулалт хангалтгүй -Хяналт тавих тогтолцоо сул -Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нь бүлэглэлийн нөлөөнд автах нөхцөлийг бүрдүүлж байна
2	Хүний эрхийн баталгаа	Хүний эрхийн зөрчил нэмэгдэж байна	<ul style="list-style-type: none"> -Хохирлыг барагдуулах, нөхөн телүүлэх механизм байхгүй -Хүний эрхийг хамгаалах чиглэлээр тэр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул, талуудын оролцоог бүрэн хангадагтүй -Хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй -Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарладаг -Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа хүний эрхэд суурилдагтүй -Албан хаагчдын хүний эрхийн ойлголт, суурь мэдлэгийн түвшин хангалтгүй
		Олон улсын хамтын ажиллагаа сул	<ul style="list-style-type: none"> -Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилт, тайлагналт хангалтгүй -Хэрэгжилтийг зохион байгуулах бие даасан бүтэц байхгүй
3	Төрийн алба	Төрийн албаны сахилга, хариуцлага алдагдсан	<ul style="list-style-type: none"> -Хууль дээдлэх зарчим алдагдсан -Чадахуйн зарчмыг хэрэгжүүлдэгтгүй -Албан хаагчийн мэдлэг, ур чадвар хангалтгүй -Хариуцлагын тогтолцоо оновчтой бус, ТАЗ-ийн мянлайлал сул -Албан хаагчийн захиргааны уламжлалт хандлага өөрчлөгдөөгүй -Хариуцлагатай албан хаагчийг дэмжих, зерчлээс урьдчилан сэргийлэх зохицуулалт дутагдалтай
		Ажлын гүйцэтгэл сул	<ul style="list-style-type: none"> -Албан хаагчийн ажлын ачаалал харилцан адилгүй -Улс төрийн нөлөөллөөс үүдсэн төрийн албаны тогтвортгүй байдал -Төрийн үйлчилгээнд тавих иргэд, олон нийтийн хяналт сул -Хүний нөөцийн бодлого алдагдсан -Төрийн үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжүүлэлт сул

			-Байгууллагын хувьд өөрчлөлтийн соёлыг төлөвшүүлзэгүй, албан хаагчийн энэ талаарх санал, санаачилгыг дэмждэгтүй
4	Цахим засаглал	Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээнд улсын нийт нутаг дэвсгэр бүрэн хамрагдаагүй	-Хөрөнгө оруулалт дутмаг -Эдийн засгийн үр өгөвж болгатай -Хүн амын нягтаршил бага
		Мэдээллийн аюулгүй байдлын түвшин хангалттай байна	-Үндэсний CERT төв (улсын хэмжээнд кибер халдлагыг илрүүлэх, хянах систем байхгүй) -Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, стратеги байхгүй -Мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ойлголт сул -Хөрөнгө оруулалт дутмаг -Хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй
		Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ашиглалт хангалттай байна. (ХҮР, ДАН, Нийтийн түлхүүрийн дэд бүтэц, e-Mongolia)	-Уялдаа холбоо муутай -Хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй -Цахим харилцааны талаарх нэгдсэн зохион байгуулалт байхгүй
5	Авлига	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг оновчтой нэвтрүүлэх	-Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим бодлого төлөвлөлт, стратеги байхгүй -Хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй
		Авлига, албан тушаалын гэмт хэргийн гаралт нэмэгдсэн	-Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хэмжээ хөнгөн, хэрэгжилт сул -Гэмт хэргийг шалган шийдвэрлэх чадавх сул, хууль сахиулах албан хаагчдын мэдлэг, мэргэшил хангалтгүй -Төрийн байгууллагын үйл ажиллагаа ил тод биш
6	Иргэний нийгмийн оролцоо	Төрийн байгууллагад авлигыг үл тэвчих соёл хэвшээгүй	-Төр хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналт сул -Шүгэл үзээгчийг хамгаалах эрх зүйн орчин байхгүй, соёл төлөвшөөгүй -Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа хангалтгүй
		Иргэний нийгмийн төлөвшил мүү	-Иргэний нийгмийг дэмжих эрх зүйн орчин сул -Төрийн байгууллагын хамтын ажиллагаа хангалтгүй -Төрийн оролцоо их -Санхүүжилтийн эх үүсвэргүй -Үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлдэгтүй

5.4. Зорилго, зорилт, үйл ажиллагаа

Хүн амын тогтвортой ёсөлт, зохистой бүтцийг бүрдүүлэх, Хүнд ээлтэй, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг дээшлүүлэх, Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилж, үр ашигийг сайжруулахад тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан, шийдвэрлэх арга замуудад үндэслэн 5 зорилго, 24 зорилт, 113 үйл ажиллагааг тодорхойлоод байна.

Зорилго 1. Төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт тэнцлийг хангана.

Энэхүү зорилгын хүрээнд хууль тогтоох засаглалыг төгөлдөржүүлж, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн шууд болон шууд бус оролцоог нэмэгдүүлж, ардчилсан сонгуулийн зарчимд бүрэн нийцсэн сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төрийн болон орон нутгийн чиг үүргийн уялдааг хангах, үндэсний аюулгүй байдлын хангах институцийн тогтолцоо, улс орны батлан хамгаалах тогтолцоог сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 5 зорилт, 31 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 1.1. Хууль тогтоох засаглалыг төгөлдөржүүлж, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн шууд болон шууд бус оролцоог нэмэгдүүлж, ардчилсан сонгуулийн зарчимд бүрэн нийцсэн сонгуулийн тогтолцоог бүрдүүлнэ.

1.1.1	Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах механизмуудын хэрэгжилтийг тогтмол үнэлж, оролцооны шинэлэг арга хэрэгслүүдийг нэвтрүүлнэ.
1.1.2	Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлнэ.
1.1.3	Монгол Улсын Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог болно.
1.1.4	Улсын Их Хурлын сонгуулийг холимог системээр явуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
1.1.5	Сонгуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн үед санал хураах үйл явцын аюулгүй байдлыг хангаж, зөрчил, маргаангүй сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
1.1.6	Сонгуулийн байгууллагад нэр дэвшүүлэх, томилох үйл ажиллагааг хараат бус, нээлттэйгээр явуулж, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцөөр хангах нөхцөлийг сайжруулна.

Зорилт 1.2. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.

1.2.1	Шүүгчийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх хэрэгцээнд тулгуурлан шүүгчийн орон тоог хүртээмжтэй, хүрэлцэхүйц тогтооно.
1.2.2	Шүүгчийн хараат бус байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөн оролцох эрх зүйн орчныг сайжруулна.
1.2.3	Шүүгчийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайнлас оролцох боломжийг хангах цахим шилжилтийг үе шаттай зохион байгуулна
1.2.4	Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлэх замаар шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах нөхцөл бүрдүүлнэ.
1.2.5	Шүүн таслах ажиллагааны урсгал зардлын санхүүжилтийн бодитой, үр ашигтай тогтолцоог нэвтрүүлж шүүхийн эдийн засгийн баталгааг хангана.
1.2.6	Хуульчдаас хууль зүйн мэдлэг, чадвар, ёс зүй, зан төлөв бүхий цогц чадамжтай шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулалтын нээлттэй, ил тод, иргэдийн мэдээлэл өгөх, оролцох боломжийг нэмэгдүүлэх оновчтой тогтолцоог сайжруулна

1.2.7	Шүүхэд хандах иргэний эрхийг баталгаатай эдлүүлэх шүүхийн тогтолцоог нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоо зэрэг хүчин зүйлийг харгалзан бүрдүүлнэ.
1.2.8	Шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх, шүүхээр үйлчилүүлэгчийн эрүүл, аюулгүй байдлыг хангах стандарт бүхий шүүхийн байр, шүүх хуралдааны танхим, техник хэрэгслээр хангаж хүн амд хүргэх шүүхийн үйлчилгээний орчин, нөхцөлийг сайжруулна.
1.2.9	Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн шийдвэрийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах, шүүхийн практикийг хөгжүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад мэдээлэл солилцох, иргэд шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд шүүхийн практикийг таниулах, мэдээлэхэд чиглэсэн цахим санд шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацаанд байршуулна.
1.2.10	Шүүхэд иргэдийн итгэх итгэлийг тогтмол судлах хэрэглэгчийн үнэлгээний судалгаа хийх тогтолцоо бүрдүүлнэ.
1.2.11	Эрх зүйн ач холбогдолтой, онцлох шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэж олон нийтэд мэдээлэх замаар эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаарх иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.
1.2.12	Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааны нээлттэй байдлыг хангах, шүүх хурлын танхимын хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим технологид тулгуурласан шүүхийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
1.2.13	Шүүх цахимаар нэхэмжлэл, хүсэлт хүлээн авах, хэргийн материалтай цахимаар танилцах, шүүх хооронд хаваст хэргийг цахимаар илгээх зэргээр шүүн таслах ажиллагааг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримтыг үнэлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
1.2.14	Шүүхийн захиргааны чиг үүргийн онцлогт тохирсон, цогц чадамж бүхий мэргэшсэн хүний неецийн тогтолцоог бүрдүүлнэ.
1.2.15	Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүхийн харьяанд шилжүүлнэ.
Зорилт 1.3. Нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмын хүрээнд төрийн болон орон нутгийн чиг үүргийн уялдааг хангана.	
1.3.1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, зохион байгуулалтыг бусчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх, оршин суугч, здийн засгийн чадавх, газар нутгийн алслалтын шалгуурыг хэмжээ, тоогоор нарийвчлан тодорхойлох замаар здийн засгийн хувьд бие даан хөгжих боломжийг хангахуйц засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарилалтыг үе шаттай хийж, сумдын тоог цеөруулнэ
1.3.2	Нийслэлийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зохицуулалтаас гаргаж, бие даан хөгжих эрх зүйн орчныг улам төгөлдөржүүлнэ.
Зорилт 1.4. Үндэсний аюулгүй байдлын хангах институцийн тогтолцоо, чиг үүргийг боловсронгуй болгоно.	
1.4.1	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг бүрдүүлж байгаа институцийн эрх хэмжээ, зөвлөлөөр хэлэлцэх асуудлын хүрээ хязгаар, нөхцөл, шалгуурыг нарийвчлан тодорхойлж, харилцан тэнцэл бүхий бурэн эрх, чиг үүргийн тогтолцоог бүрдүүлнэ.
1.4.2	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, Засгийн газрын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргыг Ерөнхий сайд нэр дэвшүүлснээр Зөвлөл томилж, чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
Зорилт 1.5. Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.	
1.5.1	Төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлнэ.
1.5.2	Мэргэжлийн цэрэгт сууринласан, орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.
1.5.3	Нэгдсэн удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бэхжүүлнэ.

1.5.4	Хил хамгаалах тогтолцоог орчин үеийн шаардлагад нийцүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно
Зорилт 1.6. Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог оновчтой болгоно.	
1.6.1	Үндсэн хуулийн цэцийг хүний үндсэн эрх зерчигдсөн тохиолдлыг хянахад онцгой үүрэгтэй институт болгоно.
1.6.2	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг шүүх эсхул Үндсэн хуулийн цэц хянах тогтолцоог судалж шийдвэрлэнэ.

Зорилго 2. Эрх зүйт төрийг төлөвшүүлж, хүний эрхийн баталгааг хангана.

Энэхүү зорилгын хүрээнд хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, Эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн эрх зүйн шинэчлэл, хуулийн нэгдмэл, тогтвортой байдлыг хангах, иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 5 зорилт, 28 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 2.1. Хүний эрхийг хангах олон улсын сайн туршлага нэвтрүүлж, хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.	
2.1.1	Хүний эрхийг хангах олон улсын механизмыг ашиглаж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
2.1.2	Хүний эрх зерчигдөхөөс урьдчилан сэргийлж, зерчигдсөн эрхийг сэргээн здлүүлэх хохирол нөхөн барагдуулах механизмыг боловсронгуй болгоно.
2.1.3	Хүний эрхийн мэдлэг, хандлагыг төрийн удирдах албан тушаалтны томилгоонд болон төрийн албан хаагчийн ур чадварын үнэлэх шалгуурын гол үзүүлэлт болгоно
2.1.4	ХЭҮК-ыг Парисын зарчимд бүрэн нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага болгож бэхжүүлнэ.
2.1.5	НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн зарчмыг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлнэ.
2.1.6	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлыг үнэлэх индекс боловсруулж, жил бүр гарч буй өөрчлөлтийг хэмжих байдлаар ахиц дэвшил гаргана.
2.1.7	Иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг аливаа хэлбэрээр зерчихөөс хамгаалахтай холбоотой зарчмыг тодорхойлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
2.1.8	Иргэд үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, бусдын эрх, эрх чөлөөг алдагдуулахаас бусад тохиолдолд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах баталгааг нэмэгдүүлнэ.
2.1.9	Хэвлэн нийтлэх эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ
2.1.10	Иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрчид, нийгмийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааны талаар өөрийн санаа бодол, шүүмж, зэмлэлээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарласан хууль тогтоомж, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын хүний эрхийн стандарт, сайн туршлагад нийцүүлэн боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
2.1.11	Бүх нийтийн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг баталгаажуулж, жагсаал, цуглаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хуулийн хүрээнд, олон улсын (НҮБ) хүний эрхийн стандартад нийцүүлж, мөрдүүлнэ.
2.1.12	Өмчлөх эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл журмаар хязгаарлах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
2.1.13	Иргэд, аж ахуй нэгж, байгууллагыг царай таних, тагнах, чагнах зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглах хүрээ, хязгаарыг тогтооно
Зорилт 2.2. Эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн эрх зүйн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлнэ.	
2.2.1	Хувийн эрх зүйн чиглэлээр дагнасан судалгааны институцийг бий болгож, төрийн бодлогоор дэмжинэ

2.2.2	Олон улсын хувийн эрх зүйн асуудлаар олон улсын байгууллага, бусад улстай хамтын ажиллагааг сайжруулна.
2.2.3	Иргэний хэргийн шүүхийн шүүгч, хуульч, судлаачдыг үе шаттай мэргэшүүлнэ.
2.2.4	Эрх зүйч бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хетелбөрт хувийн эрх зүйн хичээлийн багц цагийн эзлэх хувийг нэмэгдүүлж Монгол Улсад здийн засаг, бизнесийн эрх зүйн чиглэлээрх хуульчийн тоог нэмэгдүүлнэ.

Зорилт 2.3. Хууль боловсруулах, батлах, хэрэгжүүлэх процессыг сайжруулж, хуулийн нэгдмэл, тогтвортой байдлыг хангана.

2.3.1	Хуулийн төрлөөс хамаарч хууль батлах квотыг нарийвчлан тогтооно.
2.3.2	Улсын Их Хурлын таваас доошгүй гишүүн нэгдэж хууль санаачлах эрхийг хэрэгжүүлдэг байх зохицуулалтыг бий болгоно
2.3.3	Хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө эрх ашиг нь хөндөгдсөн этгээдүүд болон олон нийтээр заавал хэлэлцүүлдэг байна.
2.3.4	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон хуулийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалд жендерийн тэгш эрх, хүний эрхийг хангах шалгуурыг тусгана.
2.3.5	Монгол Улсын олон улсын гэрээний орчуулгыг нягталж, дахин баталгаажуулж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тогтмол, бурэн байршуулна.

Зорилт 2.4. Иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлнэ.

2.4.1	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх үр дүнтэй тогтолцоог бурдуулнэ.
2.4.2	Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бэхжүүлж хөгжүүлнэ.
2.4.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх ажлыг тогтмол хийх тогтолцоог бий болгох
	Зорилт 2.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй тогтолцоог бурдуулнэ.
2.5.1	Мөрдөх албыг байгуулна.
2.5.2	Гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх үйл ажиллагааг сайжруулна.
2.5.3	Хууль сахиулах, мөрдөн шалгах ажиллагаа болон гүйцэтгэх ажлын явцад хүний эрхийг хангах, хамгаалах, хяналтын тогтолцоог сайжруулах, алба хаагчдын мэдлэг хандлагыг өөрчлөх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилго 3. Мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд төрийн үйлчилгээний орон зай, цаг хугацааны хамаарлыг бууруулж, тэгш хүртээмжтэй хүргэх, цахим шилжилтийг эрчимжүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах, төрийн хүнд суртлыг арилгах, , ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит компанийн үр ашиг, засаглалыг сайжруулах, зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 8 зорилт, 25 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 3.1. Төрийн үйлчилгээний орон зай, цаг хугацааны хамаарлыг бууруулж, тэгш хүртээмжтэй хүргэнэ.

3.1.1	Цахим засаглалын дижитал дэд бүтцийг бий болгоно.
3.1.2	Нийтийн мэдээллийг олон улсын (Европын холбоо) сайн туршлагад үндэслэн нээлттэй өгөгдөл болгож, төрийн үйлчилгээний ил тод байдал, чанар, үр нөлөөг сайжруулна.

3.1.3	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгож, бодлогын судалгаа хийх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.
Зорилт 3.2. Төрийн үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.	
3.2.1	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.
3.2.2	Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан тэр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.
3.2.3	Цахим засаглалын дижитал дэд бүтцийг бий болгох зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны үндсэн болон дэмжих системийг хөгжүүлнэ.
Зорилт 3.3. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.	
3.3.1	Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, ажил үүргийн давхцалыг арилгана.
3.3.2	Үйл Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагад шилжүүлнэ.
Зорилт 3.4. Төрийн хяналт, шалгалт, хариуцлагын тогтолцоог сайжруулж, төрийн хүнд суртлыг арилгана.	
3.4.1	Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлнэ.
3.4.2	Төлөвлөгөөт хяналт, шалгалтыг бууруулж, төрийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилж хэрэгжүүлэх, зөвлөн туслах хэв шинжтэй болгоно.
3.4.3	Төрийн зарим хяналт, шалгалтыг тэр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх тогтолцоонд шилжинэ.
Зорилт 3.5. Чадахуйн зарчимд суурилсан төрийн албаны тогтвортой байдлыг ханган, төрийн албан хаагчдын цалин хэлс, нийгмийн баталгааны тогтолцоог боловсронгуй болгож, ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.	
3.5.1	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангаттана.
3.5.2	Үр дүн, гүйцэтгэлд суурилсан цалин хэлс, урамшууллын тогтолцоог үе шаттайгаар бий болгоно.
3.5.3	Төрийн албан хаагчийн тоог үе шаттайгаар бууруулж, цомхон чадварлаг төрийн албыг бүрдүүлнэ
3.5.4	Мэргэшсэн, чадварлаг төрийн албан хаагчдыг улс төрийн нөлөөллөөс ангид ажил үүргээ гүйцэтгэх, шатлан дэвших тогтолцоо нь иж бүрэн, нээлттэй тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ
Зорилт 3.6. Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангаж, манлайллыг нэмэгдүүлнэ.	
3.6.1	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс тэр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.

3.6.2	Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.
Зорилт 3.7. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үр ашиг, засаглалыг сайжруулж, ил тод байдлыг хангана.	
3.7.1	Төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулж болох салбар, чиглэл, зорилгыг тодорхой болгож, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
3.7.2	Төрийн өмчит компанийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үнэлгээний болон хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгоно.
3.7.3	Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
3.7.4	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор бүрэлдэхүүнд хараат бус гишүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, жендерийн тэгш байдал хангаж улс төрийн нелөөллөөс ангид, хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт бий болгоно.
3.7.5	Төрийн өмчит компанийн тайлгатнал, ил тод байдлын шалгуурыг олон улсын стандарт, сайн туршлагад үндэслэн батлан мөрдүүлнэ.
Зорилт 3.8. Өндөр чанартай, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан, нарийн задаргаатай тоо мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нотолгоонд сууриссан бодлого, шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор үндэсний статистикийн системийг бэхжүүлнэ.	
3.8.1	Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн чадавхыг нэмэгдүүлнэ.
3.8.2	Төрийн байгууллагууд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан албан ёсны статистикийг болон захиргааны тоо мэдээлэл болон жендэр статистикийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
3.8.3	Их өгөгдөл сууриссан төрийн нэгдсэн мэдээллийн санг байгуулна.

Зорилго 4. Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.

Энэхүү зорилгын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгаж, хэрэгжилтийг сайжруулах, авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг дээшлүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн З зорилт, 23 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 4.1. Авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгаж, хэрэгжилтийг сайжруулна.	
4.1.1	Авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
4.1.2	Хууль бусаар олж авсан хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө буцаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг таслан зогсооход чиглэсэн албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд тавих бүртгэл-хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.
4.1.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэх, хөрөнгө буцаахтай холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
4.1.4	Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бурдуулнэ.

4.1.5	Мөнгө угаах, терроризмтой тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
4.1.6	Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтны улс, нийгэмд учруулсан мөнгөн хохирлыг тооцож, нөхөн төлүүлэх механизмыг сайжруулна.
4.1.7	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
4.1.8	Олборлох салбарын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно
4.1.9	Төсөв санхүү, бүртгэл, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааны шударга, ил тод байдалд итгэх олон нийтийн илтгэлийг бэжүүлэхэд нээлттэй өгөгдлийн хуртээмжийг сайжруулах арга хэмжээ авна.
Зорилт 4.2. Авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.	
4.2.1	Олон нийтийн авлигын талаарх боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, авлигын шалтгаан, нөхцөл, хор уршгийг арилгах, ойлгуулахад чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээг олон нийт болон зорилтолт бүлэгт чиглүүлэн нийгэм, сургууль, гэр бүлээр дамжуулан криминологийн судалгаанд түшиглэн олон нийтийн ухамсарт нөлөөлөхүйц хэлбэрээр зохион байгуулна.
4.2.2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх аргачлалыг нэвтрүүлнэ.
4.2.3	Хүүхэд, залууст шударга, зөв байх үзэл, хандлага, авлигыг үл тэвчих үзэл ухамсыг төлөвшүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулгыг монгол хүний ахуй, соёл, зан төлөвт нийцүүлэн бүх шатны боловсролын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.
4.2.4	Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зерчлийг үл тэвчих сэтгэлгээ, ёс зүй, шударга ёсны тогтолцоог эрхэмлэсэн соёлыг хэвшүүлнэ.
4.2.5	Төрийн үйлчилгээний шударга, хариуцлагатай, ил тод байдлыг хангах, авлигын бүх хэлбэрийг таслан зогсооход чиглэсэн хяналтыг сайжруулж, нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ
Зорилт 4.3. Авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг дээшлүүлнэ.	
4.3.1	Төрийн бүх шатны байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг таслан зогсоох, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө хэрэгжүүлж, зохион байгуулалтыг сайжруулан, авлигын эсрэг үйл ажиллагааны хяналт, үнэлгээний системийг бий болгож, үр дүнг Засгийн газрын түвшинд хэлэлцүүлэн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хэвшүүлнэ.
4.3.2	Монгол Улсын авлигын түвшин, цар хүрээ, шалтгаан, нөхцөл, хандлагыг судлан тогтоох, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт өгөх судалгааг нийгмийн бүх давхарга, салбарыг хамруулан явуулж, үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулан судалгаа шинжилгээний ажлын үр нөлөөг сайжруулна.
4.3.3	Монгол Улс дахь Авлигад нөлөөлж буй хүчин зүйлийн динамик загварын шинжилгээг хөгжүүлж, авлигын түвшинд нөлөөлөх зерэг хүчин зүйлсийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3.4	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах механизмыг тодорхой болгох, иргэд, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын байгууллагын чадавхыг сайжруулж, төлевшүүлэх, хамтыг ажиллагааг өргөжүүлэх, хууль, шүүхийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
4.3.5	Шүүх, прокурор, авлигатай тэмцэх байгууллагын авлига, албан тушаалын гэмт хэргийг шалган шийдвэрлэх чадавхыг бэхжүүлж, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
4.3.6	Шүүх, прокурор, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ.
4.3.7	Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авна.
4.3.8	Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон ЭЗХАХБ-ын сүлжээний Авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, GRACE, GRECO санаачилгын үйл ажиллагаанд оролцох зэргээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
4.3.9	Улс төрийн намын санхүүжилтийг тогтолцоог шинэчлэн, ил тод байдал, хяналт, хариуцлагатай бодлогын намууд бүхий олон намын систем төлевших эрх зүйн орчныг бүрдүүлнэ

Зорилго 5. Төреес иргэний нийгмийн хөгжил, хамтын ажиллагаа, оролцоог хангах замаар бүлгийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах, хэрэгжүүлэх цогц бодлого, оновчтой механизмтай байна.

Энэхүү зорилгын хүрээнд төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, иргэний нийгмийн байгууллагын институцийн төлөвшлийг дэмжиж, улс төрийн нэлөөллөөс ангид тогтвортой, үр дүнтэй, чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 2 зорилт, 7 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 5.1. Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаагаар дамжин төрийн бодлогод нийгмийн оролцогчдын олон талт сонирхлыг тусгах, төрийн үйл ажиллагаанд оролцоог тодорхой болгох, нийгэмд өргөн хүрээний зөвшилцэл бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.1	Иргэний нийгмийн байгууллагын олон улсын чиг хандлагад тулгуурласан эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцоог хангана.
5.1.2	Хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хетелбэрийн хэрэгжилт болон төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах тогтолцоонд засаглал болон төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны узүүлэлтийг тусгана.

Зорилт 5.2. Иргэний нийгмийн байгууллагын институцийн төлөвшлийг дэмжиж, улс төрийн нэлөөллөөс ангид тогтвортой, үр дүнтэй, чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.2.1	Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.
5.2.2	Иргэний нийгмийн байгууллагын тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүгийн олон тулгуурт эх үүсвэрийг баталгаажуулсан тогтолцоог нэвтрүүлнэ.

5.2.3	Нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгон нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн, зөрчигдэж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд төрийн бус байгууллага болон сонирхогч аливаа этгээд захиргааны болон иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг бүрдүүлнэ.
5.2.4	Төрийн байгууллага нь иргэний нийгмийн төлөөлөлтэй тогтоосон санхүүгийн болон бусад аливаа харилцаанаас үл хамааран хараат бус, эрх чөлөөт байдлыг ханган ажиллахыг хууль тогтоомжоор баталгаажуулна.
5.2.5	Иргэний нийгмийн байгууллагыг бүртгэлгүй гэсэн үндэслэлээр төрийн үйл хэрэгт оролцох, үйл ажиллагаа явуулах, оролцох эрхийг хязгаарлахгүй байх баталгааг хангана

5.5. Хүрэх үр дүн

Засаглалын зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Хууль тогтоох засаглалыг төгөлдөржүүлж, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн шууд болон шууд бус оролцоог нэмэгдүүлж, ардчилсан сонгуулийн зарчимд бүрэн нийцсэн сонгуулийн тогтолцоог бүрдүүлнэ.
- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.
- Нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмын хүрээнд төрийн болон орон нутгийн чиг үүргийн уялдааг хангана.
- Үндэсний аюулгүй байдлын хангах институцийн тогтолцоо, чиг үүргийг боловсронгуй болгоно.
- Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.
- Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Эрх зүйт төрийг төлөвшүүлж, хүний эрхийн баталгааг хангана.
- Эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн эрх зүйн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлнэ.
- Хууль боловсруулах, батлах, хэрэгжүүлэх процессыг сайжруулж, хуулийн нэгдмэл, тогтвортой байдлыг хангана.
- Иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлнэ.
- Гэмт хэрэг, зерчлеөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлнэ.
- Мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.
- Төрийн үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.
- Төрийн хяналт, шалгалт, хариуцлагын тогтолцоог сайжруулж, төрийн хүнд суртлыг арилгана.
- Чадахуйн зарчимд сууринсан төрийн албаны тогтвортой байдлыг ханган, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны тогтолцоог боловсронгуй болгож, ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.
- Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангаж, манлайллыг нэмэгдүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчтөй компанийн үр ашиг, засаглалыг сайжруулж, ил тод байдлыг хангана.
- Өндөр чанартай, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан, нарийн задаргаатай тоо мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нотолгоонд сууринсан бодлого, шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор үндэсний статистикийн системийг бэхжүүлнэ.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгаж, хэрэгжилтийг сайжруулна.
- Авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.
- Авлигаас урьдчилан сэргийлэх тэр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг дээшлүүлнэ.
- Тэр, иргэний нийгмийн хамтын ажиллагаагаар дамжин төрийн бодлогод нийгмийн оролцогчдын олон талт сонирхлыг тусгах, төрийн үйл ажиллагаанд оролцох оролцоог тодорхой болгох, нийгэмд өргөн хүрээний зөвшилцэл бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.
- Иргэний нийгмийн байгууллагын институцийн төлөвшлийг дэмжиж, улс төрийн нөлөөллөөс ангид тогтвортой, үр дүнтэй, чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

БҮЛЭГ 6. БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

6.1. Танилцуулга

Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг орон зайн хөгжил, бус нутгийн хөгжил, Улаанбаатар хотын хөгжил гэсэн үндсэн 3 агуулгын хүрээнд боловсруулав. Дээрх турван агуулгын хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогыг дунд хугацааны дараах "барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалт, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, хүнд үйлдвэрлэл, уул уурхай, олборлох үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, соёлын үйлдвэрлэл-үйлчилгээ, эрчим хүч, инженерийн дэд бүтэц, тээврийн дэд бүтэц, мэдээлэл харилцаа холбоо" салбаруудын асуудлыг орон зайн эдийн засгийн ёселт, хөгжлийн төвийн онолын хандлагаар боловсруулаад байна.

Бус нутаг нь тухайн нутаг дэвсгэрийн өөр хоорондоо харилцан ижил шинжүүдийг агуулсан бодлого, төлөвлөлтийн нэгж юм. Бус нутаг буюу "Бүсийн шинжлэх ухаан" гэсэн нэр томьёог анх АНУ-ын эдийн засагч Уолтер Айзард хэрэглэж тодорхойлолтыг нь дэвшүүлсэн.

Хүснэгт 13. Бус нутгийн тодорхойлолт

№	Эх сурвалж	Тодорхойлолт	Хэв шинж	Нийтлэг хэв шинж
1	Монгол хэлний их тайлбар толь	Дэлхийн бөмбөрцгийн өргөргүүдийн хоорондох цаг уурын ямар нэг зохих зуравс болох хэсэг газар, цаг уур, хөрс ургамлын ижил төсөөтэй газар, газар зүйн байршилаар хуваасан нь	Ижил төсөөтэй газар, газар зүйн байршилаар хуваасан нь	
2	Merriam-webster	: a broad geographic area distinguished by similar features	Газарзүйн бус, хуваагдсан, ижил шинжүүд	
3	John H. Dunning (2000) "Regions, Globalization, and the Knowledge-Based Economy",	Макро бус бол уламжлалт буюу улс терийн хувьд тодорхойлсон хэд хэдэн бус нутгийг хамардаг геополитикийн дэд хэсэг юм. Улс орны хувьд утга нь харилцан адилгүй байж болох бөгөөд нийтлэг гарал үүсэл нь макро бүсийн хүрээнд соёл, эдийн засаг, түүхэн эсвэл нийгмийн ижил төстэй шинж чанартай байдаг.	Макро бүсийн хүрээнд соёл, эдийн засаг, түүхэн эсвэл нийгмийн ижил төстэй шинж чанартай байдаг	Өөр хоорондоо харилцан ижил шинжүүдийг агуулсан бодлого, төлөвлөлтийн нэгж
4	Харвардын их сургуулийн проф. Ж.Грае	Бус нутаг нь тодорхой шинж чанараар бусдаас ялгагдах нутаг дэвсгэрийн хэсэг юм	Бусдаас ялгагдах нутаг дэвсгэрт /гадна талдаа бусдаас ялгарч дотоод талдаа ижил байдаг/	
5		Бус нутаг нь байгаль, аж ахуй, нийгэм эдийн засгийн нутаг дэвсгэрийн систем бөгөөд тухайн системийг бурдүүлэг хүчин зүйлсийн харилцан нөлөөнд бий болдог бодлого, төлөвлөлтийн нэгж юм.	Бодлого, төлөвлөлтийн нэгж	

6	Д.Базаргүр (2003)	<p>Нийгэм эдийн засгийн газарзүйн шинжлэх ухаанд "орон" гэдэг категори нь өөрөө орон гэсэн утгаараа З хэмжээст "нутаг" (бүс), "зай" гэдэг категорийг "зам" гэсэн явцуу утгаар ойлгож, цаашдаа дэд бүтэц, үйлдвэр бүхий хот суурин, тэдгээрийг холбосон зам харилцаа бүхий цогцолбор шинжтэй нийгэм эдийн засгийн "тэнхлэг" гэдэг ухагдахуун болно.</p>	<p>Цогцолбор шинжтэй нийгэм эдийн засгийн "тэнхлэг" гэдэг ухагдахуун болно.</p>	
---	-------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------	--

Дээрх дүн шинжилгээний матрицын үр дүнд бус нутаг нь “Тухайн нутаг дэвсгэрийн өөр хоорондоо харилцан ижил шинжүүдийг агуулсан бодлого, төлөвлөлтийн нэгж” хэмээн тодорхойлогдож байна. Иймд бодлого боловсруулагч нар тухайн орон нутгийн нөөцед тулгуурлан харилцан уялдаатай төлөвлөлт хийх нь дунд хугацааны бодлогын баримт бичгийн хамгийн чухал ойлголт болж байна. Салбарын бодлогын нэгдсэн бөгөөд уялдаатай төлөвлөлтийг орон зайн-эдийн засгийн онолыг үндэслэн хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд түшиглэн боловсруулах нь “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн эрхэм зорилго юм.

“Бус нутгийн төлөвлөлт гэдэг нь салбарын бодлогуудыг орон зайн эдийн засгийн хувьд нэгтгэн оновчтой зохицуулах үйл ажиллагаа юм.”


Бүсийн хөгжил гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр бөгөөд түүний орон зайн буюу З хэмжээст орших обьектууд хамаарах тул нийгэм, эдийн засгийн өргөн хүрээний ойлголт юм. Бүсийн хөгжлийг хэмжихдээ “Орон нутгийн хөгжлийн индекс” болон “Хотын хөгжлийн үзүүлэлт”-ээр голчлон хэмжих бөгөөд дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үздэг. Үүнд:

Хүснэгт 14. Орон нутгийн хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлт

№	Бүлэг	Шалгуур үзүүлэлт
1	Боловсрол	Сумын 1-5 ангиid сурах ёстой хүүхдийн хамрагдалтын хувь
		1 багшид ногдох сурагчдын тоо
		Сургуулийн ээлжийн кoeffициент
		1 хүүхдэд ногдох дотуур байрны орны тоо
		Сургуулийн барилгын чанар
		Дотуур байрны барилгын чанар
		Цэцэрлэгийн хүчин чадал ба хүүхдийн харьцаа
		Цэцэрлэгийн 1 үндсэн багшид ногдох хүүхдийн тоо
		Цэцэрлэгийн барилгын чанар
2	Эрүүл мэнд	Соёлын төвийн барилгын чанар
		Эмнэлгийн барилгын чанар
		Нэг их эмчид ногдох хүний тоо
		Нэг сувилагчид ногдох хүний тоо
		10000 хүнд ногдох зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барсан хүний тоо
		10000 хүнд ногдох хавдраар нас барсан хүний тоо
3	Эдийн засаг	0-4 насны хүн амын нас бааралтын дундаж түвшин
		1000 хүнд ногдох зочид буудлын орны тоо (зөвхөн ХХК)
		Ахуйн үйлчилгээний төрлийн тоо
		1000 хүнд ногдох НДШ төлж байгаа хувийн хэвшлийн ажилчдын тоо
		1000 хүнд ногдох 15-64 насны цэвэр шилжин ирэгсдийн тоо

		1 хүнд ногдох сумын нийт татвар төлөгчдөөс сум, аймаг, улсын төсөвт төвлөрүүлсэн татварын хэмжээ /сая төгрөг/
		1 хүнд ногдох хадгаламжийн үлдэгдэл (сая төгрөг)
		1 хүнд ногдох зээлийн үлдэгдэл (сая төгрөг)
4	Байгаль орчин	Бэлчээрийн чанар (нэхэн сэргэх хугацаагаар)
		Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдэрсэн газрын хэмжээ (%)
5	Бусад	1000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо
		Нутгийн удирдлагын ордон, барилгын үнэлгээ
		Төрийн байгууллагын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон хувь
		Сумын төвийн өрхийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон хувь
		Төрийн байгууллагын цахилгаан эрчим хүчиний төвлөрсөн системд холбогдсон хувь
		Сумын төвийн өрхийн цахилгаан эрчим хүчиний төвлөрсөн системд холбогдсон хувь
		Төрийн байгууллагын цэвэр ус хангамж, ариутгах шугам сүлжээнд холбогдсон хувь
		Сумын төвийн өрхийн цэвэр ус хангамж, ариутгах шугам сүлжээнд холбогдсон хувь

Зураг 4242. Орон нутгийн хөгжлийн индекс, 2020



* Орон нутгийн хөгжлийн индексийн дундаж, 2020 он

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам


Хүснэгт 2-т харуулсан 5 бүлгийн 34 шалгуур үзүүлэлттэй орон нутгийн хөгжлийн индексээр (0.524) 21 аймгийг хэмжихэд дунджаас дээгүүр 11 аймаг, дунджаас доогуур 10 аймаг байна. Өмнөговь аймаг хамгийн өндөр буюу 0.658, Ховд аймаг хамгийн бага буюу 0.481 тус тус индекстэй байна. Иймд тухайн орон нутагт аль нэг шалгуур үзүүлэлт доогуур байгаа хүчин зүйлийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 15. Хотын хөгжлийн үзүүлэлтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт
1	Хүрээлэн байгаа орчин
2	Дэд бүтэц
3	Амьжиргааны зохистой түвшин

4	Боловсрол
5	Эрүүл мэнд
6	Соёл урлагийн үйлчилгээ
7	Хувь хүний аюулгүй байдал
8	Засаглалын индексүүд

Зураг 4343. Хотын хөгжлийн үзүүлэлт, 2020 он



Эх сурвалж: Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар


2020 оны байдлаар Хотын хөгжлийн 8 шалгуур үзүүлэлтийн индексийг дээрх байдлаар харуулав. Үүнээс дэд бүтэц 0.4534, хүрээлэн буй орчин 0.4595 буюу хамгийн бага индекстэй байна. Дээрх үр дүнг үе шаттайгаар нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч, бодлогын баримт бичигт тусгах шаардлагатай байна.

6.2. Бүсийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улс нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ дэлхийд 19 дүгээр байранд ордог. Монгол улс засаг захиргааны хувьд 21 аймаг, нийслэлд, аймаг нь сумдад, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдана. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ зийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулдаг.

Эдийн засгийн потенциалын хязгаарлагдмал цаг үед хамгийн оновчтой байршил, салбар, төсөл хөтөлбөрийг харилцан уялдаатай байдлаар, цогцоор төлөвлөх шаардлагатай байна. Өргөн уудам газар нутагтай, цөөн хүн амтай, дэд бүтцийн хөгжил сул, хөрөнгө оруулалтын хэмжээ хязгаарлагдмал цаг үед бид хамгийн оновчтой байршил, салбар, төсөл хөтөлбөрийг харилцан уялдаатай байдлаар, цогцоор нь эхний эзлжид хэрэгжүүлж байж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Бүх салбар, аймаг, сумдад тэнцүү хуваах зарчмаар хөрөнгө оруулалтаа хуваарилах нь үр ашиггүй зардал болоод байна. Иймд хөгжлийн ирээдүйтэй хот, сууриньг тодорхойлж улсын төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт, төсөл, хөтөлбөрийг оновчлох нь зийн засгийн хөгжлийг дэмжих хурдасгүүр болоод байна.

Зураг 4444. Монгол Улсын зийн засгийн микро өсөлтийн төв



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

“Хот”-ын статусыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэхгүй байснаар засаглалын чиг үүргийн давхардал үүсэж, хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын хурдацтай шилжилт хөдөлгөөн явагдаж байна. Үүний нөлөөгөөр хотжилтын түвшин 1950 оноос хурдацтай өсөж, 2020 оны байдлаар 68.7 хувьд хүрч дэлхийн дунджаас 10 хувиар илүү гарснаар Европын суурин соёл иргэншилтэй Унгар, Итали зэрэг орноос илүү гараад байна. Хүн амын өсөлтийн хэтийн тооцооноос үзвэл 2021-2040 онд хүн амын өсөлтийн жилийн дундаж хувь тогтвортой түвшинд буюу 1.7-1.9 хувь байж, улсын нийт хүн ам 2040 онд 4.6 сая, нийслэлийн хүн ам 2.1 сая, харин хөдөөгийн хүн ам тогтвортой буюу 1.0 сая орчимд хүрч өсөхөөр байна. Харин хүн

амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн хандлагыг авч үзвэл Монгол улсын хүн амын залуужсан бүтэцтэй буюу 2020-2040aad он хүртэл аажмаар өөрчлөгдсөөр дараагийн 20 жилд хөгшрэлийн бүтэцтэй болохыг судлаачид тооцоолжээ.

Энэ үед нийгмийн халамж, тэтгэвэр авагчид эрс нэмэгдэж эхлэх, хот байгуулалтад ахмад настны хэрэгцээ шаардлагыг тусгаж төлөвлөх зэргээр одооноос анхаарч стратегийн бодлогыг боловсруулах шаардлагатай юм. Өнгөрсөн зуунд хөдөөгөөс хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн бүхий хотжилтын эрин үе байсан бол ирэх 20-30 жилд тогтвортой хот байгуулалт, мэдээллийн технологи, ухаалаг төлөвлөлт бүхий уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, сэргэн хөгжих чадавх бүхий тогтвортой хот байгуулалтыг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байгааг харуулж байна.

Хүснэгт 16. Хүн амын нутапшилт суурьшлын даац, багтаамжийн үнэлгээ

№	Аймаг	Нийт нутаг, сая .га	Байгалийн неец				Хүн амын багтаамж, даац, сая хүнээр				Нийт боломжит хүн, саяар	Хүн ам, саяар, 2019	Ашиглалт, 2019, %
			Суурьш илд тохиромжтой сая га	Амралт сувилал , аялал жуулчлалын неец сая га	Газр ын доо рх усны нее ц, сая м3	ХА А-н газар, сая га	Тохир оюктой нутаг	Амралт сувилал, аялал жуулчлал	Газр ын доо рх усны нее ц, км3	ХА А-н газар			
1	Баян-олгий	4.6	0.05	0.045	526	35.8	0.67	0.67	1.26	0.280	0.109	38.8	
2	Ховд	7.6	0.3	0.02	125	50.9	4	0.39	0.3	0.360	0.090	24.9	
3	Увс	6.9	0.33	0.025	113	48.2	4.4	0.49	0.27	0.5	0.500	0.083	
4	Говь-Алтай	14.2	0.35	0.027	201	86.2	4.7	0.45	0.48	0.480	0.058	12.0	
5	Завхан	8.2	0.4	0.17	470	69.9	5.3	5.15	1.12	0.630	0.073	11.6	
6	Сэлэнгэ+Дархан	4.3	1.05	0.09	386	22.8	14	3	0.92	1.070	0.217	20.3	
7	Төв+Улаанбаатар	8.3	2.33	0.165	495	55.6	31.1	5.5	1.18	1.380	1.633	118.3	
8	Хөвсгөл	10.1	0.15	0.4	975	44.8	2	10.7	2.33	0.720	0.135	18.8	
9	Булган+Эрдэнэзүйт	5.3	1.48	0.02	347	27.8	19.7	0.67	0.83	0.560	0.170	30.3	
10	Архангай	5.5	0.9	0.03	528	38.5	12	0.8	1.26	0.550	0.095	17.3	
11	Баянхонгор	11.3	0.24	0.12	310	88.8	3.2	2	0.74	0.630	0.089	14.1	
12	Өвөрхангай	6.3	0.64	0.445	316	57.4	8.5	8.7	0.76	0.590	0.117	19.8	
13	Өмнөговь	16.5	-	0.03	70	117.9	-	0.4	0.17	0.5	0.170	0.069	
14	Дундговь	7.8	0.07	0.01	58	71.5	0.9	0.17	0.14	0.4	0.140	0.047	
15	Дорноговь	11.1	0.99	0.09	70	95.4	13.2	1.2	0.17	0.45	0.170	0.071	
16	Хэнтий	8.2	3.02	0.05	599	54.9	40.2	2.12	1.43	0.9	0.900	0.078	
17	Сүхбаатар	8.2	0.1	0.015	86	77.5	1.3	0.25	0.21	1.99	0.210	0.063	
18	Дорнод	12.2	2.61	0.056	397	96.3	34.8	1.09	0.95	2.15	0.950	0.082	
19	Нийт улсын хэмжээнд	155.6	15.01	1.808	6073	114.7.4	200.1	43.75	14.52	12.68	10.2/18.3	3.297	28.7/32.0

Эх сурвалж: Барилга хот, байгуулалтын яам

Дээрх хүснэгтэд үзүүлснээр Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт 18.3 сая хүн тогтвортой амьдрах боломжтой гэсэн тооцоолол гарсан. Хүн амын суурьшлын даацын багтаамжийг аймгуудаар авч үзвэл Төв аймаг, Улаанбаатар хотын хамтаар 20 хувийн даац хэтрэлттэй байгаа бол Сэлэнгэ, Дорнод, Хэнтий аймаг их нөөцтэй байна.

Зураг 4545. Хотуудын хөгжлийн чадавхын үнэлгээ 1-5 баллаар, 2020



Эх сурвалж: Барилга хот, байгуулалтын яам

Хот, суурин газруудын ангилал, зэрэглэлийг оновчтой тогтоохдоо зөвхөн хүн амын тооноос гадна чадавхын үнэлгээ, хөгжлийн стратегийг харгалzan тооцох шаардлагатай. Нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн олон шалгуур үзүүлэлтүүдийг тооцсон хөгжлийн чадавхын үнэлгээ болон хөгжлийн стратегийг нь харгалзан тооцоолсон хөгжлийн чадавхын харьцуулсан үнэлгээгээр Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Замын-Үүд, орон нутгийн зэрэглэлд багтаж болох хотуудаас Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хөтөл нь хамгийн өндөр үнэлгээ авсныг энэхүү графикаас харж болно.

Гадаад орчны өөрчлөлт нь бүс нутгийг хөгжүүлэх, төвлөрийг сааруулах талаар бодлого тодорхойлох хэрэгцээ үүсэж байна. Даяаршлын нөхцөлд дэлхийн улсууд, ялангуяа хөрш хоёр орны геополитик, гео-эдийн засгийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж байна. Тухайлбал, ОХУ Сибирь, Аль Дорнод руу чиглэсэн хөгжлийн бодлогоо шинчилж, Зүүн хойд Ази, Номхон далайн оруудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ ч Ази, Европыг холбож байсан тортон замын худалдаа-эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс - нэг зам”-ын шинэлэг бодлогыг тодорхойлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Орос- Монгол турван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

Газрын тухай хуульд зааснаар “Газар зохион байгуулалт” нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, газар

зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн. Тухайн газар нутагт хэчнэн хэмжээний газрыг хаана, ямар зориулалтаар эзэмшиүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах нөөц боломжийг тодорхойлсны үндсэн дээр зүй зохистой, оновчтой, бүрэн дүүрэн ашиглалтыг буй болгох болон газар, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тооцсон, дүгнэсэн, зураг төслийн аргаар тодорхойлсон баримт бичиг юм.

Зураг 4646. Улаанбаатар хотын нягтшил



Улаанбаатар хотод суурин газарт тулгамддаг асуудал хуриmtлагдаж эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байна. Нийслэл Улаанбаатар хотын одоогийн зарим статистик мэдээллээс харвал Нийслэл нь Монгол улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч нийт хүн амын 46 хувь, их дээд сургууль, коллежийн 96 хувь, иргэдийн хадгаламжийн 82 хувь, автомашины 68 хувь, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 75 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 66 хувийг эзэлдэг гэх мэт үзүүлэлтээр улсын хэмжээнд тэргүүлж байна. Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сергээр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, агаар, хөрс бохирдох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр хот, суурин газарт тулгамддаг асуудал хуриmtлагдаж нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байна.

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний теселд Улаанбаатар хотын доторх төвлөрлийг задлах зорилгоор соёл боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж, бүхий хотын төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, олон төвт хотын тогтолцоог бүрдүүлэхээр төлөвлөгдсөн.

Хотын төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг үйлдвэр, суурьшил, амралт зугаалгын бүсүүдтэй холбосон гудамж замын сүлжээг бий болгон хөдөлгөөний эрчим задалж, нэг төвт хотоос олон төвт хот болон хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Монгол Улсын нийт газар нутгийн 71.7 хувь буюу 110.5 сая га хөдөө аж ахуйн эдэлбэр газар, түүний 97.6 хувийг бэлчээр, хадлангийн газар эзэлж байна. Хөдөө аж ахуйн салбар, ялангуяа хүн амьг хүнс, тэжээл боловсруулах үйлдвэрийг түүхийн эдээр хангадаг здийн засгийн суурь болох мал аж ахуйн үйлдвэрлэл нь уур амьсгалын өөрчлөлт, хур тунадас, жилийн температур, агаарын чийгшилт, салхины чиглэл, хурд зэргээс шууд хамааралтай байна. Монгол мал нь тэсвэрт чанар болон балчээр ашиглах чадвараараа өвөрмөц онцлогтой. Манай улсын нийт ажиллагдын гуравны нэг нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж хүн амьг хүнсээр, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, экспортын болон гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх, худалдаа, үйлчилгээний салбарын ажиллагдыг ажлын байраар хангахад шууд болон шууд бус хэлбэрээр онцгой үүрэг гүйцэтгэдэг. Хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлд мал аж ахуйн нь 80 гаруй хувийг эзэлдэг бөгөөд 2020 оны байдлаар ДНБ-ий 12.2 хувийг үйлдвэрлэн, экспортын орлогын 12 орчим хувийг бүрдүүлж, улсын төсвийн зардлын 3.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 17. Мал аж ахуйн салбарын ХАА-н салбарын нийт үйлдвэрлэлд эзлэх хувь

Он	Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Үүнээс мал аж ахуйн салбар	Эзлэх хувь
2018	5,639.7	4,814.4	85.3
2019	6,548.2	5,675.8	86.6
2020	7,256.7	6,333.0	87.2

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Хөдөө аж ахуйн салбараас хөдөлмөр эрхлэгчдийн 23 орчим хувийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж байна. Энэ салбарт 2010-2020 онд нийт 671.8 тэрбум төгрөгийн урамшуулал, татаас олгожээ. Үүний 76.9 хувь буюу 496.4 тэрбум төгрөгийг мал аж ахуйн, 23.1 хувь буюу 175.3 төгрөгийг газар тариалангийн салбарт олгосон байна. Хөдөө аж ахуйн салбарт 180 мянга гаруй малчин өрхийн 300 орчим мянган малчин, 16.3 мянган тариаланч өрх, 1.5 мянган тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрт 20 гаруй мянган өрх ажиллаж, хөдөлмөр эрхлэгчдийн 23 орчим хувийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж байгаа аж.

Монгол Улсын бэлчээрийн талбайн хэмжээ нь хотжилт, үйлдвэржилт, уул уурхайн хөгжлийг дагаад жилээс жилд буурах хандлагатай байна. Тухайлбал, 1945 онд 130.0 сая га, 1964 онд 122.1 сая га, 1989 онд 122.7 га, сүүлийн 16 жилд буюу 2003-2019 онд хадлан, бэлчээрийн талбай 113.1-112.0 сая га болж 1.1 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 46.2-119.0 сая толгой болж 72.8 саяар буюу 2.6 дахин ессөн. 2019 оны байдлаар нийт бэлчээрийн газрын 17.0 сая га талбай байгалийн унаган төрхөө алдаагүй, 40.5 сая га талбай бага зэрэг доройтсон, 21.1 сая га талбай дунд зэрэг доройтсон, 24.1 сая га талбай хүчтэй доройтсон, 4.7 сая га талбай маш хүчтэй доройтсон дүн гарсан байна. Малын тоо толгойн хэт өсөлтт, уур амьсгалын өөрчлөлтийн нелеөтэй хавсарснаар бэлчээрийн даац хэтэрч, улмаар газрын доройтол, цөлжилтийг эрчимжуулэх үндсэн шалтгаан болж, доройтолд орсон 9.0 сая га газар бүртгэгдсэнд 97.7 хувь нь бэлчээр, хадлангийн газарт, 0.43 хувь нь тариалангийн талбайд, 1.7 нь ойн сан бүхий газарт, 0.12 нь уул уурхай, зам барилгын ажлаас үүдэлтэй ухагдаж эвдэрсэн газарт ногдох байна.

Мал сүргийн тоо тогтвортой өсөж ирсэн боловч үйлдвэрлэх бүтээгдэхүүний өсөлт бага, бүтээмж доогуур байна. Шилжилтийн 30-аад жилийн хугацаанд Монгол Улсын мал сүргийн тоо бараг 3 дахин, 100 га бэлчээрт ногдох малын тоо буюу бэлчээрийн ачаалал 2.3 дахин, малчдын тоо 2.2 дахин, нэг малчинд ногдох малын тоо 26.6 хувиар тус тус ессөн байна. Монголын бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчдын орлого нь тоон үзүүлэлтийн хувьд үндсэндээ малын тоо, нэгжийн ашиг шим, түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ

гэсэн гурван хүчин зүйлээс хамаардаг. Эдгээрээс малын нэгжийн ашиг буурах хандлагатай, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өсөхгүй байгаа нехцөлд малчид маань үндсэндээ малынхаа тоо толгойг өсгөх замаар л хэрэгцээгээ хангаж, амьжиргаагаа тэтгэхийг чухалчилдаг болсон байна.

Хүснэгт 18. Малын тоо, төрлөөр, сая толгой, жил бүр

Он	Адуу	Үхэр	Тэмзээ	Хонь	Ямаа	Нийт
2018	3.9	4.4	0.5	30.6	27.1	66.5
2019	4.2	4.8	0.5	32.3	29.3	71.0
2020	4.1	4.7	0.5	30.0	27.7	67.1
2021	4.3	5.0	0.5	27.7	26.5	67.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХАА-н салбарт бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэл баримтлан ажиллаж байна. Салбарын бодлого нь мэдлэгт суурилсан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, мэргэжлийн үйлчилгээг төгөлдөршүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэл баримталж байна. Хөгжлийн загвар нь уламжлалт ёв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэй технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурины орчимд хөгжлийн ирээдүйтэй сум, сууринд хөгжүүлэх, нөөцийг тогтвортой, зохистой ашиглах, ногоон здийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна хэмээн тодорхойлсон байна

Импортоор авч байгаа Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээ өсөх хандлагатай байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг бага, нэг малаас авах түүхий эд, бүтээгдэхүүний гарц доогуур, малын тэжээлийн хангамж, хүртээмж туйлын хангалттүй, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого, ашиг бага, алдагдалтай байгаа учраас ихэнх аж ахуйн нэгж үйл ажиллагаа тогтвортой бус байна. Жишээ нь 2020 оны эцсийн байдлаар 2025 аж ахуй нэгж, өрхөд 97.6 мянган сүүний үхэр, 594 аж ахуйн нэгж, өрхөд 28.6 мянган махны үхэр үржүүлж байгаа болно. Хүн амын мах, сүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа гэсэн статистик мэдээлэл байдаг ч импортоор авч байгаа сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ өсөх хандлагатай байна. Мөн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж хэрэгцээ 53 хувийн үзүүлэлттэй байна.

Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1990 онд ХАА-н салбарт зэлэх хувь 27.1 байсан бол 2000 онд 10 хувь хүртэл буурсан байна. Монголд хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхгүй байна. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор Засгийн газраас "Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөрийг 1997-2012 онуудад хэрэгжүүлснээр 2012 онд улсын хэмжээгээр 16.8 мянган га-гаас 245.9 мянган тонн төмс, 7.8 мянган га-гаас 98.9 мянган тонн хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөрийн суурь онтой харьцуулахад төмс, хүнсний ногоо тариалсан талбай 2 дахин, хураан авсан ургац 3 дахин нэмэгдэж, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны 52.5 хувийг дотоодын ургацаас хангаж байсан. Улсын хэмжээгээр 2018 онд 35000 өрх, 350 гаруй хоршоо, аж ахуйн нэгж төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн аж ахуй эрхлэн 8.7 мянган га талбайд хүнсний ногоо тарьж 100.7 мянган тонн ургац авсан нь үйлдвэрлэлийн хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 19. Хураасан ургац, ургамлын төрлөөр, мянган тонн

Таримлын төрөл	2018	2019	2020	2021	Өсөлтийн хувь 2021/2020
Үр тария	453.8	433.3	430.3	614.5	42.8
Үүнээс: Буудай	436.1	411.4	406.1	566.3	39.4
Төмс	168.9	192.2	244.3	182.6	-25.2
Хүнсний ногоо	100.7	99.5	121.2	121.7	0.4

Таримал тэжээл	123.8	121.1	182.1	293.7	61.3
Техникийн ургамал	23.9	34	22.6	52.3	2.3 дахин
Бэлтгэсэн хадлан	1,229.4	1,369.2	1,186.2	1,720.6	45.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Газар тариалангийн салбарт үр, техник технологийн шинэчлэлийг чанартай хийж чадахгүй байгаа нь бүтээмжид сергөөр нөлөөлж байна. Тус салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл нэмэгдэж байгаа хэдий ч байгаль цаг уурын тааламжгүй нөхцөлөөс шалтгаалан хураан авах ургацын чанар, хэмжээ тогтвортыхгүй байна. Хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор байгаль, цаг уурын өөрчлөлтөд нийцсэн үр, техник технологийн шинэчлэлийг чанартай хийж чадахгүй байгаа нь тариалангийн салбар тогтвортыхгүй байгаагийн нэг үндсэн нөхцөл нь юм.

Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1990 онд ХАА-н салбарт эзлэх хувь 27.1 байсан бол 2000 онд 10 хувь хүртэл буурсан байна.

Зураг 4747. Үр тарианы үйлдвэрлэл



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам


“Атрын III аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн шинэчлэл хийгдсэн, 2007 оноос эхлэн гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн буудайн тонн тутамд урамшуулалт олгодог болсон, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас шатахуун, үр, бордоо, ургамал хамгааллын бодисыг зээлээр олгож байна. Энэхүү бодлогын томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлснээр тариалангийн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж үр тариа тариалсан талбай, хураан авсан ургацын хэмжээ өссөн байна.

Хөдөө аж ахуйн салбар нь байгаль цаг уурын нөлөөллөөс хэт хамааралтай байгаагаас шалтгаалж эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл нь хэлбэлздэг. Нэг хүнд 2020 онд дунджаар 230.8 кг мах, 335.6 литр сүү ногдож, өмнөх онтой харьцуулахад мах 60.0 кг-аар нэмэгдэж, сүү 1.0 литрээр багассан байна. Манай орны бүх аймаг, сумдаар тархсан мах, сүү, арьс шир, ноос, ноолуурын неөцийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах эрмэлзэлтэй. Үүний зэрэгцээ темс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, байгалийн ургамлын түүхий эд, зөгийн бал боловсруулах чиглэл “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн 2 дугаар хавсралтад тусгагдсан. Харин байршлын чиглэл нь түүхий эдийн тархац, бэлтгэн нийлүүлэлт, нэмүү өртгийн оновчтой сүлжээ, тээвэр-логистик, зах зээлийн эрэлт, хэрэгцээ зэрэг үйлдвэрлэлийн гол хүчин зүйлстэй хэрхэн уялдсан нь анхаарал татахуйц юм.

Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлд тооны хувьд хөнгөн үйлдвэрт арьс шир, ноос, ноолуурын үйлдвэр, хүнсний үйлдвэрт мах, сүүний боловсруулах үйлдвэрүүд давамгайлж байгаа юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, мал аж ахуй, газар тариалангийн нийлүүлэлтэд хамгийн хүчтэй нөлөө үзүүлэх зүйл нь түүхий эдийн үнэ юм. Үнийн

хүчин зүйлийн нэлөөллийг чадамгай ашиглан нийлүүлэлтийг тогтвортой есгэхийн тулд түүхий эдийн чанарыг сайжруулах, хамгаалах, өөрөөр хэлбэл анхан шатны тordолт, боловсруулалтыг газар нь гүйцэтгэж, боловсруулах үйлдвэрт өртөг шингэсэн бүтээгдэхүүн/түүхий эд нийлүүлэхэд оршино.


Зураг 4848. Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт сүлжээ



Эх сурвалж: Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжил, байршилын төвлөвлөлтийн судалгаа

Арьс шир, ноосны анхан шатны тordолт, чанарын хамгаалалтыг хөдөө аж ахуйн нэгдэл, аж ахуй хийдэг, худалдаа, бэлтгэлийн байгууллага арьс ширийг чанараар нь зэрэглэж, бодын ширийг жингээр нь, богийн арьсиг талбайгаар үнэлдэг, мөн ноос, ноолуурыг ч ангилж, зэрэглэн үнэлж, боож баглан бэлтгээд үйлдвэрт нийлүүлдэг байв. Мал бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд тууврын арга зонхилж, малын эрүүл мэндийг хамгаалах, хяналтын арга хэмжээг тууврын замд хэрэгжүүлдэг, гарал үүслийн бүртгэл, тооцоо бүрэн учраас махны аюулгүй байдлын талаар ямар нэг эргэлзээ гарахгүй, мах боловсруулах үйлдвэрүүд төхөөрсөн малынхаа арьс ширний анхан шатны тordолтыг тусгай цехэд хийж, стандартын дагуу зэрэглэн холбогдох үйлдвэрт нийлүүлдэг байв. Гэтэл өнөөгийн тогтолцоонд түүхий эдийн үнэ, урамшуулал нь чанартай шууд уялдаагүй, жишээ нь малыг насаар нь, арьс ширийг ширхэгээр нь үнэлдэг хэлбэрт шилжсэн байна.

Зураг 4949. Хөдөө аж ахуйн биржийн түүхий эд бэлтгэлийн тогтолцоо



Эх сурвалж: Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжил, байршилын төлөвлөлтийн судалгаа

Мал, мах бэлтгэн нийлүүлэлт, хүн амын хэрэгцээний болон экспортын мах, махан бүтээгдэхүүний аюул байдлыг хангах хамгийн чухал арга хэмжээ нь эруул мал бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх явдал болно. Сүү бэлтгэн нийлүүлэлт, нийслэлийн сүүний үйлдвэрүүд 300 км орчим радиуст орших мал бүхий иргэд, фермерийн аж ахуйгаас өөрийн тээврээр сүү цуглуулж, алслагдсан газарт хөргөх тасагт төврүүлэн татаж авдаг бөгөөд энэ бол төвлөрсөн төлевлөгөөт нийгмийн үед Улаанбаатарын сүүний үйлдвэр, Дархан, Дорнод, Эрдэнэтийн хүнсний комбинат, аймгийн хүнсний үйлдвэрт хэрэглэж байсан уламжлалт тогтолцоо юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түүхий эд материалын нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг тухайн бус нутгийн нөөцөд тулгуурлан бий болгох нь чухал асуудал болоод байна.

Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийн есөлтөд дэмжлэг үзүүлэх гол салбар юм. Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь жилээс жилд тогтвортой нэмэгдэж, сүүлийн 10 жилд 4.0 дахин, 2020 онд өмнөх оноос 18.1 хувиар есөж, дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мал аж ахуйгаас жилд 6.3 их наяд төгрөгийн нэмэгдэл өртгийг бүрдүүлж байна.

Хүснэгт 20. Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, улсаар, жилээр, сая төгрөгөөр, 2015-2020 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Улсын дүн	3,496,077.0	3,704,054.0	4,389,301.8	5,182,602.6	6,333,003.8

Эх сурвалж: Үндэсний статикийн хороо

Чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж төрийн өмчийг хувьчилж, нэгдэл, сангийн аж ахий задарснаар эрчимжсэн мал ахуйн хөгжил зогсонги байдалд орсон. Өөрөөр хэлбэл 800, 400 үнээний саалийн механиюксан фермүүд, гахай, шувууны төвлөрсөн аж ахуйн хөгжил саарч эхэлсэн. Үүний дараа 2000 оны сүүлчээс эрчимжсэн мал аж ахуй эрхлэлт аажмаар сэргэж, аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдсэн. Иргэд, аж ахуйн нэгжийн хувьд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх оролдлого, хандлага, сонирхол их байгаа ч олон талт хүчин зүйлсийн нөлөөлөөр дотоодын эрэлт хэрэгцээ, хэрэглэгчийн шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна.

Үхрийн мах, хуурай сүү, өндөг, зөгийн бал зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний болон зарим нэр төрлийн түүхий эдийн импортын хэмжээ өндөр хэвээр байна. Гаалийн ерөнхий газраас авсан судалгаагаар сүүлийн 5 жилд үржлийн адуу 1754, цэвэр үүлдрийн үхэр 3932, үржлийн гахай 797, мах, ноосны болон ихэрлэдэг удмын хонь 3000, сүү, ноолуурын ямаа 286, хоногийн настай дэгдээхэй 1.1 сая толгой, үржлийн өндөг 12.0 сая ширхэг, гүн хөлдөөсөн үр 200.0 мянган тун буюу 52.4 кг-ийг тус тус улсын хилээр нэвтрүүлсэн байна.

Сүү, махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйн төрөлжилт: өнөөгийн байдлаар 2020 оны жилийн эцсийн байдлаар 2025 аж ахуй нэгж, өрхөд 97.6 мянган сүүний үхэр, 594 аж ахуйн нэгж, өрхөд 28.6 мянган махны үхэр, 127 аж ахуйн нэгжид 23.8 мянган нарийн ноост, мах, ноосны хонь үржкуулж байна.

Бусад аж ахуйн төрөлжилт: Өнөөгийн байдлаар 2020 оны 387 өрх, аж ахуйн нэгжид 22.3 мянган гахай, 1391 өрх, аж ахуйн нэгжид 991.8 мянган өндөглөгч тахиа, 608 өрх, аж ахуйн нэгжид 13.5 мянган бүл зөгий, мөн түүнчлэн зарим иргэд цаа буга, илжиг, загас, цөөн тооны цацагт хяруул, галуу, нугас, туулай зэргийг үржкуулж байна.

Монгол орны газарзүйн онцлог, байгалийн баялаг, нөөц чадамжаас хамаарч орон нутаг бүр өөрийн чадамж дээр суурилан, бус нутгийн боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх шаардлагатай. Уул уурхай, эрдэс баялгийн салбар ДНБ-ий 24 хувь, АҮ-ийн салбарын 67 хувь, экспортын орлогын 93 хувь, ГШХО-ын 76 хувийг дангаараа бүрдүүлж байна. Мөн 2021 онд улсын төсөвт 13.2 их наяд төгрөг төвлөрсний 29.6 хувь буюу 4.1 их наяд төгрөгийн тус салбар төвлөрүүлж байна.

Уул уурхай, газрын тосны салбараас 2021 онд 167.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс 158.8 тэрбум төгрөг буюу 78 хувийг уул уурхайн салбараас, 8.3 тэрбум төгрөг буюу 3.7 хувийг газрын тосны салбараас тус тус бүрдүүлсэн байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 82.34 тэрбум төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 8.2 тэрбум төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 11.48 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчийн төлсөн нөөц ашигласны төлбөрийн хассан 10 хувь буюу 56.8 тэрбум төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарт бэлтгэсэн нийт ноолуурынхаа 86 хувийг угаасан, 5 хувийг самнасан байдлаар экспортолж, 9 хувиар нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Тус салбар 2020 онд 721.1 мянган ширхэг боловсруулаагүй, 157.9 мянган ширхэг боловсруулсан арьс шир, 19.4 мянган тонн угаасан ноос, сэв хялгас, 6.3 мянган тонн угаасан ноолуур, 260 тонн самнасан ноолуур, 107 тонн зэрмэл утас экспортод гаргасан байна.

Хүснэгт 9. ХАА-н салбарын үйлдвэрлэл

Салбар	Үйлдвэрийн тоо	Ажиллах хүчин	Үйлдвэрлэл /тэрбум төгрөг/	Борлуулалт /тэрбум төгрөг/
Ноос, ноолуур	327	10,000	381.8	294.3
Арьс шир	150	4,225	31.7	30.5
Оёдол	300	2,506	68.8	63.5
Модон эдлэл, тавилга	450	6,000	21.7	25.5
Хэвлэл	300	4,000	46.0	47.5
Сав баглаа боодол	50	2,000	42.0	41.1
Дахин боловсруулах	27	2,000	14.1	15.5
Гоо сайхан, ахуйн хими	30	200	8.0	4.0
Нийт	1,634	30,931	614.1	521.9

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Хөнгөн үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны байдлаар 621.5 тэрбум төгрөг, борлуулалт 521.9 тэрбум төгрөг, нийт экспорт 492.1 сая ам. доллар байна. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 оны гүйцэтгэлээр (оны үнээр) 36,9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд 13,1 их наяд буюу 35,5 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Харин боловсруулах үйлдвэрийн салбарт 2019 онд нэхмэлийн үйлдвэрлэлд 4.4 хувь нь, хувцас үйлдвэрлэлд 5.2 хувь нь, модон эдлэлд 0,9 хувь нь, хэвлэлд 1,2 хувь нь тус тус оногдож, нийт 11,7 хувьтай байна. Хөнгөн үйлдвэрийн салбарын экспортын бүтцийг авч үзэхэд экспортын барааны нийт дунд нэхмэл, хувцас үйлдвэрлэл, түүхий эдийн экспорт дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд модон эдлэл, хэвлэл цаас картонон бүтээгдэхүүн маш бага хувийг, харин импортын дийлэнх хувийг зээлж байна. Хөнгөн үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний экспортыг нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн тэр дундаа ноолуур зээлж байна.

Түүхий эдийн экспорт давамгайлсан манай улсын хувьд аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах зайлшгүй шаардлагатай байна. Эрдэст түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулах, нэмүү өртгийн сүлжээг


хөгжүүлэн улс орны эдийн засгийн өсөлтийг хангах зайлшгүй шаардлагатай байна. Иймд аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, техник, технологи, инновацад суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэн уул, уурхай металлурги-химиийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк,
- Эрдэнэт-Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр,
- Эрдэнэт-Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл,
- Оюу Толгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал үйлдвэр,
- Монгол Ган цогцолбор-I,
- Алтанширээт аж үйлдвэрийн парк,
- Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр,
- Газрын тос боловсруулах үйлдвэр,
- Газрын тосны дамжуулах хоолойн төсөл.

Соёл, урлагийн салбар нь орон нутагт 435 соёл, урлагийн байгууллагатай, үүнээс 22 соёл, урлагийн газар, 25 урлагийн байгууллага, 24 музей, 24 номын сан, 340 соёлын төв, соёлын ордонд нийтдээ 4470 хүн ажиллаж байна. Жилдээ орон нутгийн хэмжээнд давхардсан тоогоор 3,055,921 хүнд соёл, урлагийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Нийт үйлчлүүлэгчдээс хойч үе болох хүүхдийн үзэгч, үйлчлүүлэгчийн эзлэх хувь нь 18 хувь байна.

Бус, орон нутгийн анхан шатанд үйл ажиллагаа эрхэлж буй соёлын төв, соёлын ордон нь нийт 2645 ажилтантай, 91,446 суудлын хүчин чадалтайгаар жилдээ 3369 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 1,675,800 хүн үйлчилдэг байна. Энэ нь засаг захиргааны анхан шатанд амьдарч буй иргэдэд соёлын үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Зураг 5050. Соёлын салбарын статистик мэдээлэл, 2021



Эх сурвалж: Соёлын явам

Бус, орон нутгийн онцлог нь Монгол орны түүх, соёл, уламжлалын арвин их дээж оршдог. Тэгвэл соёл, урлагийн үйлчилгээ хүртэгч хүүхдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажил чухал байна. Иймээс ч бус орон нутгийг өөрийн өвөрмөц, онцлог байдал, унаган байгаль, эх

терхөд нь тулгуурлан соёлын чиглэлээр зайлшгүй хэрэгжүүлэх 4 үйл ажиллагааг тодорхойллоо. Үүнд:

Соёл, урлагийн үйл ажиллагааг здийн засгийн эргэлтэд оруулахад бид соёлын брэндээ хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Иймээс дэлхийн брэндтэй болохын тулд эхлээд орон нутгийн брэндийг хөгжүүлж түүнийгээ үндэсний хэмжээнд сурталчлан таниулж дэлхийн зах зээлд нэвтрүүлдэг. Орон нутгийн брэнд нь тухайн бус нутгийн соёл уламжлал, бус нутгийн өвөрмөц шинжийг агуулсан байдгаараа онцлог юм. Монгол Улсын хувьд түүх, соёлын арвин баялагтай хийгээд тал, хээр, цөл, хангай хосолсон газарзүйн өвөрмөц тогтоцтой, зөвхөн Монголд л байдаг соёл, уламжлал, ургамал амьтнаараа онцлог учир орон нутгийн соёлын брэндүүдээ сайн хөгжүүлбэл дэлхийн тавцанд гарч амжилттай хөгжих бүрэн бүрэн боломжтой.

Соёл, урлагийн үйл ажиллагааг здийн засгийн эргэлтэд оруулахад бид соёлын брэндээ хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Иймээс дэлхийн брэндтэй болохын тулд эхлээд орон нутгийн брэндийг хөгжүүлж түүнийгээ үндэсний хэмжээнд сурталчлан таниулж дэлхийн зах зээлд нэвтрүүлдэг. Орон нутгийн брэнд нь тухайн бус нутгийн соёл уламжлал, бус нутгийн өвөрмөц шинжийг агуулсан байдгаараа онцлог юм. Монгол Улсын хувьд түүх, соёлын арвин баялагтай хийгээд тал, хээр, цөл, хангай хосолсон газарзүйн өвөрмөц тогтоцтой, зөвхөн Монголд л байдаг соёл, уламжлал, ургамал амьтнаараа онцлог учир орон нутгийн соёлын брэндүүдээ сайн хөгжүүлбэл дэлхийн тавцанд гарч амжилттай хөгжих бүрэн бүрэн боломжтой.¹³ Монгол Улсын 21 аймгийн орон нутгийн бүтээгдэхүүний чадавхын судалгааны үр дунд брэнд бүтээгдэхүүн 0.9 индексээс доош бол “орон нутгийн онцлог брэнд” харин, 0.9 индексээс дээш бол “орон нутгийн соёлын брэнд” гэсэн ангилал үүсэж байна. Нэгтгэн дүгнэн үзэхэд цаашид соёлын брэнд бүтээгдэхүүнүүдийг орон нутгийн, бүсийн, үндэсний цаашилбал дэлхийн, глобал түвшний брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломжтой тул брэнд бүтээгдэхүүн бүрд нэмэлтээр хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийн шинжилгээ /HRV/-ийг хийн хязгаарлагчийг тодорхойлж түүний шийдлийг олох судалгаа явуулах хэрэгцээ гарч байна.

Босоо, хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг барих, хөгжлийн ирээдүйтэй хот, сууринтай уялдуулан орон нутгийг хатуу хучилттай авто замаар холбоно. Монгол Улс нийт 112,414.2 км авто замын сүлжээтэй. Үүнээс 14,918.7 км нь олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд хамаарч, тус сүлжээний 50 орчим хувь буюу нийт 7,744.7 км нь хатуу хучилттай замаар ашиглагдаж байна. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан Монгол Улсын авто замын үндэсний сүлжээг бий болгох зорилтын хүрээнд нийт 21 аймгийн төв, 95 сум, 5 хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдоод байна.

Мөн Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг Улаанбаатар хоттой холбох 32.226 км, 2 урсгал бүхий 6 эгнээтэй олон улсын стандартыг хангасан Монгол Улсын анхны хурдны авто зам болон Нийслэл Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгеж, замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, түгжрэлийг бууруулах зорилгоор хотын гол гудамж зам, төмөр зам дээгүүр гүүрэн гарц, олон түвшний отглолцол бүхий Замын цагдаагийн гүүрэн гарц, Яармагийн 250.2 у/м шинэ гүүр болон хуучин гүүрний их засвар, шинэчлэлтийн ажил, Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрний бүтээн байгуулалтын ажлыг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэн 2019 онд улсын ашиглалтад оруулаад байна.

Дэд бүтцийн хүртээмжийн тааруу байгаагаас уул уурхайн өртгийн сүлжээний хөгжил доогуур хэвээр байна. Эрдэс баялагийн ордын бүтээн байгуулалтын ажил нь цөөн тооны компаниудаар хязгаарлагдаж байгаа бөгөөд үлдсэн компаниуд нь найдвартай дэд бүтэц

байгуулах томоохон зардлыг өөрсдөө хариуцах чадваргүй байдаг. Олборлосон түүхий эдийг шууд экспортлохын оронд дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингээх боломж хязгарагдмал, өртөг нь хэт өндөр байна.

Монгол Улс дотоод дахь дэд бүтцийн хөгжил сулаас гадна бус нутгуудад холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын хувьд бараа бүтээгдэхүүний үнийн бүтцийн 30 орчим хувийг тээвэр, логистикийн зардал эзэлж байгаа нь бусад улс орны үзүүлэлтээс үлэмж өндөр байна. Учир нь Монгол Улс далайд гарцгүй учир олон улсын зах зээлд нэвтэрхийн тулд 2 хөршийн сүлжээгээр дамжин өнгөрөх шаардлагатай болдог. Дэлхийн банкнаас гааль, дэд бүтэц, олон улсын тээвэр, логистикийн үйлчилгээний чанар, тээвэрлэлтийн хяналт, цаг зарцуулалт зэрэг 6 үндсэн үзүүлэлтээр улс орнуудыг дүгнэн логистикийн гүйцэтгэлийн индексийг тооцдог. Уг үзүүлэлтээр Монгол улс 2007 онд 150 орноос 136 дугаарт орж байсан бол 2018 онд 130 дугаар байранд жагсаад байна.

Хүснэгт 10. Логистик гүйцэтгэлийн индекс

Үзүүлэлт		2007	2010	2012	2014	2016	2018
Логистикийн гүйцэтгэлийн индекс	Оноо	2.08	2.25	2.25	2.36	2.51	2.37
	Дэлхийд эзлэх байр	136	141	140	135	108	130
Гааль	Оноо	2	1.81	1.98	2.2	2.39	2.22
	Дэлхийд эзлэх байр	131	149	144	132	100	127
Дэд бүтэц	Оноо	1.92	1.94	2.22	2.29	2.05	2.1
	Дэлхийд эзлэх байр	129	133	125	120	140	135
Олон улсын тээвэрлэлт	Оноо	2.5	2.46	2.13	2.62	2.37	2.49
	Дэлхийд эзлэх байр	91	119	142	110	129	117
Логистикийн чадавх	Оноо	1.8	2.24	1.88	2.33	2.31	2.21
	Дэлхийд эзлэх байр	144	128	152	126	129	140
Хянах, мөрдөн мөшгих чадвар	Оноо	2	2.42	2.29	2.13	2.47	2.1
	Дэлхийд эзлэх байр	136	122	134	149	108	152
Хугацааны найдвартай байдал	Оноо	3	2.55	2.99	2.51	3.4	3.06
	Дэлхийд эзлэх байр	70	147	91	147	65	93

Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Өнөөдрийн байдлаар улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээний 22.6 хувьд нь ээлжит засвар, 13.4 хувьд нь их засвар, шинэчлэлтийн ажил хийх хугацаа болсон, зайлшгүй засварлах шаардлагатай байна. Авто замын засвар, арчлалтын ажлыг жил бүр санхүүжилтийн асуудлаас шалтгаалан нормативт хугацаанд нь зохих түвшинд хангалттай хийж гүйцэтгэгүйгээс тухайн авто зам, гүүрний ашиглалтын байдал улам бүр муудаж, эвдрэл даамжирч, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сергэөр нөлөөлж байна.

Өнгөрсөн хугацаанд жилд дунджаар нийт шаардагдах хөрөнгийн дөнгөж 36 хувь буюу 20 тэрбум төгрөгийн хөрөнгийг засвар арчлалтын ажил зарцуулж байсныг 2020 онд 55 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар төлөвлөж, замын засвар, арчлалтын төрийн өмчтэй 20, хувийн хэвшлийн 12 нийт 32 компанийгээ гэрээ байгуулан олон улсын болон улсын чанартай нийт 14,918.7 км авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгүүлж байна.

Дэлхийн банкнаас 2019 оны байдлаар илгээмж хүргэх хугацаа, илгээмжийн хяналт, логистикийн үйлчилгээ, олон улсын үйлчилгээ, дэд бүтэц, гааль гэсэн шалгуураар эрхлэн гаргадаг логистикийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлтээр нийт 160 орноос 130 дугаарт байрт орж байна.

Худалдаа тээврийг хөнгөвчлөх зорилгоор Монгол Улс 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Хуурай боомтын тухай Засгийн газар хэлэлцээрт гарын үсэг зурж Алтанбулаг, Улаанбаатар, Сайншанд болон Замын-Үүд зэргийг хуурай боомт, харин

Чойбалсанг хуурай боомт болгох боломжтой гэж хэлэлцээрт тусгасан бөгөөд Монгол Улсын Их Хурал 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан. Дээрх хэлэлцээрт тусгагдсан хуурай боомтууд нь Алтанбулаг, Хөшигийн хөндий (Улаанбаатар), Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүстэй байршлын хувьд уялдаж байгаа бөгөөд эхний ээлжид Замын-Үүдийн Бүс нутгийн логистикийн төвийг хуурай боомт болгон хөгжүүлэхээр судалгааны ажлууд хийгдэж байна.

Бага оврын агаарын хөлгийн хөөрч, буух 87 байршилд зурvasын координат баталгаажуулахаас 11 дүгээр сарын 09-ны өдрийн байдлаар 61 байршилд хөөрч, буух зурvasын цэгийг сонгон хэмжилт хийж, координатыг баталгаажуулаад байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 119 дугаар тушаалаар Монгол Улсын Агаарын зайл шинэчлэн тогтоосон. Мөн зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалаар ИНД-71 Агаарын зайл тогтоох болон ангилах дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулсан.

Монгол Улсад агаарын хөлгийн нисгэгч, инженер, техникийн ажилтан бэлтгэхээр хувийн хөрөнгө оруулалтаар “Монголиан авиаашн академи” байгуулагдсан бөгөөд Буянт-Ухаа Олон Улсын нисэхийн буудлын барилга байгууламжийг түшиглэн байгуулагдсан. Мөн үйл ажиллагаанд зориулж Цессна- 172, Н-125, ЕС-130, ЕС-145 маягийн сургалтын агаарын хөлгүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын хэмжээнд нийт 126 нисгэгчийн үнэмлэх эзэмшигчид байна.

Сургалтын төв, нисэх клубийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 19 байгууллага байна. Мөн Монгол Улсад нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ авсан дотоод гадаадын 18 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалаар ИНД- 21, 146, 148-ийг шинэчлэн батлагдаж дотооддоо агаарын хөлөг угсарч, үйлдвэрлэх зохицуулалт бүрдсэн. Тус дүрмийн хүрээнд Монголиан эйрвиз ХХК гадаадаас бага оврын агаарын хөлгийг экспортолж, дотооддоо угсарч, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг тус дүрмүүдийн хүрээнд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас олгож, хэрэгжиж эхлээд байна.


“Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т 2018 оны 10 сарын 12-ны өдөр нэгдэн орсон. Энэхүү хэлэлцээрт нэгдэн орсноор агаарын хөлөг, түүний сэлбэг хэрэгслийг Монгол Улсад татваргүй импортлох зохицуулалт бүрдсэн. Монгол Улсад агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээтэй засвар үйлчилгээ явуулж буй дотоодын 17 компани бүртгэлтэй байна.

Аймаг тус бүрийн зорчигч урсгал, газарзүйн байршил, хүн амын нягтийн, авто замын сүлжил зэрэг хүчин зүйлүүдийг судалж шаардлагатай хөөрч буух зурvas байгуулах газарзүйн байршлыг тогтоох судалгааг боловсруулсан. Тус судалгаагаар нийт 30 газарзүйн байршилд бага оврын агаарын хөлгийн шатахуун түгээх төв байгуулахаар тооцоолсон. Мөн хөгжлийн ирээдүйтэй өсөлтийн төвүүдтэй уялдуулах шаардлагатай байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн ихэнх салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэхэд анхаарлаа хандуулж байна. Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд МХХТ-ийг нэвтрүүлэх ажлууд идэвхжиж байна. Монгол Улсын Засгийн газар МХХТ-ийг ашиглан цахим засаглалыг бий болгох, цахим

засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах, МХХТ-ийн дэд бүтцийг сайжруулах, засгийн газрын цахим мэдээлэл, контентыг хөгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг онлайнаар хүргэх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, дижитал хэрэглээний ялгаатай байдлыг багасгах, хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг цуврал арга хэмжээг хэрэгжүүлсэн. Засгийн газар, төрийн байгууллагууд МХХТ-ийг иргэдэд үйлчилгээгээ хүргэх нэг хэрэгсэл болгох санаачилгудыг хэрэгжүүлж эхэлсэн.


Зураг 5151. Монгол Улсын харилцаа холбооны дэд бүтцийн өнөөгийн байдал



Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Монгол Улсын үүрэн холбооны урт нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 47,278 км-ийг хамаарч байна. Монгол Улсын 15-аас дээш насны иргэдийн 98 хувь нь сүүлийн 3 сард тогтмол үүрэн утас хэрэглэсэн байна.

Зураг 5252. Монгол улсын үүрэн холбоо хэрэглэгчдийн хувь, бүсээр



Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам


Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо: 4.687 сая

- 3G хэрэглэгчийн тоо: 3,539,362
- 4G хэрэглэгчийн тоо: 2,809,592

Улаанбаатар хотын нийт 15-аас дээш насны хэрэглэгчдийн 99.2 хувь, аймгийн төвийн 98.3, сумын төвийн 97.2 хувь, багийн хэмжээнд 95 хувь нь үүрэн холбоог ашиглаж байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 920,000 гаруй өрхийн 80 хувь нь интернэт хэрэглэж байна.

Зураг 5353. Монгол Улсын үүрэн холбооны өрхийн хэрэглээний хувь, бүсээр



Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Улаанбаатар хотын нийт өрхийн 92.4 хувь, аймгийн төвийн 83.1, сумын төвийн 82.5 хувь, багийн хэмжээнд 66.8 хувь нь интернэт хэрэглэж байна.

Зураг 5454. Монгол Улсын шуудангийн салбар



Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Улаанбаатар хотод 40 салбар, аймгийн төвд 22 салбар, сумын төвд 330 салбар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 5555. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлого, тэрбум төгрөг



Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Хүснэгт 21. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлогын бүтэц

№	Эх үүсвэр	Үйлчилгээ	Орлогод эзлэх хувь
1	Мэдээлэл холбоо 83.8%	Яриа - үүрэн холбоо	56.00%
		Интернэтийн үйлчилгээ	9.26%
		Мэдээлэл холбооны сүлжээ	7.74%
		Интернэтийн бөөний үйлчилгээ	5.02%
		Кабел шугам, цамхаг угсралт	2.93%
		Яриа - суурин холбоо	1.54%
		Контентийн үйлчилгээ	0.68%
		Сансрын холбоо	0.52%
2	Өргөн нэвтрүүлэг 14.0%	Яриа - улс хооронд	0.13%
		Олон суваг дамжуулах үйлчилгээ	9.63%
		Өргөн нэвтрүүлгийн ТВ	2.70%
		Арилжааны ТВ	1.54%
3	Шуудан, 2.2%	Арилжааны радио	0.13%
		Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	2.18%

Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Харилцаа, холбооны салбарын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Газар сансрыг холбосон үндэсний харилцаа холбооны нэгдсэн сүлжээ байгуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах;
- Монгол улсыг бүрэн хамарсан тоон радио нэвтрүүлгийн сүлжээ байгуулах;
- Үндэсний радио долгион хяналт, тоног төхөөрөмжийн баталгаажуулж, харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах.

6.3. Тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын бодлогын хүрээнд алслагдсан хил орчмын бус нутагт хүн амын тогтвортой суурьшлыг хангах шаардлага үүсэж байна. Учир нь энэ бус нутаг нь төвөөс алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн, хүн амын шилжин явах хөдөлгөөн их, хүн амын суурьшил, нягтшил багатайгаас гадна хүн амын төрөл ойртолт зэрэг нийгмийн эрсдэлүүд үүсэх нэг нөхцөл болж байна.

Хил орчмын бус нутгийг геостратегийн бус нутаг болгон авч үзэж, энэ бус нутагт, засаг захиргааны нэгж, суурьшлын төвүүдийг татан буулгаж өөрчлөхгүй байх, суурьшлын төвүүдийг эрчим хүч, авто зам, хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн хангамжаар хангах хэрэгтэй. Нөгөө талаар энэ бус нутагт дэд бүтэц муу хөгжсөн, худаг бэлчээрийн усан хангамж, малчин өрхийн суурьшил багатайгаас бэлчээр, өвс тэжээлийн нөөц ихтэй байгааг харгалzan төвийн бүсийн бэлчээрийн даац 2-5 дахин хэтэрсэн бус нутгаас запуу малчдыг шилжин суурьшихад бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Өндөр хөгжилтэй орнуудын жишгийн дагуу хотуудад, ялангуяа нийслэл хотод хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах шаардлагатай байна. 1990-2020 онд Монгол Улсын хүн ам 2.0 саяас 3.2 сая болж, 55 хувиар, тэр дундаа хотын хүн ам 1.0 саяас 2.5 сая болж 2.5 дахин, нийслэлийн хүн ам 0.5 саяас 1.4 сая болж, 2.8 дахин ихээр өссөн байна. Үндсэндээ дээрх хугацаанд өссөн хүн ам нь нийслэлийн хүн ам болж байна. Хүн ам ихээр шилжин ирж байгаагаас Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгэм, төрийн үйлчилгээний ачаалал даац нэмэгдэж, хотын тогтвортой хөгжилд сэргээр нөлөөлөх боллоо. Сүүлийн 20 жилд шилжин ирэгсдийн тоог аймгуудын хүн амтай харьцуулбал нийт 8 аймгийн хүн амын тоотой дүйцэхүйц 462 мянган хүн орон нутгаас Улаанбаатар хотод шилжин иржээ. Улмаар Монгол Улсын хотжилтын түвшин дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрсэн. Хүн амын хэт төвлөрөл, нягтшилаар дэлхийд тэргүүлэгч Япон улсын Токио хотын суурьшлын бүсийн хүн амын дундаж нягтшилаас Улаанбаатар хотын нягтшил илүү гарсан, мөн хороогоор авч үзвэл Чингэлтэй дүүргийн 6-р хорооны нягтшил Токио хотоос 7 дахин хэтэрсэн байгааг харуулж байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөнийг татаж нэг том шалтгаан нь улсын нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, аж үйлдвэр, засаг захиргаа гээд улсын төв болох нийслэлийн бүхий л чиг үүрэг 1 хотод хэт төвлөрсентэй холбоотой юм. Тухайлбал нийт оюутнууд болон их, дээд сургуулиудын 90 гаруй хувь Улаанбаатар хотод төвлөрснөөс гадна дээд боловсролын мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн төрөлжилт хотуудаар ялгаж өгөөгүйгээс болж бүх мэргэжлээр Улаанбаатар хотод төгсөх болсноор орон нутгийн хотуудын оюутнуудын тоо жилээс жилд цеөрч, өрсөлдөх чадвар буурч байна.

Хил орчмын бус нутаг нь төвөөс алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн, худаг, бэлчээрийн усан хангамж, малчин өрхийн суурьшил багатай, хүн амын шилжин явах хөдөлгөөн их, нягтшил багатай байгаа нь хүн амын төрөл ойртолт зэрэг эрсдэлүүд үүсэх нэг нөхцөл болж байна.

Олон улсын жишгээр авч үзвэл, манай улсын хүн амын амьдрах тохиромжтой орон зай, тааламжит орчинг өөрийн хөгжиж ирсэн онцлог, газар нутгийн нөөц, баялаг, байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлтэй уялдуулан, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан тодорхойлох, энэ үндсэн дээр нийгэм, эдийн засгийн ойр ирээдүйн хөгжил, соёлын түвшинг илэрхийлэх, нийгмийн дэвшилд идэвхтэй нөлөөлөх бодит үр дагавар бүхий нутаг дэвсгэрийг зохион

байгуулах, хүн амыг зохистой байдлаар нутагшуулах төслийг боловсруулж, төрийн бодлогын түвшинд авч үзэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсаар байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түүхий эд материалын нийлүүлэлт хадгалалт тээвэрлэлтийн сүлжээг бий болгоход тулгамдаж буй асуудлууд бол мал сүргийн эрүүл мэндийн үзлэгт бүгд хамрагдах боломж хомс, халдварт өвчлөлийн эрсдэл, хүн амын хүнсний аюулгүй баталгаат байдлыг бүрэн хангаж чадахгүй, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар хүртээмжк, орон нутагт мал эмнэлгийн сүлжээ лабораториуд байхгүй, мал эмнэлгийн нэгдсэн системийн чадавх төдийлөн сайн биш байна.

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт дараах асуудлууд тулгамдаад байна.

Үүнд:

- Боловсруулах үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал ашиглалтыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэг үзүүлэх;
- Стратегийн хүнсний экспорт, импортын үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахимжуулах;
- Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах, импортын хамаарлыг бууруулах;
- Стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарал, улирлын нөөц бүрдүүлэлт, үнийн хэлбэлзэл;
- Хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг өргөн хүрээнд явуулж, эх оронч худалдан авалтыг нэмэгдүүлэх, төрийн худалдан авалтаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжих;
- Малын болон ургамлын гаралтай түүхий эдийн нөөц ашиглалт, нэмүү өртөг шингээлт, экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Боловсруулах үйлдвэрийн салбарын хүний нөөцийн чадавхыг сайжруулах.

Эх газрын эрс тэс уур амьсгалд дасан зохицсон 5-6 төрлийн мал, тэдгээрийн олон янз байдал, генетик тогтолцоог 10 мянган жилийн туршид тогтвортой хадгалж ирсэн уламжлалыг үргэлжлүүлэх, өвлүүлэх, бататтан сайжруулахад төрийн оновчтой бодлого, тогтолцоо чухал бөгөөд дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлттэй холбогдуулан байгалийн давагдашгүй хүчин зүйл, болзошгүй эрсдэлийн нөлөөг багасгах, мал сүргийн таваарлаг байдлыг сайжруулах хэрэгцээ шаардлагын үүднээс мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, малын генийн санг хамгаалах, сайжруулах, малын үргүүлэг, биотехнологийн ажил, үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, дэлхийн жишигт нийцсэн технологиор өргөн цар хүрээтэй явуулах, үндэсний чадавхыг бий болгох асуудлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Соёл, урлагийн үйлчилгээ хүртэгч хүүхдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажил чухал байна. Соёлын салбарын хүрээнд 4 үйл ажиллагааг төлөвлөсөн бөгөөд 2025 он гэхэд бус, орон нутгийг голлох 5 аймгийн соёлын брэндийг бий болгох, хөгжлийн ирээдүйтэй 2 бүсэд мега төслийг хэрэгжүүлэх, нүүдлийн соёл, иргэншлийн дурсгалт газар, уламжлалт ахуйд түшиглэсэн соёлын олон төрөлт бүтээгдэхүүн, үйл ажиллагааг хөгжүүлж, хөгжлийн ирээдүйтэй 3 бүсэд соёлын кластерыг хөгжүүлэхээр төлөвлөв. Энэ хүрээнд:

1. Соёлын ёв, угсаатны өвермөц онцлогийг илэрхийлсэн соёлын брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Бүс, орон нутгийн онцлогийг урьд өмнө хийгдсэн шинжлэх ухааны үндэстэй судалгаанууд болон нэмэлт үндэсний хэмжээний судалгаанд түшиглэн олон чиглэлээр тодорхойлж, томьёолох;
- Тодорхойлсон соёлын брэндийг бүтээх, нийтэд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хөгжүүлэх, түгээх буюу соёлын брэндийг нэгдмэл байдлаар үүсгэх;
- Хөгжлийн ирээдүйтэй бүс, нутагт соёлын брэндийг үүсгэн, төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах;

2. Нүүдлийн соёл иргэншлийн дурсгалт газар, уламжлалт ахуй, орон нутгийн хүн амын оролцоонд түшиглэсэн соёлын олон төрөлт бүтээгдэхүүн, үйл ажиллагааг баяжуулан хөгжүүлэх;

- Соёлын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны нэгдсэн үзэсгэлэнг зохион байгуулж хэвших;
 - Шинэлэг бүтээгдэхүүн, соёлын үйл ажиллагааны нэр төрлийг олшруулах чиглэлд гарсан санал санаачилгыг дэмжих, хөгжүүлэх;
 - Нүүдлийн соёл, иргэншилд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, төлөвлүүлэх;
 - Нүүдэлчдийн онцлогийг сурталчлан таниулсан, түгээн дэлгэрүүлсэн, иргэдийн оролцоог хангасан бүтээгдэхүүн, үйл ажиллагааг дэмжих;
3. Орон зай, соёлын онцлог, нөөцөд тулгуурласан мега төслийг хэрэгжүүлэх;
- Мега төслийг хэрэгжүүлэх бус, орон зай газар нутгийг тодорхойлох;
 - Мега төсөл, нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэнгүүдийн үзэл баримтлал, хөгжлийн зураглалын төлөвлөлтийг иж бүрнээр шийдвэрлэх;
 - Мега төслийг хэрэгжүүлэх ТЭЗҮ, ТЭЗҮС-ийг тооцон санхүүжилтийг шийдвэрлүүлэх;
4. Соёлын төрөл, зүйлүүдийг кластерын санаачилга, кластерыг дэмжих
- Бүсүүдийн онцлог нийцсэн соёлын кластерын төрөл, хэлбэрийг тодорхойлох;
 - Соёлын байгууллага, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны хүрээнд кластерыг хөгжүүлэх, түүнд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;

Соёл, урлагийн үйл ажиллагааг здийн засгийн эргэлтэд оруулахад бид соёлын брэндээ хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Иймээс дэлхийн брэндтэй болохын тулд эхлээд орон нутгийн брэндийг хөгжүүлж түүнийгээ үндэсний хэмжээнд сурталчлан таниулж дэлхийн зах зээлд нэвтрүүлдэг. Орон нутгийн брэнд нь тухайн бус нутгийн соёл уламжлал, бус нутгийн өвөрмөц шинжийг агуулсан байдгаараа онцлог юм. Монгол Улсын хувьд түүх, соёлын арвин баялагтай хийгээд тал, хээр, цөл, хангай хосолсон газарзүйн өвөрмөц тогтоцтой, зөвхөн Монголд л байдаг соёл, уламжлал, ургамал амьтнаараа онцлог учир орон нутгийн соёлын брэндүүдээ сайн хөгжүүлбэл дэлхийн тавцанд гарч амжилттай хөгжих бүрэн бүрэн боломжтой.^[1]

Монгол Улсын 21 аймгийн орон нутгийн бүтээгдэхүүний чадавхын судалгааны үр дүнд брэнд бүтээгдэхүүн 0.9 индексээс доош бол орон нутгийн онцлог брэнд харин, 0.9 индексээс дээш бол орон нутгийн соёлын брэнд гэсэн ангилал үүсэж байна. Нэгтгэн дүгнэн үзэхэд цаашид соёлын брэнд бүтээгдэхүүнүүдийг орон нутгийн, бүсийн, үндэсний цаашилбал дэлхийн, глобал түвшний брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломжтой тул брэнд бүтээгдэхүүн бүрд нэмэлтээр хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийн шинжилгээ /HRV/-ийг хийн хязгаарлагчийг тодорхойлж түүний шийдлийг олох судалгаа явуулах хэрэгцээ гарч байна.

Үүний дараа брэнд бүтээгдэхүүнүүд хооронд нь төр, хувийн хэвшлийн түншлэл, холбогдох захиргааны байгууллага, бизнес эрхлэгчидтэй хамтран орон нутгийн брэнд бүтээгдэхүүнүүдийг кластерийн загвараар хөгжүүлэн салбарын болоод бус, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусган, уялдуулах нөхцөл бүрдэнэ.

Тухайн бус нутгийн нөөцөд тулгуурласан сүлжээ байхгүй. Төреөс дэмжлэг үзүүлэх нь бага. Төв авто замаас алслагдсан ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн хувьд төв зам хүрэх туслах замыг хурдтай явах боломжтой болгон сайжруулах, тэмдэг тэмдэглэгээ хийх, ус зайлцуулах шугам тавих зэргийг хийх зайлшгүй шаардлагатай. Түүхий здийн боловсруулалтаас нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулах явц, үйлдвэрлэлтэй уялдуулан байгаль орчинд ээлтэй буюу эрчим хүчиний шугам хоолой зэрэг дэд бутцийн хүчин чадал мүү.

1. Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа явуулахтай холбоотой орон нутгийн эсэргүүцэл, үл ойлголцол бий болдог.
2. Дэд бүтэц, тээвэр, логистикийн хөгжил сул, хил гаалийн нэвтрүүлэх хүчин чадал дутмаг
3. Уул уурхайн үйл ажиллагаа, хууль бус ашигт малтмалтай холбоотойгоор байгаль орчинд үзүүлэх серөг нөлөөлөл нэмэгдэж байна.

Дээрх төслийдийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлууд тулгарч байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүчиний хангамжийг шийдвэрлэх зорилгоор 220/110/35кВ-ын дэд станцуудыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулах;
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Үйлдвэрт түүхий эд нийлүүлэх асуудлыг шийдвэрлэж баталгаажуулах.
- Дотоодын түүхий эдэд түшиглэсэн Газрын тос боловсруулах үйлдвэр барьж, ашиглалтад оруулах, түүхий эдээр хангах асуудлын хүрээнд газрын тосны эрэл, хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллахгүй бол үйлдвэр ашиглалтад орох тухайн нэхцэлд түүхий эдийн нөөцгүй, үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжгүй болно.
- Газрын тосны салбарыг олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй зохион байгуулах.

Мөн соёлын брэндийг шалгах шалгуур тодорхойгүй тул өнөөг хүртэл соёлын брэндийг тодорхойлж гаргаж чадаагүй. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс здийн засгийн орлого олох тогтолцоо бүрдээгүй байна. Орон нутгийн соёлын үйлчилгээнээс бүрдүүлэх жилийн орлого нь сумын соёлын төвийн хувьд 2,0 сая төгрөг, аймгийн урлагийн байгууллагын хувьд 25,0 сая төгрөгөөр төлөвлөгддэг. Үүнийг өөрийн үндсэн үйл ажиллагаагаараа төвлөрүүлдэг, зарим тохиолдолд өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж чаддагтуй. Энэ нь соёлын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг здийн засгийн эргэлтэд оруулахад бодлого, эрх зүйн орчин бүрдээгүй, бус орон нутгийн соёлын бодлогыг тусгайлан тодорхойлоогүйтэй шууд хамааралтай.

Харин бус, орон нутагт ижил түвшний бүтээн байгуулалтуудыг төлөвлөх бөгөөд бүсийн хөгжлийг дэмжсэн томоохон бүтээн байгуулалт, мега төслийг төлөвлөх нь бага байна. Иймээс бус, орон нутгийн соёлын байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн соёлын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшуулах, үйлчилгээний хэлбэрийг нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага бий болж байна.

Нийт 24 соёлын төвийн үйл ажиллагаа явуулж буй барилга нь авто гараж, ахуй үйлчилгээ, аж ахуйн, Засаг даргын Тамгын газрын, хорооны, хурлын заал, агуулах, сургууль, цэцэрлэг, ресторан, төмөр замын депо, холбоо, цэргийн штабын зориулалттай буюу соёлын төвийн зориулалтын бус барилга байна.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Ази, Номхон далайн орнуудын здийн засаг, нийгмийн комиссоос хийсэн судалгаагаар улсуудын засгийн газрын чөлөөт бус байгуулах үндсэн шалтгаан нь “нэгдүгээрт хөрөнгө оруулалтыг татах, хоёрдугаарт ажлын байр нэмэгдүүлэх, гуравдугаарт орлого олох” бол чөлөөт бусэд бизнес эрхлэгчдийн хувьд дэд бүтэц, эрчим хүчиний хангамж мөн байршил нь маш чухал байна. Тиймээс бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулах эсэхээ шийдвэрлэхэд дээрх зүйлсээс шалтгаалж хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэх эсэхээ шийдвэрлэдэг байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн тухайд 3,8 км 6 кВ цахилгаан хангамжийн түр шугам, 2610 кВА хүчин чадалтай 4 дэд өртөөний байгууламжийг барьж ашиглалтад оруулан эрчим хүчиний эх үүсвэрийг Алтанбулаг сумаас авч байна. Дулаан хангамжийн эх үүсвэрт холбогдоогүй.

Цаашид чөлөөт бүсэд шинээр нэмж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, үйл ажиллагаагаа өргөтгөхөд эрчим хүчиний хүрэлцээ хангалтгүй, сумын эрчим хүчиний суурилагдсан хүчин чадал дээд хэмжээндээ тулсан байгаа тул цахилгаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөж Сүхбаатар сумаас Алтанбулаг сум хүртэл 24 км урттай 110 кв агаарын шугам, дэд станцыг барьж байгуулах, дулааны станцыг барьж байгуулан Алтанбулаг сум болон Хилийн боомт, чөлөөт бүсийг нэгдсэн дулаанаар хангах боломжтой.

Цагааннуур чөлөөт бүсийн тухайд сумын төвөөс 10 кВт хүчин чадалтай цахилгааны түр эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулсан. Цаашид чөлөөт бүс үйл ажиллагаа явуулж эхлэх үед цахилгаан хангамжийг өргөтгөх шаардлагатай.

Алтанбулаг чөлөөт бүсийн тухайд хоногт 6,300 м.куб цэвэр усаар хангах байгууламж, хоногт 5700 м.куб бохир тээвэрлэх хүчин чадалтай бохир усны насос, секундад 15 м.куб урсгах хүчин чадалтай үерийн ус зайлцуулах байгууламжийг тус тус барьж ашиглалтад оруулсан.

Цаашид Алтанбулаг чөлөөт бүсийн холбоо сувагчлалын барилга байгууламж болон бүс доторх дулааны шугам, хоолойн ажлыг барьж байгуулах шаардлагатай.

Замын-Үүд чөлөөт бүсийн тухайд Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 58.8 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 48 га талбайд шинээр автозам, холбоо дохиолол, усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, дулааны станцын барилга байгууламж барьж улсын комисст хүлээлгэн өгсөн.

Цаашид чөлөөт бүсийн 2-р ээлжийн дулаан, усан хангамж, ариутгах татуургын ажлыг барьж байгуулах шаардлагатай. Цагааннуур, Хөшигийн хөндийн чөлөөт бүсийн тухайд одоогоор инженерийн дэд бүтцэд холбогдоогүй. Цаашид инженерийн дэд бүтцэд үе шаттайгаар барьж байгуулах шаардлагатай.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Цагааннуур чөлөөт бүсийн хажуугаар Ази, Европыг холбосон АН-4 олон улсын авто зам 2019 онд ашиглалтад орсон. Бүсээс боомт хүртэлх 28 км авто зам, Өлгий хотыг тойрч гарах зам гүүрийн барилгыг энэ онд дуусгахаар төлөвлөжээ. Энэ нь Цагааннуур чөлөөт бүсэд ОХУ болон БНХАУ-ыг холбосон тээвэр логистикийн төв байгуулахад давуу талтай хэмээн Цагааннуур чөлөөт бүсийн захирагч танилцуулжээ.

Босоо, хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг барих, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтэй уялдуулан орон нутгийг хатуу хучилттай авто замаар холбоно. Зорилтын хүрээнд төлөвлөж буй авто замын төслийдийг хэрэгжүүлэхэд нийт 4,572,680 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлагатай.

Тээвэр, логистикийн болон хуурай боомтын үйл ажиллагааг зохицуулах тусгайлан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөгжлийн ирээдүйтэй хот, сум сууринд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлагатай. Улсын чанартай 14918.7 км авто зам болон түүнийг дагууд байрлах төмөр бетон гүүрний зөвхөн урсгал засвар, арчлалтын ажлын зардалд жилд 90 орчим тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд жил бүр 20-50 тэрбум

Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөр

төгрөг төсөвлөгддөг нь урсгал засвар, арчлалтын ажлыг норм нормативын дагуу чанартай гүйцэтгэх боломжгүй байдалд хүргэж байна. Арчлалтын ажлыг нормын дагуу гүйцэтгээгүйгээс авто зам эвдэрч зэлжит болон их засварын зардлыг ёсгех нөхцөл байдал бий болдог. Иймд жил бүр авто замын урсгал засвар, арчлалт, зэлжит засвар, их засварын ажлын хөрөнгө оруулалтыг бүрэн тусгах шаардлагатай.

6.4. Зорилго, зорилт, үйл ажиллагаа

Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг оновчтой болгох, Бүс нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, хөгжлийн ирээдүйтэй хот суурин, чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн тогтолцоог сайжруулахад тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан, шийдвэрлэх арга замуудад үндэслэн 4 зорилго, 9 зорилт, 39 үйл ажиллагааг тодорхойлоод байна.

Зорилго 1. Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг оновчтой болгоно.

Энэхүү зорилгын хүрээнд нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн нэгдсэн төлөвлөлтийг оновчтой болгох асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 1 зорилт, 3 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 1.1. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн нэгдсэн төлөвлөлтийг оновчтой болгоно.	
1.1.1	Хөгжлийн ирээдүйтэй хот, сууриныг тодорхойлох суурь судалгааг хийж, төлөвлөлтийг оновчтой болгоно.
1.1.2	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, улсын тусгай хамгаалалтад авах газрын байршлыг бүрэн тусгаж, сайжруулна.
Зорилт 1.2. Үндэсний орон зайн өгөгдлийн системийг хэрэглээнд нэвтрүүлнэ.	
1.2.1	Үндэсний орон зайн өгөгдлийн системийг бүрдүүлнэ.
1.2.2	Үндэсний орон зайн өгөгдлийн системийн мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгоно.
1.2.3	Үндэсний хаягийн мэдээллийн нэгдсэн системийг сайжруулж хэрэглээнд нэвтрүүлнэ.

Зорилго 2. Бүс нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн түүхий эд материалын нийлүүлэлт хадгалалт тээвэрлэлтийн сүлжээг хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд бий болгох, түүхий эд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж үйлдвэржүүлэх, аялал жуулчлалын үйлдвэрлэл-үйлчилгээг эрчимжүүлэх, соёлын бүтээгдэхүүн үйл ажиллагааг хөгжүүлж эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 7 зорилт, 21 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 2.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж бүтээмжийг нэмэгдүүлнэ.	
2.1.1	Иргэд аж ахуй нэгж хоорондын хорших хамтран ажиллах үйл ажиллагааг хөгжлийн ирээдүйтэй сум сууринд өргөжүүлнэ.
2.1.2	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
2.1.3	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон дэвшилтэт технологид сууриссан тогтвортой газар тариаланг хөгжлийн ирээдүйтэй сум, сууринд хөгжүүлж үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
2.1.4	Бэлчээрийн менежментийг сайжруулна.
2.1.5	Малын ашиг шимийг сайжруулна.
2.1.6	Малын тэжээлийн нөөц хангамжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 2.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түүхий эд материалын нийлүүлэлт хадгалалт тээвэрлэлтийн сүлжээг хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд бий болгоно.

2.2.1	ХАА-н гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл борлуулалтын сүлжээг хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд хөгжүүлнэ.
2.2.2	Худалдаанд сууриссан дэд бүтэц үйлдвэрлэлийн цогц систем бүрдүүлнэ.

Зорилт 2.3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарыг сайжруулна.

2.3.1	Малын генийн санг хамгаална.
2.3.2	Малын үргжил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулж бус нутгийн онцлогт тохирсон мал үржүүлэх ашиг шимиийн түвшинг бүсчлэн тогтоож сургийн эргэлтийг тооцох замаар бэлчээрийн даац нехэн сэргэх чадавхд тохируулна.
2.3.3	Олон улсын худалдааны хориг бүхий мал амьтны гоц халдварт халдварт өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх тэмцэх өвчнөөр улс бус нутгаар тайван байдлыг баталгаажуулна.
2.3.4	Шинээр болон дахин сэргэж байгаа малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин оношлуурыг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангах вакцин эм бэлдмэлийг хадгалах хүйтэн хэлхээний сүлжээг нэвтрүүлнэ.
2.3.5	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны хүртээмж чадавхыг бэхжүүлнэ.
Зорилт 2.4. Хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж үйлдвэржүүлнэ.	
2.4.1	Хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд аж үйлдвэрийн паркуудыг хөгжүүлнэ.
Зорилт 2.5. Бус нутгийн хөгжилд уул уурхай хүнд үйлдвэр газрын тосны салбарын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	
2.5.1	Бус нутгийн тогтвортой хөгжлийг хангасан хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.
2.5.2	Геологи хайгуулын ажлыг эрчимжүүлж ашигт малтмалын боловсруулалтын түвшинг дээшлүүлэн металлурги-химийн аж үйлдвэрийн цогцолборыг байгуулж шинжлэх ухаан технологийн чадавх экспортыг нэмэгдүүлнэ.
2.5.3	Түүхий эдийн нөөцед түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэрийг дэд бүтцийн хамт байгуулж ашиглалтад оруулна.
2.5.4	Уул уурхайн салбарын хөгжлийн ирээдүйтэй бус нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг өндөржүүлж нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.
Зорилт 2.6. Бус нутгийн аялал жуулчлалын үйлдвэрлэл-үйлчилгээг эрчимжүүлнэ.	
2.6.1	Аялал жуулчлалын үйлдвэрлэл-үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
2.6.2	Аялал жуулчлалын үйлдвэрлэл-үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж чанарыг сайжруулан тээвэр логистикийн сүлжээг байгуулна.
2.6.3	Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлж төрийн дэмжлэгийг нэмэгдүүлнэ.
2.6.4	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж хүртээмжийг сайжруулна.
2.6.5	Жуулчдын аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлнэ.
2.6.6	Байгаль түүх соёлын өв үндэсний онцлог нутгийн иргэдэд түшиглэсэн хүрээлэн орчинд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
Зорилт 2.7. Бус нутгийн онцлог хүн амын чадавхд түшиглэсэн соёлын бүтээгдэхүүн үйл ажиллагааг хөгжүүлж эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлнэ.	
2.7.1	Бус орон нутгийн байгалийн дурсгал түүх соёлын өв угсаатны өвөрмөц онцлогийг илэрхийлсэн соёлын брэндийг бүтээнэ.
2.7.2	Нүүдлийн соёл иргэншилийн дурсгалт газар уламжлалт ахуй орон нутгийн хүн амын оролцоонд түшиглэсэн соёлын олон төрөлт бүтээгдэхүүн үйл ажиллагааг баяжуулан хөгжүүлнэ.
2.7.3	Хөгжлийн ирээдүйтэй хот, суурини төвүүдэд байгаль орчин нүүдлийн соёлын онцлог нөөцед тулгуурласан орон зай бүхий соёлын мега төслийдийг үе шаттай хэрэгжүүлж орлогыг нэмэгдүүлнэ.
2.7.4	Соёлын кластерын санаачилгыг дэмжих салбар дундын уялдааг сайжруулна.

Зорилго 3. Хөгжлийн ирээдүйтэй хот суурин, чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн тогтолцоог сайжруулна.

Энэхүү зорилгын хүрээнд бус нутаг чөлөөт бүсүүдийн эрчим хүчиний хангамж дамжуулалтын тасралтгүй найдвартай аюулгүй байдлын орчин бүрдүүлэх, инженерийн дэд бүтцийг үе шаттай өргөтгэх сайжруулах, авто замыг барих, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, иргэний нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл харилцааны холбооны дэд бүтцийн хүчин

чадлыг нэмэгдүүлж хамрах хүрээг өргөжүүлэх, Улаанбаатар хотын суурьшлын бус үйлдвэрлэл инженерийн дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 8 зорилт, 34 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 3.1 Бус нутаг чөлөөт бүсүүдийн эрчим хүчиний хангамж дамжуулалтын тасралтгүй найдвартай аюулгүй байдлын орчин бүрдүүлнэ.	
3.1.1	Хөгжлийн ирээдүйтэй хот, суурин, чөлөөт бүсүүдийн эрчим хүчиний хэрэгцээг тогтвортой үр ашигтай хангах эх үүсвэрүүдийг дэс дараатай ашиглана.
3.1.2	Хөгжлийн ирээдүйтэй хот суурин, чөлөөт бүсүүдийн эрчим хүчиний түгээлт дамжуулалтын найдвартай үр ашигтай сүлжээнд холбоно.
3.1.3	Дулаан хангамжийн найдвартай эх үүсвэрүүдийг ашиглалтад оруулж сүлжээний алдагдлыг бууруулна.
Зорилт 3.2 Хөгжлийн ирээдүйтэй хот суурин, чөлөөт бүсүүд дэх инженерийн дэд бүтцийг үе шаттай өргөтгөх сайжруулна.	
3.2.1	Цэвэр ус хангамжийн нэгдсэн системийг сайжруулж хүчин чадлыг хөгжлийн ирээдүйтэй сум, сууринд нэмэгдүүлнэ.
3.2.2	Бохир усыг зайлцуулах дахин ашиглах системийг боловсронгуй болгож стандартын шаардлагад нийцуулэн цэвэрлэх байгууламжуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
Зорилт 3.3 Босоо, хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг барих, хөгжлийн ирээдүйтэй хот, суурин, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан орон нутгийг хатуу хучилттай авто замаар холбоно.	
3.3.1	Хөгжлийн ирээдүйтэй хот, суурини төвүүдийг босоо болон хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замаар холбоно.
3.3.2	Аялал жуулчлалын гол маршрутыг хатуу хучилттай авто замаар холбоно.
3.3.3	Хедөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг дэмжсан авто замын сүлжээг байгуулна.
3.3.4	Ашигт малтмалын бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын хатуу хучилттай авто замыг барина.
Зорилт 3.4 Авто зам замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал замын, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулна.	
3.4.1	Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг стандарт норм дүрмийн дагуу гүйцэтгэж үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.
3.4.2	Авто замын түр буудаллах цэг замын хажуугийн зогсоолыг стандартын дагуу байгуулна.
3.4.3	Замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах цэгүүдийг оновчтой тогтоож тэмдэг тэмдэглэгээг байршуулна.
3.4.4	Зам, тээврийн ослын үед ашиглах техник хэрэгслийн хангалтыг сайжруулах, осол saatlyн үед үзүүлэх тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулах сүлжээг байгуулна.
3.4.5	Нийслэл, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замыг камержуулж, гэмт халдлага, осол, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ
Зорилт 3.5 Тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлнэ.	
3.5.1	Хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд тээвэр логистикийн төвийг байгуулна
3.5.2	Хот хоорондын зорчигч үйлчилгээний терминалыг байгуулна.
3.5.3	Авто замын дагуух үйлчилгээний цогцолборыг стандартын дагуу байгуулж, зорчигч явагчдын ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.
3.5.4	Логистикийн төвийг түшиглэн Хуурай боомт байгуулах ажлыг эхлүүлнэ.
3.5.5	Худалдаа тээврийг хөнгөвчлөх хөгжлийн ирээдүйтэй хот, сууринд логистик, хуурай боомт, чөлөөт бүсийн үйл ажиллагааг уялдуулж, замын сүлжээнд холбоно.
3.5.6	Усан замын тээврийн үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй аюулгүй хэвийн явуулах бодлогыг хэрэгжүүлэх, усан замын эко зогсоол байгуулна.
Зорилт 3.6 Иргэний нисэхийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	
3.6.1	Хөгжлийн ирээдүйтэй хот, суурини нисэх буудлын хүчин чадал ашиглалтыг сайжруулна.

3.6.2	Ерөнхий зориулалтын нисэхийн хөөрч буух зурvas, шатахуун хангамж, агаарын хөлгийн засвар үйлчилгээний сүлжээг хөгжлийн ирээдүйтэй сум, сууринд хөгжүүлнэ.
3.6.3	Алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, эрх зүйн орчин бүрдүүлнэ.
Зорилт 3.7 Бус нутгийн мэдээлэл харилцааны холбооны дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж хамрах хүрээг өргөжүүлнэ.	
3.7.1	Өндөр хурдны өргөн зурvasын сүлжээнд Монгол Улсын нийт нутаг дэвсгэр бүрэн хамруулна.
3.7.2	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүртээмжийг хөгжлийн ирээдүйтэй сум, сууринд нэмэгдүүлнэ.
3.7.3	Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлнэ.
3.7.4	Шуудангийн сүлжээний бэлэн байдлыг хангана.
3.7.5	Тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор нэмэлт дата төвийг шинээр байгуулах, одоо ашиглагдаж буй төвийг өргөтгэн шинэчлэх, ногоон дата төв байгуулна.
Зорилт 3.8 .Улаанбаатар хотын суурьшлын бус үйлдвэрлэл инженерийн дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлнэ.	
3.8.1	Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийг барьж, иргэдийн амьдрах орчин сайжруулан үерийн эрсдэлийг бууруулна.
3.8.2	Усны нөөцийн эх үүсвэрийг хамгаалах, хуримтлуулах, алдагдлыг бууруулах, усан сан, төвлөрсөн эх үүсвэр, шугам сүлжээг барьж байгуулан хүртээмж, хангамжийг сайжруулна.
3.8.3	Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж барьж, хуучин байгууламжуудад техник, технологийн шинэчлэлт хийж хүртээмжийг нэмэгдүүлнэ.
3.8.4	Эрчим хүчиний ашиглалтын үр ашгийг ёсгэж, дэд бүтцийг өргөжүүлэн, технологийн шинэчлэл хийж, хүн амыг тогтвортой эрчим хүчээр хангана.
3.8.5	Дулааны эрчим хүчиний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгоно.
3.8.6	Мэдээлэл, холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэнэ.

6.5. Хүрэх үр дүн

Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн нэгдсэн төлөвлөлтийг оновчтой болгох, хөгжлийн ирээдүйтэй өсөлтийн төв хот, сууринг тодорхойлж баталгаажуулах, үндэсний орон зайн өгөгдлийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх замаар нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг оновчтой болгоно.
- Хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл зэрэг салбаруудын бүтээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар бус нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- Бус нутаг чөлөөт бусуудийн дэд бүтцийн тогтолцоог сайжруулна. Үүний тулд:
 1. Бус нутаг чөлөөт бусуудийн эрчим хүчиний хангамж дамжуулалтын тасралтгүй найдвартай аюулгүй байдлыг бий болгож 870 км шугам сүлжээг ашиглалтад оруулна.
 2. Бус нутгийн хөгжлийн төлөвлөлтэй уялдуулан орон нутгийг хатуу хучилттай авто замаар холбож, хөгжлийн ирээдүйтэй сум сууринг холбосон хатуу хучилттай авто замын сүлжээг 2 дахин нэмэгдүүлнэ.
 3. Авто зам замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал замын, хедөлгөөний аюулгүй байдлыг сайжруулж, зам тээврийн ослын тоог бууруулна.
 4. Тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлж, хөгжлийн ирээдүйтэй сум сууринд 56 логистик терминал цогцолбор байгуулна.
 5. Иргэний нисэхийн дэд бүтцийг хөгжүүлж, бус нутагт нэмэгдсэн стандартад нийцсэн орон нутгийн нисэх буудлын тоог 161 -т хүргэх
 6. Бус нутгийн мэдээлэл харилцааны холбооны дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж хамрах хүрээг өргөжүүлнэ
 7. Улаанбаатар хотын суурьшлын бус үйлдвэрлэл инженерийн дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлнэ.

БҮЛЭГ 7. ҮНДЭСНИЙ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

7.1. Танилцуулга

Дэлхийн эдийн засгийн форумаас “Өрсөлдөх чадвар” гэж “Улс орны бүтээмжийн түвшнийг тодорхойлж буй институт, бодлого, дэд бүтэц гэх мэт хүчин зүйлсийн нийлэмж”-ийг хэлнэ гэж тодорхойлжээ. Өрсөлдөх чадварын тухай ойлголт сүүлийн 200 орчим жилийн турш судлагдаж байгаа бөгөөд анх өрсөлдөх чадварыг туйлын давуу тал, худалдааны харьцангуй давуу талаар тодорхойлж байсан бол өдгөө боломжит нөөцөө удирдах чадвар, бизнес эрхлэх таатай орчин, эдийн засгийн салбаруудын чадавх, хөдөлмерийн зах зээлийн байдал, төрийн тогтвортой, үр ашигтай засаглал, компанийн засаглал зэрэг гадаад, дотоод хүчин зүйлсийг нэгтгэн өргөн хүрээнд авч үзэж байна.

Монгол Улсын өрсөлдөх чадвар олон улсын түвшинд доогуур байна. Дэлхийн эдийн засгийн форумаас “Таатай орчин”, “Хүний нөөц”, “Зах зээл”, “Инновацын экосистем” гэсэн 4 хүрээнд 12 бүлгийн 103 үзүүлэлтээр Өрсөлдөх чадварыг хэмжиж байна. Монгол Улс уг Өрсөлдөх чадварын индексээр 2017-2019 онд дунджаар 101 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. 2019 оны байдлаар дэлхийн 141 орноос 102 дугаар байрт байгаа нь өмнөх оноос 3 байраар ухарсан үзүүлэлт юм. Манай орны хувьд доогуур үнэлэгдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь өмчийн эрх (property right), засгийн газрын чиг баримжаа (future orientation of government), тээврийн дэд бүтэц (transport infrastructure), макро эдийн засгийн тогтвортой байдал (macroeconomic stability), үр чадвар (skills), бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал (product market), санхүүгийн систем (financial system), бизнесийн хурдтай өөрчлөгдхө байдал (business dynamism), инновацын чадавх (innovation capability) зэрэг үзүүлэлтуүд байна. Ийнхүү өрсөлдөх чадвар сүл байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт доогуур, уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн цөөн, эдийн засгийн тэлэлт удаан, нэг хүнд ногдох орлого дорвигий өсөхгүй байх гол шалтгаан болж байна.


Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулахдаа Монгол Улсын өрсөлдөх чадварын индексийг хойш татах буй гол хүчин зүйлсийг арилгах зарчмыг баримтлан боловсрууллаа. Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлсон макро эдийн засгийн тогтвортой байдал, бизнесийн орчин, инновацын хөгжил сүл, эдийн засаг төрөлжөөгүй зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг “Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр”-т тодорхойлсон. Мөн Монгол Улсын өрсөлдөх чадварт сэргээр нөлөөлж буй хуулийн хэрэгжилтийг сайжруулах, эрхэзүйн таатай орчныг бүрдүүлэх зорилтуудыг “Засаглалын зорилтот хөтөлбөр”-т, хөдөлмерийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтыг “Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т хуний үр чадвар, төлөвшлийг хөгжүүлэх, боловсролын чанарыг ахиулах, эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийх зорилтуудыг “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т тус тус тусгалаа.

“Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр”-ийг макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, инновацын тогтолцоог бүрдүүлэх гэсэн 4 зорилгын хүрээнд 9 зорилт, 39 үйл ажиллагаатай боловсрууллаа. Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд нэгдүгээрт, ерийн дарамтыг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хоёрдугаарт, компанийн засаглалыг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах, гуравдугаарт, тэргүүлэх салбаруудыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх, дөрөвдүгээрт, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх гэсэн 4 зорилгыг дэвшүүлж байна. Тус зорилтот хөтөлбөрийг эдийн засаг, дэд бүтэц, засаглал, бизнесийн ашигт ажиллагааг илэрхийлсэн дэлхийн өрсөлдөх чадварын үндсэн шалгуур, зарчимтай нийцүүлэн боловсруулсан бөгөөд засаглалын зөв бодлого болон эдийн засгийн өндөр бүтээмжтэй, тогтвортой есөлтийн орчныг бүрдүүлснээр Монгол Улсын өрсөлдөх чадварын эрэмбийг 102 (2019 оны тайлангаар) дугаар байрнаас 20 байраар урагшуулах, ингэснээр “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогод дэвшүүлсэн хүн амын дундаж давхарыг нэмэгдүүлэх үндэсний зорилгод хүрэхэд дорвигий хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

7.2. Монгол Улсын өрсөлдөх чадварын өнөөгийн нөхцөл байдал


Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг хоёр үндсэн судалгааны байгууллага үнэлж байна. “Дэлхийн эдийн засгийн форум (WEF)”, “Менежментийн хөгжлийн олон улсын хүрээлэн (IMD)” гэсэн 2 байгууллагаас туршигдсан аргачлалын дагуу жил бүр дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг үнэлж, эрэмбэлдэг.

Зураг 5656. Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт, 141 орноос зэлзэх байр, 2019 он



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум

Зураг 5757. Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт, 64 орноос зэлзэх байр, 2019 он



Эх сурвалж: Менежментийн хөгжлийн олон улсын хүрээлэн

Дэлхийн эдийн засгийн форум улс орнуудын өрсөлдөх чадварыг 12 тулгуур бүлэг бүхий 103 үзүүлэлтээр шинжилдэг бөгөөд Монгол Улс 2019 онд 53 оноотойгоор 141 орноос 102 дугаар байрт эрэмбэлэгдсэн. Өрсөлдөх чадварт нөлөөлж буй үзүүлэлтүүдийг салбар бүрээр шинжилж үзвэл дараах байдлаар дүгнэж болохоор байна.

Тулгуур 1: Институц (90-р байр, 49.8 оноо)

Засгийн газрын бодлогын тогтвортой байдал болон өмчийн эрхийн үзүүлэлтүүд доогуур байгаа нь институцын чадавхад сөргөөр нөлөөлж байна. Тус бүлгийг аюулгүй байдал, хууль хяналтын тэнцвэрт байдал, төрийн гүйцэтгэл, эд хөрөнгийн эрх, компанийн засаглал, Засгийн газрын чиг баримжаа гэсэн нийт 8 бүлэг 26 үзүүлэлтээр хэмждэг.

Аюулгүй байдал (71-р байр, 74.1 оноо)-ын үзүүлэлтэд терроризмын тохиолдол бүртгэгдээгүй нь эзрэг нөлөө үзүүлж байна. Гэсэн хэдий ч иргэдийн хууль, хүчний байгууллагад итгэх итгэл, хүн амины гэмт хэргийн тувшиний үзүүлэлтүүд нь 80.7 болон 50.7 оноогоор 91 болон 100 дугаар байрт тус тус эрэмбэлэгдсэн байна.

Хууль хяналтын байгууллагын тэнцвэрт байдал (90-р байр, 45.5 оноо) үзүүлэлт нь шүүх засаглал хараат бусаар ажиллаж чадахгүй байгааг илэрхийлж байна. Тус үзүүлэлтийг төсвийн ил тод байдал, шүүгчийн хараат бус байдал, хууль эрх зүйн тогтолцооны үр ашигт байдал, хэвлэлийн эрх чөлөө гэсэн 4 үзүүлэлтээр хэмжиж байгаа бөгөөд Монгол Улс 45.5 оноогоор 90 дүгээрт эрэмбэлэгджээ. Энэхүү үзүүлэлтүүд доогуур үнэлгээтэй байгаа нь шүүх засаглал хараат бусаар ажиллаж чадахгүй, хуулийн тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна. Шүүхийн хараат бус байдлын үзүүлэлт 25.7 оноогоор 120 дугаарт байгаа бол төсвийн ил тод байдлын үзүүлэлтээр 50 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлт (95-р байр, 45.5 оноо) нь төрийн зохицуулалт хувийн хэвшилд ихээхэн саад бэрхшээл үүсгэдэг бөгөөд хууль эрх зүйн орчны үр ашигт байдал сул байгааг илэрхийлжээ. Харин Засгийн газраас иргэдэд мэдээллээр хангах ажлыг хөнгөвчлөх онлайн үйлчилгээний ашиглалтыг үнэлдэг Цахим оролцооны индекс 73.6 оноогоор 63 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Ил тод байдлын үзүүлэлт (81-р байр, 37 оноо) манай улсын авлига, албан тушаалын гэмт хэргийн тоо буурахгүй байгааг илэрхийлж байна. Тус үзүүлэлтийг авлигын индексийн оноогоор хэмждэг бөгөөд доогуур байр эзэлсэн нь нийгэм, здийн засгийн хөгжил, улс төрийн шинэчлэлд авлига чөдөр тушаа болсоор байгааг илтгэж байна.

Өмчийн эрхийн үзүүлэлт (113-р байр, 41.6 оноо) оюуны өмч, өмчийн эрх, тэр дундаа санхүүгийн хөрөнгийг хамгаалах тогтолцоо бүрдээгүйг илэрхийлж байна. Монгол Улс эд хөренгө тэр дундаа санхүүгийн хөрөнгийн хамгааллын үзүүлэлтээр 42.2 оноогоор 124 дүгээр байр, оюуны өмчийн хамгааллын үзүүлэлтээр 34.3 оноогоор 131 дүгээр байрт байгаа нь эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Компанийн засаглал (127-р байр, 37.2 оноо)-аас санхүүгийн аудит, тайлагналын стандартын үзүүлэлт сул байна. Компанийн засаглалыг аудит, нягтлан бодох бүртгэлийн стандартын биелэлт, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, хувьцаа зээмшигчдийн засаглалын үзүүлэлтээр хэмждэг бөгөөд санхүүгийн аудит, тайлагналын стандартын үзүүлэлтээр 48.2 оноогоор 116 дугаар байрт эрэмбэлэгдэж байгаа нь бүлгийн үзүүлэлтийг хойш татаж байна.

Засгийн газрын бодлогын тогтвортой байдал (64-р байр, 61.4 оноо)-ын үзүүлэлт бизнес эрхлэх бодлогын орчин тогтвортой байдал, сүл байгааг илэрхийлж байна. Монгол Улсын Засгийн газрын өөрчлөлтэд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх байдлын үзүүлэлт 25.9 оноотойгоор 129 дүгээр байр, хууль эрх зүйн орчны дижитал бизнесийн загварт дасан зохицох чадвар 32.7 оноотойгоор 117 дугаар байрт байгаагаас харахад төрийн бодлого тогтвортой, засгийн газар, төрийн захиргааны байгууллагудын бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх чадавх сүл гэж үнэлжээ.

Тулгуур 2: Дэд бүтэц (101 -р байр, 56.6 оноо)
Тээврийн дэд бүтцийн үр ашиг (119-р байр, 35.5 оноо)-ийн үзүүлэлтээр бүх төрлийн тээврийн үр ашиг доогуур байна. Тус үзүүлэлтийг тооцоходо авто зам, төмөр зам, агаарын тээвэр, усан замын тээврийн дэд бүтцүүдийн чанар, хүртээмж, нягтаршил, үр ашигийн үзүүлэлтүүдийг харгалзаж үздэг. Авто замын чанар хүртээмжийн үзүүлэлтээр 112 дугаар байр (59.2 оноо), мөн агаар (31.5 оноо)-ын болон усан замын тээвэр (10.2 оноо)-ийн үзүүлэлт мөн 97 болон 137 дугаар байруудад байна.

Ашиглалтын дэд бүтцийн үзүүлэлт (91-р байр, 77.6 оноо)-д эрчим хүчний хүртээмжийн сүл байдал нөлөөлж байна. Тус багц үзүүлэлтийг эрчим хүчинд холбогдсон байдал, хангамжийн чанар, ундны уснаас халдвартлах эрсдэл, ус хангамжийн найдвартай

байдал зэрэг 4 үзүүлэлтээр тооцдогоос эрчим хүчний чанарын үзүүлэлтээр хамгийн өндөр буюу 92.1 оноогоор 73 дугаар байранд эрэмбэлэгдэж, хүртээмжийн үзүүлэлтээр тааруу буюу 90.8 оноогоор 99 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Тулгуур 3: Мэдээлэл, харилцаа холбооны технологи нэвтрүүлэлт (96-р байр, 46.5 оноо)

Мэдээлэл, харилцаа холбооны технологи нэвтрүүлэлтийг үүрэн телефон, гар утас, өргөн зурvasын болон кабелийн интернэтийн хүртээмжийн үзүүлэлтээр хэмждэг. Гар утас хэрэглэгчийн хүртээмж харьцангуй сайн (36-р байр, 100 оноо) гэж үнэлэгдсэн бол интернэтийн хүртээмжийн үзүүлэлтээр 119 дүгээр байр (23.7 оноо)-т эрэмбэлэгджээ.

Тулгуур 4: Макро здийн засгийн тогтвортой байдал (120-р байр, 66.7 оноо)
Макро здийн засгийн тогтвортой байдалд өрийн динамикийн үзүүлэлт муу байгаа нь нөлөөлж байна. Инфляц болон өрийн динамик гэсэн 2 үндсэн үзүүлэлтээр тогтвортой байдлыг хэмждэг бөгөөд хэрэглээний үнийн индексийн жилийн дундаж өөрчлөлтийг харуулдаг инфляцын үзүүлэлтээр Монгол Улс 94.1 оноогоор 116 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Харин өрийн динамикийг улсын зээлжих зэрэглэл болон өрийн ДНБ-д эзлэх хувийг харгалзан үнэлэх ба 39.3 оноогоор 129 дүгээрт эрэмбэлэгджээ. Макро здийн засгийн тогтвортой байдлаар бусад 11 тулгууртай харьцуулахад хамгийн муу эрэмбэтэй байна.

Тулгуур 5: Эрүүл мэнд (106-р байр, 63.3 оноо)

Улс орны эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт нь чанартай дундаж наслалт юм. Тус үзүүлэлтийг тооцоходоо хүн амын төрөхөөс нас барах хүртэлх хугацаанд эрүүл амьдрах боломжтой жилийг нас барагт болон хөгжлийн бэрхшээлийн үзүүлэлтүүдийг хамааруулан тооцдог. Монгол Улсын хувьд хойгур байр (106-р байр, 63.3 оноо)-т байгаа бол хүн амын чанартай дундаж наслалт өндөртэй орнуудад Испани, Итали, Ирланд, Япон зэрэг орнууд 91-92 оноогоор эхний 4 байрт эрэмбэлэгджээ.

Тулгуур 6: Ур чадвар (87-р байр, 52.4 оноо)

Ажиллах хүчний ур чадварыг одоогийн болон ирээдүйн ажиллах хүчин гэсэн 2 үндсэн хэсэгт хувааж үзэх бөгөөд одоогийн ажиллах хүчний ур чадварын үзүүлэлт хамгийн муу байна. Өнөөгийн ажиллах хүчний боловсролын түвшнийг сургуульд суралцсан дундаж хугацаагаар, ирээдүйн ажиллах хүчний боловсролыг суралцахаар хүлээгдэж буй дундаж жилээр хэмжих бөгөөд энэ 2 үзүүлэлтийн хувьд 52.4 (87-р байр) болон 60.7 оноо (97-р байр)-той үнэлэгджээ.

Өнөөгийн ажиллах хүчний ур чадвар (119-р байр, 41.5 оноо)-ыг ажилтнуудын сургалтын цар хүрээ, мэргэжлийн сургалтын болон төгсгөгчдийн ур чадвар, идэвхтэй хүн амын тоон бичиг үсгийн ур чадвар, чадварлаг ажилчдыг олоход хялбар байдал гэсэн 4 үзүүлэлтээр хэмждэг. Аж ахуйн нэгжүүд сул орон тоогоо нөхөхөд шаардлагатай ур чадвартай ажилчдыг олж чадаж буй эсэхийг хэмждэг чадварлаг ажилчдыг олоход хялбар байдал гэсэн үзүүлэлтээр 29.9 оноотойгоор судалгаанд хамрагдагч орнуудаас сүүлээсээ 2-т буюу 140 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Ирээдүйн ажиллах хүчний ур чадвар (113-р байр, 40.3 оноо)-ыг шүүмжлэлт сэтгэлгээнд тулгуурласан заах арга зүй, бага боловсролын сургуулийн багш, сурагчийн харьцаа гэсэн 2 үзүүлэлтээр хэмждэг бөгөөд харгалзан 31.6 (114-р байр), 49.1 оноо (110-р байр)-той байна.

Тулгуур 7: Бүтээгдэхүүний зах зээл (106-р байр, 50 оноо)

Монгол Улсын бүтээгдэхүүний зах зээлийг цөөн тооны, томоохон аж ахуйн нэгжүүд эзэмшидэг болохыг бүтээгдэхүүний зах зээлийн үзүүлэлт илэрхийлж байна. Мөн

терийн татвар, татаасын бодлого нь өрсөлдөөнд серөг нөлөө үзүүлдэг бөгөөд хилийн нэвтрүүлэлтийн үр ашиг доогуур байгаа нь зах зээлийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Дотоодын зах зээлийн өрсөлдөөн (133-р байр, 38.8 оноо) сул байна. Тус үзүүлэлтийг тодорхойлоходо татвар, татаасыг гажуудуулах нөлөө, зах зээлийн нöёрхлын байдал болон бүх түвшний үйлчилгээний салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг харгалzan тооцдог. Энэ бүлгийн үзүүлэлт 38.8 оноогоор 133 дугаарт эрэмбэлэгдсэн нь зах зээлийг цөөн тооны аж ахуйн нэгж эзэмшдэг, териин татвар, татаасын бодлого нь өрсөлдөөнд мөн серөг нөлөө үзүүлдэг болохыг илтгэж байна.

Харин худалдааны нээлттэй байдал (133-р байр, 38.8 оноо)-д тарифын зохицуулалтын хүндрэл бага байгаа нь зерэг нөлөө үзүүлсэн байна. Тус багц үзүүлэлтийг тарифын бус саад бэрхшээл, худалдааны тариф, тарифын зохицуулалтын хүндрэл, хил нэвтрүүлэлтийн үр ашиг зэрэг 4 үзүүлэлтийг үнэлж, тооцдог. Манай улсын хувьд тарифын зохицуулалтын хүндрэл харьцангуй багатай буюу 96.1 оноогоор 5 дугаарт эрэмбэлэгдсэн бол тарифын бус хязгаарлалт болон хил нэвтрүүлэлтийн үр ашиг маш муу буюу тус тус 49.9 болон 30.6 оноотой байна.

Тулгуур 8: Хөдөлмөрийн зах зээл (42-р байр, 64.0 оноо)

Уян хатан байдал, хөдөлмөрийн урамшуулал ба мерит зарчмыг хэмждэг хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтээр бусад 11 тулгуураас хамгийн дээгүүрт буюу 42 дугаар байрт эрэмбэлэгдэж байна. Үүнд урамшуулал ба мерит зарчмын үзүүлэлт, тэр дундаа ажлын байрны төлбөрийн үзүүлэлтийн өндөр оноо (43-р байр, 93.9 оноо) нөлөөлжээ.

Уян хатан байдал (69-р байр, 57.4 оноо)-ыг ажлаас халах зардал, ажилд авах, халах үйл явц, хөдөлмөр-ажил олгогчийн харилцаанд хамтын ажиллагаа, цалин тогтоох уян хатан байдал, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого, ажилчдын эрх, гадаадаас ажиллах хүч авахад хялбар байдал, хөдөлмөрийн дотоод шилжих хөдөлгөөн гэсэн 8 үзүүлэлтээр хэмждэг. Хамгийн өндөр оноотой ажлаас халах зардлын үзүүлэлт (17-р байр, 90.4 оноо) нь ажилтныг ажлаас халах үеийн урьдчилсан мэдэгдэл болон халагдсаны төлбөрийн зардлыг долоо хоногийн цалингаар илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд энэ зардал бага байх нь хөдөлмөрийн шилжилтэд зерэг нөлөөтэй.

Хөдөлмөрийн урамшуулал ба мерит зарчим (31-р байр, 70.6 оноо)-ыг мэргэжлийн удирдлагатай эсэх, цалин ба бүтээмж, цалин хөлстэй эмэгтэй, болон эрэгтэй ажилчдын харьцаа, хөдөлмөрийн татварын хувь хэмжээ гэсэн 4 үзүүлэлтээр хэмждэг. Тэдгээрээс цалин хөлстэй эмэгтэй болон эрэгтэй ажилчдын харьцааны үзүүлэлт 92.7 (16-р байр), хөдөлмөрийн татвар 93.9 (43-р байр) гэсэн хамгийн өндөр оноотой үнэлэгджээ.

Тулгуур 9: Санхүүгийн систем (108-р байр, 50.5 оноо)

Санхүүгийн системийн гүнзгийрэлт, тархалт (114-р байр, 24.7 оноо)-ын үзүүлэлт манай оронд шинээр бизнес эрхлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг бага, эрсдэлтэй байгааг харуулж байна. Санхүүгийн системийн гүнзгийрэлт, тархалтыг хувийн хэвшилд олгодог дотоодын зээл, ЖДҮ-ийн санхүүжилт, венчур хөрөнгийн хүртээмж, зах зээлийн үнэлгээ, даатгалд хамрагдалтын түвшин гэсэн үндсэн 5 үзүүлэлтээр хэмждэг бөгөөд Монгол Улс тус бүлэг үзүүлэлтээр 24.7 оноогоор 114 дүгээрт эрэмбэлэгджээ. Ийнхүү тааруу үнэлэгдэхэд ЖДҮ-ийн санхүүжилт, венчур хөрөнгийн хүртээмж, даатгалын үзүүлэлтүүд 7.0-32.2 хүртэл оноог авч 122-124 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь нөлөөлжээ.

Санхүүгийн системийн тогтвортой байдал (104-р байр, 82.8 оноо)-д зээлийн чанар, дотоодын хувийн хэвшилд олгосон зээл болон банкны өөрийн капиталын чадамж чухал нөлөөтэй байна. Бусад үзүүлэлтийн хувьд тааруу байгаа ч зээлийн зөрүү (credit gap)-гийн үзүүлэлтээр 100 оноо авч нэгдүгээрт эрэмбэлэгдсэн нь тус бүлэг үзүүлэлтийн

оноог сайжруулахад нөлөөлсөн байна. Зээлийн зөрүү нь хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь болон түүний урт хугацааны тренд хоорондын зөрүүг илэрхийлэх бөгөөд санхүүгийн хямралыг урьдчилан таамаглахад ашигладаг гол үзүүлэлтүүдийн нэг юм.

Тулгуур 10: Зах зээлийн хэмжээ (103-р байр, 41.8 оноо)

Олон улсад зах зээлийн хүчин чадлыг дотоодын нийт бүтээгдэхүүн болон бараа, үйлчилгээний импортын хэмжээгээр илэрхийлдэг. ДНБ-д зэлзэх бараа, үйлчилгээний импортын үзүүлэлтээр 26 дугаарт эрэмбэлэгдсэн боловч ДНБ-ий хэмжээгээр 105 дугаарт эрэмбэлэгдсэн нь эдийн засаг тэлэх дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Тулгуур 11: Бизнесийн хурдтай өөрчлөгдөх байдал (108-р байр, 53.3 оноо)

Төлбөрийн чадваргүйдлийн зохицуулалт, нөхөн төлөлтийн түвшин муу байгаа нь бизнесийн орчны өрсөлдөх чадварт сергеөр нөлөөлж байна. Шүүхийн өөрчлөн байгуулах, татан буулгах, ерийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар барьцаалагдсан зээлдүүлэгчид нөхөн төлсөн төлбөрийн хэмжээг илэрхийлж буй үзүүлэлт 121 дүгээр байр (18.2 оноо), уг үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны нийцэл, бие даасан байдлыг хэмждэг үзүүлэлтээр 112 дугаар байр (40.6 оноо)-т жагсаж байгаа нь энэ чиглэлийн үйл ажиллагаа хангалттай бус, үр ашиггүй байгааг илэрхийлж байна.

Эрх мэдлээ шилжүүлэх хүсэл эрмэлзэл, тодорхой бус бизнесийн санааг хүлээн зөвшөөрч буй байдал бага байгаа нь энтрепренер сэтгэлгээний өрсөлдөх чадварыг бууруулж байна. Удирдах албан тушаалтнууд доод албан тушаалтандaa эрх мэдлээ шилжүүлэх хүсэл эрмэлзлийн үзүүлэлтээр 130 дугаар байр (40.8 оноо), тодорхой бус, эрсдэлтэй, шинэлэг бизнесийн санааг компаниуд хүлээн зөвшөөрч, дэмжих хандлагын үзүүлэлт 84 дүгээр байр (41.4 оноо)-т тус тус эрэмбэлэгдсэн байна.

Тулгуур 12: Инновацын чадавх (93-р байр, 32.3 оноо)

Ажиллах хүчний төрөлжилт, байгууллагын дотоод хамтын ажиллагаа болон гадаад, дотоод зах зээлд нээлттэй хамтран ажиллах чадварыг илэрхийлдэг хамтын ажиллагаа ба төрөлжилт (96-р байр, 35.2 оноо)-ийн үзүүлэлтээр бага оноотой байна. Манай улсын хувьд кластерын хөгжил, хамтын ажиллагааны үзүүлэлт харьцангуй доогуур буюу 124, 105 дугаар байрт эрэмбэлэгдсэн бол нэг байгууллагад үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хүйсийн ялгавартай бүлгүүдийг ажиллуулдаг байдлаараа 34 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Улс орон судалгаа, хөгжүүлэлт (107-р байр, 20.2 оноо)-д хэрхэн анхаарал хандуулж буйг судалгаа, хөгжүүлэлтийн зардлын ДНБ-д зэлзэх хувиар тодорхойлдог. Тус бүлэг үзүүлэлтийг шинжлэх ухааны бүтээл, патентын мэдүүлгийн тоо болон судалгааны байгууллагуудын нэр хүндийн түвшнээр хэмждэг. Манай улс шинжлэх ухааны бүтээлийн тоогоор 65.9 оноотой 110 дугаар байр, патентын мэдүүлгийн хувьд 9.9 оноотой 73 дугаар байр, судалгаа, хөгжүүлэлтийн зардлын үзүүлэлтээр 4.5 оноотой 103 дугаар байр, судалгааны байгууллагуудын нэр хүндээр 0.4 оноотой 112 дугаар байрт байгаа нь судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Зах зээлд нэвтрэлт (86-р байр, 50.9 оноо) нь шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох орчны үзүүлэлт юм. Худалдан авагчийн боловсролын түвшний үзүүлэлт 36.9 оноотой 96 дугаар байр, барааны тэмдгийн мэдүүлгийн тоо 64.8 оноотой 79 дүгээр байрт тус тус эрэмбэлэгдсэн нь зах зээлд шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох орчин муу байгааг харуулж байна.

Тулгуур 12 булгийн хувьд Монгол Улсын өрсөлдөх чадварыг шинжлэхэд макро эдийн засгийн тогтвортой байдлын хувьд 120 дугаар байр (141 орноос)-т эрэмбэлэгдсэн нь бусад 11

тулгуур бүлэгтэй харьцуулахад хамгийн муу эрэмбэ юм. Мөн санхүүгийн систем, зах зээлийн хэмжээ, бизнесийн хурдтай өөрчлөгдөх байдал, эрүүл мэнд, бүтээгдэхүүний зэх зээл, дэд бүтэц зэрэг тулгуур бүлгийн үзүүлэлтүүд 101-108 дугаарт эрэмбэлэгдэж, ерөнхий өрсөлдөх чадварын үзүүлэлт доогуур үнэлэгдэхэд голлох нөлөө үзүүлж байна.

Инновациын чадавхын бүлэг үзүүлэлтээр хамгийн бага оноотой үнэлэгдсэн ба үүнд судалгаа, хөгжүүлэлтийн зардлын ДНБ-д эзлэх хувь, гадаад хүнтэй хамтран эзэмшдэг патентын тоо, судалгааны байгууллагуудын нэр хүндийн үзүүлэлт 5-аас доош буюу маш бага оноотой байгаа нь нелөөлжээ.

Хөдөлмерийн зах зээлийн бүлэг үзүүлэлтээс бусад бүлгүүдийн хувьд олон улсын түвшинд 90-с хойгуур байрт эрэмбэлэгдэж байна.

103 үзүүлэлтийн түвшинд авч үзвэл, терроризмын тохиолдол, мобайл үүрэн телефоны хүртээмж, банкны зохицуулалтын хөрөнгийн харьцаа зэрэг үзүүлэлтүүд хамгийн өндөр буюу 100 оноотой, судалгааны байгууллагуудын нэр хүндийн үзүүлэлт, судалгаа, хөгжүүлэлтийн зардлын ДНБ-д эзлэх хувь, гадаад хүнтэй хамтран эзэмшдэг патентын тоо, төмөр замын нягтаршил зэрэг үзүүлэлтүүд хамгийн сүл буюу 5-аас бага оноотой байна.

Ийнхүү, Монгол Улсын өрсөлдөх чадвар бүх талаараа сүл байгаа нь эдийн засаг тэлэхгүй, экспортын нэр төрөл нэмэгдэхгүй, гадаад өр буурахгүй, гадаадын хөрөнгө оруулалт өсөхгүй, бизнес шинээр хөгжихгүй, бүх салбарын бүтээмж үр ашиг дээшлэхгүй, нэг хүнд ногдох орлого дорвигий өсөхгүй байх гол шалтгаан болж байна.


7.3. Тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Олон улсын өрсөлдөх чадварын тайлангийн үр дүнд тулгуурлан Монгол Улсын өрсөлдөх чадвар доогуур үнэлэгдэхэд нелөөлж буй гол шалтгаануудыг тодорхойллоо. Макро эдийн засаг тогтвортгүй, бизнесийн орчин, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи нэвтрүүлэх инновацийн хөгжил сул, дэд бүтцийн чанар, хүртээмж мую, засаглалын чадавх мую, хөдөлмөрийн бүтээмж доогуур, уур амьсгалын өөрчлөлт, эмзэг байдал нэмэгдэж байгаа зэрэг үндсэн асуудлууд өрсөлдөх чадварын үзүүлэлтэд сөргөөр нелөөлж байна. Бизнес эрхлэх орчин мую, суурь дэд бүтэц хангалтгүй, зардал өндөр, хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэгтэй хүний нөөц дутмаг байна. Мөн бүтээмжгүй, хоцрогдсон технологитой, бүтээгдэхүүний чанараар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сул, экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл, гадаад эрэлтийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлсээс хамаарах эмзэг бүтэц нь өрсөлдөх чадварыг хойш татаж буй гол шалтгаанууд болж байна.

Төсвийн зохистой бодлого хэрэгжүүлж, гадаад өрийн дарамтыг бууруулахгүйгээр макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдэхээргүй байна.

Эдийн засгийн өрөөсгөл, эмзэг бүтэцтэй, нэг салбараас хараат байгаа нь өсөлт тогтвортгүй байх суурь шалтгаан болж байна. 2004 оноос уул уурхайн эдийн засагт үзүүлэх нелөө нэмэгдсэнээр эдийн засаг дунджаар 7.2 хувиар өссөн хэдий ч өсөлт -4.6 хувиас +17.3 хувийн хооронд огцом хэлбэлзэж байв. хамаарал улам нэмэгдсэн.

Зураг 5858. Эдийн засгийн өсөлт ба түүхий эдийн үнийн хамаарал, 1991-2021 он




Байгалийн баялгийн эдийн засагт үзүүлэх нелөө нэмэгдэх тусам түүхий эдийн үнэ, экспортоос хараат байдал улам ихэссэн. 2020 онд эдийн засгийн өсөлтийн хэлбэлзлийн 21 хувь нь түүхий эдийн үнээс шалтгаалж байгаа нь байгалийн баялгийн олборлолт өсөлтэд голлох нелөөтэй хэвээр байгаа бөгөөд эдийн засагт шаардлагатай бүтцийн өөрчлөлтийг хийж чадаагүй харуулж байна.

Эдийн засгийн өсөлт тогтвортгүй байх нь цаашдын тодорхой бус байдлыг үүсгэж, эдийн засгийн үр ашгийг бууруулах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нелөөлөхөөс гадна нийгмийн сайхны үзүүлэлтүүдэд сөргөөр нелөөлж, хөгжлийн түвшнийг бууруулж байна.


Технологи, инновац, хүмүүн капиталаар өдеөгдсөн өсөлт бий болохгүй байгаа нь бүтээмж бүх салбарт доогуур байх шалтгаан болж байна. Экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр жилүүдэд уул уурхайн салбар тэлж, ДНБ-д эзлэх хувь өссөн хэдий ч уг өсөлтөд хүний неөөцийн ур чадвар, технологи бүтээмжийн өсөлтийн нелөө харьцангуй бага байв. 2005 оноос хойших эдийн засгийн өсөлтийг биет капитал бүрдүүлж ирсэн бөгөөд урт хугацааны хөгжлийн суурийг бүрдүүлэгч гол хүчин зүйлс болох технологийн бүтээмж ихэнх тохиолдолд өсөлтөд серэг нелөө үзүүлж байсан бол хүмүүн капиталын оролцоо маш бага байв. Байгалийн неөөцед сууриссан биет капиталын бүтээмж уул уурхайн салбарт төвлөрч, бусад салбарт бүтээмж маш бага байна. Энэ нь эргээд хөрөнгө оруулалт татах боломжид нелөөлөх бөгөөд нэг салбараас хараат байдлыг улам нэмэгдүүлнэ.

Зураг 5959. Эдийн засгийн өсөлтийн бүтэц, 1999-2017 он



Эх сурвалж: Уул уурхай ба оюун ухаан, Дэлхийн банк, 2020 он

Зураг 6060. Эдийн засгийн өсөлтийн хэлбэлзлийн шалтгаан



Эх сурвалж: Уул уурхай ба оюун ухаан, Дэлхийн банк, 2020 он


Монгол Улсын төсвийн орлого уул уурхайн орлогоос ихээхэн хамааралтайн дээр татварын суурь багатай тул алдагдал ихтэй, тогтвортой байна. Уул уурхайн орлого төсвийн орлогын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2021 онд 27 хувийг бүрдүүлсэн. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэл төсвийн орлогод шууд нелөө үзүүлэхээс гадна хөренгө оруулалт, нүүрсний экспорт буурах нь үйлдвэрлэл, хэрэглээний татварын орлогод сергеер нелөөлж, төсөвт нэмэлт дарамт үүсгэдэг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон холбогдох ногдол ашиг, үл хөдлөх хөрөнгийн ашгийн татвар зэрэг шууд татварууд ч огцом буурдаг.

Төсвийн орлогын тогтвортой байдлаас гадна халамж, амлалтаас үүдэлтэй төсвийн зарлага ихээхэн нэмэгдсээр байгаа нь төсвийн алдагдлыг өсгөж, Засгийн газрын өр нэмэгдэх гол хүчин зүйл болж байна. 2016 оны байдлаар өрхийн орлогын 20 хувийг тэтгэвэр, тэтгэмж, халамж эзэлдэг байсан бол 2021 онд 30 хувь болон нэмэгдсэн нь төсвийн зарлагын өсслт, цаашлаад алдагдлын нэг шалтгаан болж байна.

2010 онд ДНБ-ий 31.6 хувьтай тэнцэж байсан төсвийн зардал 2020 онд ДНБ-ий 37.1 хувь болж өссөн нь үндсэндээ нийгмийн халамжийн тэлэлттэй холбоотой байна. Нийгмийн халамжийн зардал 2019 онд ДНБ-ий 8 хувь байсан бол 2020 онд 13 хувь болж өссөн нь төсөөтэй орнуудтай харьцуулахад ихээхэн өндөр байна.

Мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжүүлсээр ирсэн нь эдийг засагт бүтцийн шинэчлэлт хийгдэхгүй, эмзэг өрөөсгөл хэвээр байхад нелөөлж байна. Эдийн засгийн дундаж өсслт өндөр (2007-2019 онуудад 7.2 хувь) байсан нь дэд бүтэц, нийгмийн бүтээн байгуулалт хийж, эдийн засгийн сууриа бэхжүүлэх боломж олгосон. Гэсэн хэдий ч түүхий эдийн үнийн уналт, өсслтийн мөчлөг серсөн төсвийн бодлого хэрэгжүүлж чадаагүйн улмаас төсвийн алдагдал сүүлийн 10 жилд 9 удаа алдагдалтай гарав. Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнийн өсслтийн үед орлогоо хуримтлуулж, эдийн засаг хүндрэлтэй жилүүдэд ачааллыг хуваалцаж, алдагдлыг бууруулах бодлогыг оновчтой хэрэгжүүлж чадаагүй байна. Үүний үр дүнд уул уурхайн түүхий эдийн үнээс хэт хамааралтай, гадаад өр өндөр, нийгмийн үйлчилгээний хүртээмж муу, хүн амын 27.8 хувь нь ядуурал бүхий эдийн засгийн эмзэг бүтцийг бий болгожээ. Мөн Монгол Улс ОУВС-гийн зургаан удаагийн зээлийн хөтөлбөрт хамрагдсан нь байгалийн баялгаа макро эдийн засгийн бодлогын хүрээнд үр дүнтэй удирдан шийдвэрлэж чадахгүй байсныг харуулж байна.

Зураг 6161. Түүхий эдийн үнийн уналт, сэргэлтийн мөчлөг




хуримтлагдсаар ирсэн нь өрийн тогтвортой байдлыг алдагдуулж, макро эдийн засгийн эрсдэлт байдлыг нэмэгдүүлж байна. Нийт гадаад өр 2022 оны эхний улиралд 33.9 тэрбум ам.долларт хүрч ДНБ-ий 224.2 орчим хувьтай тэнцэж байгаа бөгөөд бүтцийн хувьд 37.1 хувийг

Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөр


шууд хөрөнгө оруулалтын компани хоорондын зээллэг, 26.3 хувийг банкнаас бусад салбаруудын өр бүрдүүлж байна. Харин Засгийн газрын өр нийт өрийн 24.7 хувийг бүрдүүлж, нэрлэсэн дунгээр ДНБ-ий 62.6 хувьтай тэнцэж байна. Нийт гадаад өрийг хугацаагаар нь харвал урт хугацаат өр 58.4 хувийг, шууд хөрөнгө оруулалтын компани хоорондын зээллэг 37.1 хувийг, богино хугацаат өр 4.5 хувийг эзэлж байна.

Зураг 6262. Монгол Улсын нийт гадаад өрийн бүтэц, 2019-2022 он



Монгол Улсын 2022 оны гадаад санхүүжилтийн хэрэгцээний ДНБ-д эзлэх хувийг Ази, номхон далайн бусад орнууд болон шинээр гарч ирж буй хөгжих буй орнуудын дундажтай харьцуулахад хамгийн өндөр байна. Үүнд урт хугацаат өрийн үйлчилгээний төлбөр хамгийн өндөр хувийг эзлэх ба харьцуулагч бусад орнуудаас хамгийн их хувийг эзэлж байна. Урсгал дансны алдагдал мөн их байгаа нь шаардагдах богино хугацаат өр болон өрийн үйлчилгээний төлбөрийн дарамтыг улам ихэсгэж байна. Уул уурхайн орлогын өсөлтөөс шалтгаалсан төсвийн орлого өндөр үеүдэд мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжүүлсний улмаас төсвийн алдагдлыг ихэсгэж, ДНБ-ий 50.8 хувьтай тэнцэхүйц хэмжээний өр хуримтлагдах шалтгаан болжээ.

Зураг 6363. Гадаад зах зээлийн эмзэг байдал



Төсөв, мөнгөний бодлогын орон зай бага, хүлээгдэж буй гадаад санхүүжилтийн хэрэгцээ өндөр байгаа тул төсвийн тогтвортгуй байдал цаашид үргэлжлэх хандлагатай

байна. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь бусад Зүүн Азийн орнуудаас хамгийн өндөр байгаа байгаа бол БНХАУ-ын хилийн хориг болон ОХУ-Украины дайнаас үүдэлтэй нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалсан инфляц зорилтот түвшнээс даруй 6 хувиар, харьцуулагч орнуудаас даруй 4 хувиар илүү байгаа нь 2022 онд төсвийн болон мөнгөний орон зайд маш бага байгааг харуулж байна.

Хүснэгт 22. Зүүн Азийн хөгжж буй орнуудын төсвийн болон мөнгөний бодлогын орон зайд

Улсууд	Сангийн бодлого						Мөнгөний бодлого			Нөөц	
	Засгийн газрын өр (ДНБ-д эзлэх хувь)	Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	Хувийн хэвшилд олгосон дотоодын зээл (ДНБ-д эзлэх хувь)	Бодлогын хувь, хувь		Инфляц, хувь	Инфляцийн зорилт	Валютын нөөц, импортын сараар			
				2021	Δ	2021	Δ	2022 он	2021	Δ	
Камбож	35	5	-5.7	-6	143	52	3.7	3.7	9.5	2	
БНХАУ	45	-5	-4.4	0	205	17	3.7	-1	12.8	-4	
Индонези	41	12	-4.6	-2	39	1	3.5	-2	8	0	
Лаос	78	21	-1.4	4	46	5	3	-1	3.1	1	
Малайз	64	8	-6.4	-4	145	14	1.8	-1	2.5-4.00	2	
Монгол	80	4	-3.1	1	46	-7	6.5	-5	9.1	2	
Мьянмар	57	19	-8.8	-5	27	2	7	-3	8.3	1	
Филиппин	55	17	-8.6	-8	52	2	2	-2	7.2	2	
Тайланд	58	16	-7.8	-8	135	13	0.5	-1	2.0-4.0	2	
Вьетнам	45	0	-3.8	-1	117	-9	2.5	-2	10.3	1	
							1.4	<4	9.9	1	
									5.3	2	

Δ 2015-2019 оны дундажтай харьцуулсан хувь

Эх сурвалж: Braving storms, East Asia and the Pacific economic update, World bank

Макро эдийн засаг ийнхүү тогтвортой явж ирсэн нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг сулруулж байна. Уул уурхайн салбарын өсөлтийг дагасан төсөв, мөнгөний бодлого хөөснөхгарал гэсэн мечлэгийг үүсгэж ирсэн нь эдийн засгийн тогтвортой, олон тулгуурт өсөлтийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл, мечлөг дагасан төсөв, мөнгөний бодлого нь түүхий эдийн үнээс үүдэлтэй хэлбэлзлийг тогтвортжуулах бус, улам тогтвортгүйжүүлэх шалтгаан болсоор иржээ.

Дотоодын хуримтлалаас давсан хөрөнгө оруулалтыг гадаад валютаар санхүүжүүлж, өрийн тогтвортой байдлыг нэмэгдүүлж байгаа тул санхүүгийн зах зээлийн төлөв эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй байна. Нийт хуримтлалаас давсан хөрөнгө оруулалтын эрэлтийг ГШХО, гадаад зээлээр санхүүжүүлж байгаа нь урсгал тэнцлийн алдагдлыг бий болгож, өр нэмэгдэх шалтгаан болж байна. 2007 оноос хойш хөрөнгө оруулалтын дийлэнхийг бүрдүүлдэг хувийн хөрөнгө оруулалт багасаад байсан ч 2021 оны эхний улирлаас сэргэж, эдийн засаг идэвхжиж, 2022 оны эхний улиралд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хадгаламжийн зөрүү ДНБ-ий 45.1 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөр



Эх сурвалж: Монголбанк

Зураг 6565. Хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү, ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк, тооцоолол

Зураг 6666. Санхүү, эрдсийн үнэ, бодит эдийн засгийн мөчлөг, 2000-2020 он



Эх сурвалж: Монголбанк

Компанийн засаглалыг сайжруулж, санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэхгүйгээр бизнесийн орчин сайжрахгүй байна.

Бизнес эрхлэгчид Монгол Улсын бизнес эрхлэх орчныг “дунд” гэж дүгнэсэн байна. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын худалдааг дэмжих тесел, Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургууль хамтран Монголын бизнесийн орчны судалгааг сүүлийн жилүүдэд тогтмол хийж байна. “Эдийн засаг”, “Засаглал, хууль эрх зүй”, “Дэд бүтэц, технологи”, “Нийгэм соёл”, “Байгууллагын дотоод орчин” гэсэн ерөнхий 5 бүлгээр дүгнэн үзэхэд 2020 онд бизнесийн орчны ерөнхий үнэлгээ 2.91 оноо буюу дунд гэж үнэлгэдсэн нь 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.46 нэгжээр сайжирсан байна. Сүүлийн 3 жилд дэд бүтэц, технологийн орчны үнэлгээ хамгийн ихээр сайжирсан (0.69 нэгжээр дээшилсэн) бол Эдийн засгийн орчин, Засаглал, хууль эрх зүйн орчны хувьд хамгийн бага ахицтай байна.

Хүснэгт 23. Монголын бизнесийн орчны үнэлгээ, ерөнхий үзүүлэлтээр

Үзүүлэлтүүд	2017 оны орчны үнэлгээ*	2020 оны орчны үнэлгээ	Өөрчлөлт
Дэд бүтэц, технологийн орчин	2.54	3.23	+0.69
Байгууллагын бизнесийн үйл ажиллагаа	2.63	3.13	+0.50
Нийгэм, соёлын орчин	2.38	2.87	+0.49
Эдийн засгийн орчин	2.4	2.67	+0.27
Засаглал, хууль эрх зүйн орчин	2.28	2.66	+0.38
Үнэлгээний дундаж	2.45	2.91	+0.46

Тайлбар: * Бизнесийн орчны үнэлгээнд: 1-маш муюу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн

Эх үүсвэр: Монголын бизнесийн орчин-2020, Судалгааны тайлан

Хувийн хэвшлийн бизнес эрхлэх орчныг нарийвчлан судалж үзвэл аж ахуйн нэгжүүд бизнесээ санхүүжүүлэх эх үүсвэр олоход төвөгтэй, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахад хүндрэлтэй, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагаа тодорхойгүй байгаа нь бизнес эрхлэхэд саад учруулж байна гэж үзсэн. Харин татварын орчин, шинэ бизнес болон өмч хөрөнгөө бүртгүүлэх үйл явц, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашигийг хамгаалах байдал дундаж түвшинд гэсэн байна.

Шинэ бизнес эрхлэх боломж: Монгол Улсад шинээр бизнес эрхлэхэд хүндрэлтэй (2.44) байгаа нь судалгааны дүнгээр харагдсан байна. Ялангуяа бизнесээ эхлүүлэхэд хөрөнгө, санхүүжилт дутагдалтай (2.17), шинэ бизнес эхлүүлэх зардал гаргахад хүндрэлтэй (2.35), бизнес эрхлэхэд шаардлагатай техникийн нөхцөл, зөвшөөрлийн процесс төвөгтэй, хүнд сурталтай (2.34) гэжээ.

Бизнесийн дэмжлэг: Төрийн ба төрийн бус байгууллагуудын бизнест үзүүлдэг дэмжлэгийн талаар судалгаанд оролцогчид үнэлэхдээ арилжааны банкнууд, MYXAYT болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг илүү, харин эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, Олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй тесел хөтөлбөрүүд, Бизнесийн зөвлөгөө өгөх төвүүдийн бизнес дэх дэмжлэг тааруу байдгийг илэрхийлжээ. 1.5 тэрбумаас бага орлоготой бизнес эрхлэгчид Засгийн газар, Орон нутгийн засаг захиргаа, Арилжааны банкны дэмжлэгийг, 1.5 тэрбумаас дээш орлоготой бизнес эрхлэгчдийн хувьд MYXAYT болон үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн холбоодын дэмжлэгийг чухалчилсан байна.

Өrsөлдөөний орчин: Бизнесийн өrsөлдөөний төлөвийн тухайд дийлэнх буюу 64.0 хувь нь бизнесийн гол өrsөлдөгчөө дотоодын аж ахуйн нэгжүүд гэсэн бол 21.0 хувь нь Хятадын импортын бараа, 11.0 хувь нь Монголд үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд гэж үзсэн байна. Монгол Улсад шинээр бизнес

эрхлэхэд хүндрэлтэй (2.44), ялангуяа бизнесээз эхлүүлэхэд хөрөнгө, санхүүжилт дутагдалтай (2.17), шинэ бизнес эхлүүлэх зардлыг гаргахад хүндрэлтэй (2.35), бизнес эрхлэх техникийн нөхцөл, зөвшөөрлийн процесс төвөгтэй, хүнд сурталтай (2.34) гэжээ.

Маргаан шийдвэрлэлт: Бизнесийн маргаан, гэрээний зөрчлийг шүүхээр шийдүүлдэг аж ахуйн нэгжүүд шүүхийн шударга байдлыг 2.66, шүүхийн шуурхай байдлыг 2.53 оноогоор буюу дунджаас доогуур түвшинд үнэлж байна. Энэ нь бизнесийн маргааныг харилцан тохиролцох, эсхүл хуулийн байгууллагад хандалгүй хохирч үлдэх сонголтыг хийхэд нөлөөлдөг байж болох юм.

Компанийн засаглал ба бүтээмж: Бизнесийн дотоод орчин буюу байгууллагын үйл ажиллагааг 2 дэд үзүүлэлтээр дүгнэж үзэхэд Удирдлага, зохион байгуулалт (3.34) дундаас дээгүүр буюу сайн талдаа үнэлэгдсэн бол Байгууллагын үр ашиг, бүтээмж (2.94) нь дундаас доогуур үнэлэгджээ.

Хил дамнасан худалдаа: Судалгаанд оролцогчид гадаад худалдаа эрхлэх нөхцөл байдлыг мөн хүндрэлтэй гэж үнэлсэн бөгөөд дийлэнх нь экспорт, импортын зөвшөөрөл авахад зарцуулах хугацаа их, бүрдүүлэх бичиг баримтын тоо олон, зөвшөөрөл авахад гарах зардал, төлбөр хураамжийн хэмжээ өндөр байдгийг илэрхийлсэн байна. Мөн гадаад худалдаа эрхлэхэд дотоодын тээврийн зардал өндөр, тээвэрлэлтэд зарцуулах хугацаа их, тээврийн олдоц, хүрэлцээ хангалтгүй байгаа нь сөрөг нөлөө үзүүлж байгааг дурдсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэр: Бизнес эрхлэгчдэд банк, санхүүгийн байгууллагын зээлээс бусад хэлбэрээр бизнесийн санхүүжилт авах боломж хомс (2.22) бөгөөд Засгийн газрын тусгай сангуудын дэмжлэг хүрч чадахгүй байгаа (2.17) нь санхүүжилтийн орчин муу үнэлэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.

Шигтгээ 7.1. Эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо

Эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо чухал үүрэгтэй тул хувийн хэвшлийг урамшуулах гол хөшүүргүүдийг бүрдүүлэх шаардлагатай. Манай улсын хувьд 2021 оны байдааар хувийн хэвшил ДНБ-ий 77.5 хувь, улсын төсвийн орлогын 80 орчим хувийг бүрдүүлж, нэг сая гаруй ажлын байр бий болгожээ. Эдийн засагт хувийн хэвшлийн оролцоо 2010-2013 онд хамгийн их буюу 80.1 хувьд хүрч байв. Хөдөө аж ахуйгаас гадна худалдаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, барилга, мэдээлэл холбоо болон үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбаруудад хувийн хэвшлийн оролцоо хамгийн өндөр байна.

Хүснэгт 24. ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь, салбарваар

Бүрэлдэхүүн	2012	2017	2021
ДНБ	78.7	75.5	77.5
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	100.0	100.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	99.8	99.9	100.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	99.0	99.4	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	99.7	99.9	99.8
Боловсруулах үйлдвэрлэл	95.8	98.2	98.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	97.9	98.7	98.1
Барилга	97.8	98.9	97.1
Мэдээлэл, холбоо	87.4	90.0	92.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Компанийн засаглал сүл байгаа нь урт хугацааны туршид хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн бүрэн бүтэн байдлыг хөхиүлэн дэмжихэд шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчин бүрдэхгүй байх шалтгаан болж байна. Компанийн засаглал нь хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог, компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо юм. Компанийн засаглалын кодекс⁹ нь үнэлгээний гол баримт бичиг бөгөөд компанийд засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Тус кодекст компанийн засаглалыг “компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо” гэж тодорхойлжээ.

Компанийн засаглалын үндсэн 9 зарчмыг кодекст тодорхойлсон байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, хороодын чиг үүрэг, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, аудит, хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, цалин урамшуулал, оролцогч талуудын эрх ашиг, компанийн соёл, хувьцаа эзэмшигчийн эрх зэрэг агууллыг тусгасан байна.

Улсын хэмжээнд бүх талуудыг оролцуулсан, компанийн засаглалын түвшний нэгдсэн үнэлгээ дутагдалтай байгаа нь кодексийн хэрэгжилтийг хянах тогтолцоо сүл байгааг харуулж байна. Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагч, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд кодексийн хэрэгжилтийг жил бүр¹⁰ тайлагнах, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Энэ хүрээнд компанийн засаглалын хэрэгжилтийг төлөөлөн удирдах зөвлөл хариуцаж, компанийд зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрэлдсэн эсэхэд хувьцаа эзэмшигчид хяналт тавьдаг. Гэвч энэ нь дээр дурдсан нээлттэй үйл ажиллагаа явуулдаг компаниудад хамаарах тул хаалттай компаниудын хувьд кодексийг заавал дагаж мөрдөх албагүй.

Санхүүгийн аудит, тайлагналын стандартын хэрэгжилт муу байгаа нь компанийн засаглалын үзүүлэлтэд сэргээр нөлөөлж байна. Компанийн засаглалын үзүүлэлтээр 61.4 оноогоор 141 орноос 64 дүгээрт эрэмбэлэгджээ.¹¹ Тус үзүүлэлтийг хэмжихдээ аудит, нягтлан бodoх бүртгэлийн стандартын биелэлт, хувь эзэмшигчийн засаглалын үзүүлэлт болон ашиг сонирхлын зөрчлийн үзүүлэлт гэсэн 3 үзүүлэлтийг харгалзах бөгөөд Монгол Улсын хувьд санхүүгийн аудит, тайлагналын стандартын хэрэгжилтийг үнэлдэг аудит, нягтлан бodoх бүртгэлийн стандартын биелэлтийн үзүүлэлтээр хамгийн муу буюу 48.2 оноо (116-р байр)-г авчээз.

Хувьцаа эзэмшигчийн засаглалын үзүүлэлтээр хувьцаа эзэмшигчийн засаглалын цар хүрээнд эзэмшлийн бүтэц, бие даасан захирлууд байгаа эсэх, тэдний хувь хэмжээ, гүйцэтгэх бус захирлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилох, аудитын хороо байгаа эсэхийг асуудлыг хөнддөг бол ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалтын үзүүлэлтээр захирлуудын хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн хөрөнгийг зүй бусаар ашиглахаас хувьцаа эзэмшигчийн хамгаалалтыг хэмждэг. Эдгээр үзүүлэлтүүдийг сайжруулснаар компанийн засаглалын үзүүлэлт сайжирч, нэр хүнд өсөн, хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэхээс гадна улсын ерөнхий өрсөлдөх чадварт зөргээр нөлөөлнө.

⁹ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоол

¹⁰ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын үйл ажиллаганы тайлангийн маягт”-ын дагуу тайлагнана.

¹¹ Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Дэлхийн банк, 2019 он

ГШХО-ын дийлэнх нь уул уурхайн салбарт төвлөрч, бусад салбарт ГШХО дорвитой орж ирэхгүй байгаа нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж чадахгүй байна. 1990-1999 онд жилд дунджаар 13 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж ирсэн байв. 2000-2011 онд уул уурхай, олборлох салбарын хурдацтай ёсэлтийг дагаж, тэр дундаа Оюу Толгойн ил уурхайн бүтээн байгуулалт эхэлсэнтэй холбогдуулан уул уурхайн хөрөнгө оруулалт нэмэгджээ. Сүүлийн 10 жилд нийт ГШХО-ын 60-аас дээш хувь нь уул уурхайн салбарт чиглэж, хөрөнгө оруулалт бүх салбарт үр өгөвж өгч чадахгүй байна.

Зураг 6767. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц, салбараар, 2011-2021 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үр ашиг эрэлхийлсэн хөрөнгө оруулалтын хувь хэмжээ бага байгаа нь олон улсад хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадвар сүл байгааг харуулж байна. Хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадвар гэдэг нь улс орнуудын зөвхөн хөрөнгө оруулалт татах бус мен оруулсан хөрөнгө оруулалтыг хадгалах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг эдийн засагтаа шингээх чадварыг хэлдэг. Иймд хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварыг сайжруулна гэдэг нь дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, дотоодын, бус нутгийн мөн олон улсын эдийн засагтай холбогдох, хамтын ажиллагааг бий болгоход таатай бизнесийн орчныг бүрдүүлнэ гэсэн уг юм (Дэлхийн банк, 2017).

2012-2016 онд Монгол Улсад хийгдсэн ГШХО-ын 81 хувийг нөөц баялаг эрэлхийлсэн, 16 хувийг зах зээл эрэлхийлсэн, 3 хувийг стратегийн хөрөнгө эрэлхийлсэн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Стратегийн хөрөнгө эрэлхийлсэн хөрөнгө оруулалтын дийлэнх нь аялал, жуулчлалын салбарт хийгдсэн бол хамгийн чухал хөрөнгө оруулалтын төрөл болох үр ашиг эрэлхийлсэн хөрөнгө оруулалт маш бага хэмжээтэйгээр хийгджээ.

Зураг 6868. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын төрөл, 2012-2016 он



Эх сурвалж: Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зурагал, 2018 он

Гадаад худалдааны эргэлтийн дийлэнх хувийг БНХАУ, ОХУ гэсэн 2 улс бүрдүүлж байгаа нь худалдааны хараат байдлыг бий болгож байна. Монгол Улс 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн болсон ба олон талт худалдааны зарчмын дагуу нээлттэй, чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлдэг. 2021 оны байдлаар дэлхийн 64 оронд бараа экспортолж, 159 орноос гарал үүсэлтэй бараа импортолсон байна. Гэсэн хэдий ч экспортын 82.6 хувийг БНХАУ, импортын 65 хувийг БНХАУ, ОХУ гэсэн 2 улс бүрдүүлж байна. Энэ нь худалдаа цөөн тооны бүтээгдэхүүнээс хамаарахаас гадна түнш орнуудын эдийн засгийн


орчин, гадаад эрэлт, худалдааны болон хил, гаалийн бодлогоос хамаарах эрсдэлтэйг харуулж байна.

Зураг 6969. Экспортын бүтэц, 2005-2020 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 7070. Импортын бүтэц, 2005-2020 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дотоодын экспортлогч, импортлогч аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөн, худалдааны түнш орнуудын бодлогоос шалтгаалан Монгол Улсын экспортын үнэ зах зээлийн үнээс доогуур, харин импортын барааны үнэ зах зээлийн үнээс дээгүүр буюу бид арилжааг ашигтай хийхгүй байна. Зөвхөн 2019 онд нийт экспортод 76 хувийг зээлж байсан нүүрс, зэсийн баяжмал, тэмрийн хүдэр, түүхий нефть зэрэг 4 төрлийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээс доогуур үнээр худалдаалснаас 1,354.8 сая ам.долларын, нийт импортоод 19 хувийг зээлж байсан бензин болон дизелийн түлшийг зах зээлийн үнээс хэт дээгүүр худалдан авснаас 293.8 сая ам.долларын алдагдал хүлээжээ¹.

Хатуу болон зөвлөн дэд бүтэц хангалтгүйн улмаас тээвэрлэлтэд их хугацаа зарцуулж байгаа нь худалдааны эргэлтийг удаашруулж байна. Дэлхийн банкнаас гаргадаг логистикийн гүйцэтгэлийн үзүүлэлтээр Монгол Улс 2016-2018 онд 22 байраар ухарч 160 улсаас 130-д эрэмбэлэгджээ. Тээврийн дэд бүтэц, үйлчилгээ, хилээр нэвтрэх үйл явц, цаг хугацаа, нийлүүлэлтийн сүлжээний найдвартай байдлыг харгалzan үзэж тооцдог тус индексийг ийнхүү буурахад гаалийн ажиллагааны үр ашигтай байдал болон хилийн цэгүүд дээрх гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, худалдаа, тээврийн дэд бүтцийн чанар, логистикийн чадавх, илгээсэн барааг хянах, мөрдөн мөшгөх чадвар сүл байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 25. Логистикийн гүйцэтгэлийн үзүүлэлт

Үзүүлэлт		2007	2012	2018
Логистикийн гүйцэтгэлийн индекс /оноо/	Оноо	2.08	2.25	2.37
Логистикийн гүйцэтгэлийн индекс /дэлхийд эзлэх байр/	Дэлхийд эзлэх байр	136	140	130

Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөр

Гааль	Оноо	2	1.98	2.22
	Дэлхийд эзлэх байр	131	144	127
Дэд бүтэц	Оноо	1.92	2.22	2.1
	Дэлхийд эзлэх байр	129	125	135
Олон улсын тээвэрлэлт	Оноо	2.5	2.13	2.49
	Дэлхийд эзлэх байр	91	142	117
Логистикийн чадавх	Оноо	1.8	1.88	2.21
	Дэлхийд эзлэх байр	144	152	140
Хянах, мөрдөн мешгех чадвар	Оноо	2	2.29	2.1
	Дэлхийд эзлэх байр	136	134	152
Хугацааны найдвартай байдал	Оноо	3	2.99	3.06
	Дэлхийд эзлэх байр	70	91	93

Эх сурвалж: Дэлхийн банк

Дэд бүтцийн чанар, үр ашгийг сайжруулж, тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэхгүйгээр олон тулгуурт эдийн засгийн бүтцэд шилжих боломжгүй байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд эдийн засаг нэг салбарт төвлөрсөн бүтэцтэй болсон. 2000 онд ДНБ-ий аравны нэг хувийг бүрдүүлж байсан уул уурхайн салбар 2020 онд деревний нэг хувийг бүрдүүлэх болжээ. Түүнчлэн, 2000 онд Монгол Улсын экспортын сагсны 43.5 хувийг уул уурхай, 41.3 хувийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, 14.3 орчим хувийг үйлчилгээ, 0.9 хувийг боловсруулах салбар бүрдүүлдэг байсан бол 2019 онд 79.2 хувийг уул уурхайн салбар, 5.3 хувийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, 14.9 орчим хувийг үйлчилгээ, 0.4 хувийг боловсруулах салбар бүрдүүлжээ.

Зураг 7171. Экспортын сагсны бүтэц, 2000 он



Эх сурвалж: Харвардын их сургууль, Өсөлтийн шинжилгээний лаборатори

Зураг 7272. Экспортын сагсны бүтэц, 2019 он




Эх сурвалж: Харвардын их сургууль, Өсөлтийн шинжилгээний лаборатори

Эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг тэтгэх экспортын бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдээгүй бөгөөд 2004 оноос хойш ердөө 6 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортын сагсанд шинээр нэмэгджээ. Харвардын их сургуулиас бэлтгэн гаргадаг ур чадвар, мэдлэг шаардсан бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх чадавхыг хэмждэг эдийн засгийн цогц байдлын индексээр 2019 онд Монгол Улс дэлхийн 127 орноос 113-т жагсаж байгаа нь 10 жилийн өмнөхөөс 9 байраар ухarsan байна. Монгол Улсын экспортын дийлэнх буюу 81.3¹² хувийг цогц байдал доогуур буюу боловсруулаагүй эрдэс бүтээгдэхүүн эзэлж байна. Түүнчлэн, Монгол Улс эдийн засгийн төрөлжилтийг хэмжих үзүүлэлтээр дэлхийн 133 орноос 117-д жагсаж байгаа нь сүүлийн 15 жилийн хугацаанд 17 байраар ухarsan үзүүлэлт юм.

¹² 2021 оны экспортод залэх эрдэс бүтээгдэхүүний хувь

Монгол Улс бага дунд орлоготой орнуудтай харьцуулахад боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувь 2 дахин доогуур байна. Экспортын бүтээгдэхүүнийг боловсруулалтаар нь авч үзвэл 96.2 хувийг завсрын хэрэглээний бүтээгдэхүүн, 1.2 хувийг үндсэн хөрөнгө, 2.6 хувийг эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн эзэлж байна. Түүнчлэн, сүүлийн арван жилийн хугацаанд боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувь 7-9 хувьд хэлбэлзэж байна.

Зураг 7373. Эдийн засгийн бүтэц, хувь, 2000-2021 он



Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо

Дэд бүтцийн хүртээмж тааруу байгаагаас уул уурхайн өртгийн сүлжээний хөгжил доогуур хэвээр байна. Эрдэс баялгийн ордын бүтээн байгуулалтын ажил нь цөөн тооны компаниудаар хязгаарлагдаж байгаа бөгөөд үлдсэн компаниуд нь найдвартай дэд бүтэц байгуулах томоохон зардлыг өөрсдөө хариуцах чадваргүй байдаг. Олборлосон түүхий эдийг шууд экспортлохын оронд дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингээх боломж хязгаарлагдмал, өртөг нь хэт өндөр байна.

Хөдөө аж ахуйн салбар боломжит потенциалаа бүрэн ашиглаж чадахгүй байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд малын too толгой тасралтгүй ёсөж, 2020 оны байдлаар 67.1 саяд хүрэн, тоогоороо дэлхийд эхний 10 байрт багтаж байгаа хэдий ч мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь буурч байгаа нь салбар үр ашигтай ажиллаж чадахгүй байгааг илтгэж байна. Мал аж ахуйн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл болон боловсруулсан бүтээгдэхүүнийг харьцуулан авч үзвэл нийт мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 3.4 хувийг, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 16.3 хувийг, арьс, шир үйлдвэрлэлийн 2.6 хувийг дотоодын үйлдварт боловсруулалт хийсэн байна. Эндээс мал аж ахуйн салбарт боловсруулалтын түвшин маш бага буюу үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний 10 хүрэхгүй хувийг боловсруулж байна.

Хүснэгт 26. Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, 2020 он

№	Малын гаралтай бүтээгдэхүүн	Нийт үйлдвэрлэл	Боловсруулсан үйлдвэрлэл	Боловсруулсан үйлдвэрлэлийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь
1	Max, мян.тонн	744.5	24.6	3.3
2	Сүү, сая литр	1,082.4	176.2	16.3
3	Арьс, шир, мян.ширхэг	27,119.0	727.6	2.7

Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйн салбарт тоо хэмжээ, чанарын тогтвортой нийлүүлэлт байхгүйгээс экспортын боломж бодитоор хэрэгжихгүй байна. Малын эрүүл мэндийн болон үргүүлгийн тогтолцоо сул, малын өвчлөлийн тохиолдол өндөр, бэлчээрийн зохистой менежмент байхгүй, тэжээлийн болон усны хангамж дутмаг, орчин үеийн үйлдвэрлэлийн арга барилыг нэвтрүүлээгүйн улмаас хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтэээмж бага хэвээр байна. Экспортод гарч буй мал аж ахуйн бүтээгдэхүүний дийлэнх нь нэмүү өртөг бага шингэсэн тул дэлхийн зах зээл дээр хямд үнээр худалдаалагдаж байна. Бүтээгдэхүүний боловсруулалт, чанарыг дэмжих тулхэц, урамшуулалт дутагдалтай байна.

Аялал жуулчлалын салбарын өсөлтийг дэд бүтцийн сул хөгжил хойш татаж байна. Монгол Улсын аялал жуулчлалын салбар 2011 оноос эхлэн эрчимтэйгээр өсөж, 2018 оны байдлаар ДНБ-ий 4 орчим хувийг, ажиллах хүчний 4.6 хувийг тус тус бүрдүүлсэн. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирсэн нь 2018 онтой харьцуулахад 5.3 хувиар өссөн байна. Харин цар тахалтай холбоотойгоор 2020 онд нийт жуулчдын тоо 58.9 мянга болж огцом буурсан. Гадаад жуулчдаас авсан санал асуулгын дунгээр Монгол Улсад учирсан хамгийн хүндрэлтэй асуудлууд нь 1) Ариун цэврийн өрөө, 2) Зам, замын түгжрэл, 3) Интернэт, утсан холбоо зэрэг дэд бүтэцтэй холбоотой асуудлууд байв¹³. Мен, Дэлхийн здийн засгийн форумаас гаргадаг аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Монгол Улс 2019 онд 7 онооны үзүүлэлтээс 3.5 оноог авч 130 гаруй орноос 93 дугаар байранд эрэмбэлэгдэхэд бизнесийн орчны үзүүлэлт, дэд бүтцийн хөгжил, олон улсад нээлттэй байдал зэрэг үзүүлэлтүүд голлон нөлөөлсөн байна.

Байгалийн өвөрмөц тогтоц, соёлын өвийг ашиглан аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломж бололцоог бүрэн ашиглахгүй хэвээр байна. Монгол Улсын аялал жуулчлалын улирал нь 5-9 дүгээр сард буюу харьцангуй богино байдаг нь аялал жуулчлалын салбарын томоохон сорилтуудын нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын яам дотоодын аялал жуулчлалын салбарыг энэ хугацаанд 1.2 сая буюу өдөрт 72,000 жуулчин хүлээн авах хучин чадалтай гэж тооцсон. Аялал жуулчлалын салбар 2019 онд оргил түвшиндээ буюу 577,000 хүрсэн нь зорилтот түвшнийхээ өрдөө тал нь юм. Аялал жуулчлалын салбарын боломж бололцоог бүрэн ашиглахын тулд Монгол Улс нь тэзврийн дэд бүтэц, системийг бэлтгэх шаардлагатай.


Монгол Улс мэдлэгт сууринсан здийн засгийг бий болгох ихээхэн боломжтой гэж үнэлэгдэж байгаа ч дижитал бэлэн байдлыг бүрдүүлэх шаардлагатай. Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас гаргадаг Дэлхийн инновацийн индексийн Инновацийн үр ашигтай харьцаагаар Монгол Улс 30 дугаарт эрэмбэлэгдэж, инновацийн өгөгдлийг бүтээгдэхүүн болгох өндөр чадвартай гэж үнэлэгдсэн. Дэлхийн өрсөлдөх чадварын тайландаа Монгол Улсын инновацлаг компанийн өсөлтийн хувь дундаас дээгүүр үнэлгээ авсан ч салбарын хөгжлийн бодлогын үзэл баримтлалаас үл хамааран кластер буюу нэгдмэл хөгжлийн үнэлгээ нь дундаас доогуур үнэлэгдсэн. Монгол Улсын Дижитал бэлэн байдлын үнэлгээнээс хараад Монголд зохих дэд бүтэц нь байгаа ч технологийн дэвшлийг ашиглах дижитал бэлэн байдлын шаардлагыг хангаагүй байна. Монгол Улс гар утасны интернэт, ухаалаг гар утас хэрэглээгээрээ дундаж орлоготой орнуудын дунджаас өндөр боловч гар утсаар холбогдох өргөн зурваст интернэт холболтоороо 141 улсаас 90-д эрэмбэлэгдсэн нь дижитал здийн засгийн бүрэн дүүрэн хөшүүрэглэхэд хүн ам нь хангалттай бэлэн бус байгааг илтгэж байна.

Монгол Улс дотоод дахь дэд бүтцийн хөгжил сулаас гадна бүс нутгуудад холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын хувьд бараа бүтээгдэхүүний үнийн бүтцийн 30 орчим хувийг тээвэр, логистикийн зардал зээлж байгаа нь бусад улс орны үзүүлэлтээс үзэмж өндөр байна. Учир нь Монгол Улс далайд гарцгүй учир олон улсын зах зээлд нэвтрэхийн тулд 2 хөршийн сүлжээгээр дамжин өнгөрөх шаардлагатай болдог. Дэлхийн банкнаас гааль, дэд бүтэц, олон улсын тээвэр, логистикийн үйлчилгээний

¹³ Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд


чанар, тээвэрлэлтийн хяналт, цаг зарцуулалт зэрэг 6 үндсэн үзүүлэлтээр улс орнуудыг дүгнэн логистикийн гүйцэтгэлийн индексийг тооцдог. Уг үзүүлэлтээр Монгол Улс 2007 онд 150 орноос 136 дугаарт орж байсан бол 2018 онд 130 дугаар байрт жагсаад байгааг өмнө дурдсан.

Зураг 7474. Харьцуулагдах зэрэглэлийн орнуудын 1 км² газарт ногдох ДНБ, 2018 он



Тээвэрлэлтийн зардал өндөр байгаа нь бүтээгдэхүүний үнэ, өрсөлдөх чадварыг суплуулж байна. Тухайлбал, Япон улс руу нэг чингэлэг ачаа тээвэрлэх зардал бусад орнуутдтай харьцуулахад 3-20 дахин их байгаа нь тээвэрлэлт үр ашиг муутай байгааг илтгэж байна.

Зураг 7575. Япон улс руу экспортлох зардал, ам.доллар/контейнер



Эх сурвалж: "Монгол Улсын бүсчилсэн төлөөвлөлт"-ийн өгөгдөл, ЖАЙКА, 2016 он

Хүснэгт 27. Япон руу экспортлох зардал, ам.доллар/1 чингэлэг

Үзүүлэлт	Алматы, Казахстан	Ташкент, Узбекстан	Душанбе, Таджикистан	Бишкек, Киргиз	УБ, Монгол (импорт)
20 футийн чингэлгийг 1 км-т тээвэрлэх зардал (TEU/km)	0.37	0.35	0.59	0.34	0.87

Эх сурвалж: "Монгол Улсын бүсчилсэн төлөөвлөлт"-ийн өгөгдөл, ЖАЙКА, 2016 он

Түүнчлэн, төмөр замаар ачаа тээвэрлэхэд Тяньжини боомтод 74-144 цаг, Тяньжинаас Эрээн хот хүртэл 96 цаг, Эрээн-Замын-Үүд хилийн боомтоор нэвтрэхэд 24-78 цаг, Замын-Үүдээс Улаанбаатар хүртэл 21 цаг, нийтдээ 213-339 цаг зарцуулж байгаа¹ нь худалдааны эргэлт удаашрах, тээвэрлэлтийн зардал өндөр байх гол шалтгаануудын нэг болж байна.

Тээвэрлэлтийн зардал өндөр байгаа бас нэгэн шалтгаан нь төмөр замын дэд бүтэц байхгүйгээс шалтгаалж авто замаар тээвэрлэлт хийх явдал юм. Монгол Улс Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад нэгдсэн 28 гишүүн орноос төмөр замын уртаараа 20, тээвэрлэсэн ачааны хэмжээгээрээ 15-р байранд орсон байна. Ачаа тээвэрлэлтийн бүтээмжийг төмөр замын нийт уртад нь харьцуулан харвал Монголын төмөр

замын салбар Узбекистан, Туркменистаныг бодвол илүү сайн боловч Казахстанаас хоёр дахин бага бүтээмжтэй, БНХАУ болон ОХУ нь Монгол Улсаас дөрөв дахин өндөр бүтээмжтэй байна.

Хүснэгт 28. Төмөр замын салбарын үзүүлэлтүүд


Улс	Монгол	Узбекистан	Туркменистан	Казахстан	Пакистан	Япон
Төмөр замын сүлжээний урт	1,810.0	4,669.0	3,115.0	16,040.0	11,881.0	27,823.0
Ачаа тээвэрлэлт	25.7	82.3	26.8		5.0	
Ачаа эргэлт (тэрбум тн-км)	15.3	22.9	12.0	266.6	4.7	20.9
Зорчигч тээвэрлэлт (сая.хүн)	2.5	20.6	6.5		52.2	
Зорчигч эргэлт (сая хүн-км)	993.0	3,758.0	1,811.0	18,200.0	21,200.0	430,405.0
Он	2018	2015	2012	2017	2016	2016
Бүтээмж: Ачаа тээвэр/сүлжээний урт (тэрбум.тн)	8.5	4.9	3.9	16.6	0.4	0.75
Бүтээмж: Зорчигч сүлжээний урт (сая)	0.55	0.80	0.58	1.13	1.78	15.47

[Эх сурвалж ...](#)

Мөн Монгол, Хятадын хоорондын төмөр замын царигийн ялгаа болон транзит тээврийг хийж буй галт тэрэгнүүдийг ажиллуулах зүтгүүр, чиргүүлийн тоо хэмжээ Монголд хангалтгүй байна.

Агаарын тээврийн салбарын нийт ашиг алдагдлыг сүүлийн 5 жилийн хугацаанд авч үзвэл орлогоос давсан зардалтай, алдагдалтай ажиллаж байна. Монгол Улсад олон улсын зэрэглэлт 4 боомт, 14 аймагт 21 нисэх буудал үйл ажиллагаа явуулж байна. Мөн улсын хэмжээнд 1 л боомт тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нь агаарын тээврийн салбар алдагдалтай ажиллахад чухал хүчин зүйл болж байна. Манай улс ОХУ, БНХАУ-тай агаарын 15 хаалгаар холбогдох, нийт 62 агаарын замыг ашиглаж байна. 2020 онд олон улсад 26 чиглэл, орон нутагт 18 чиглэлд тогтмол нислэг үйлдсэн бөгөөд дотоодын нислэгийн тоо 7967-т хүрсэн бөгөөд уул уурхайн салбарын хөгжлийг дагаад уул уурхайн зориулалттай захиалгат нислэг тогтмол нэмэгдсээр байна.

Зураг 7676. Дамжин өнгөрөлт, олон улсын болон орон нутгийн нислэгийн тоо, 2010-2019 он



[Эх сурвалж ...](#)

Судалгаа хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалт хийж, инновацыг дэмжихгүй бол бүтээмж нэмэгдэхгүй байна.

Шинжлэх ухаан, инновацад суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох орчин сул байгаа нь инновацын хөгжлийн үзүүлэлтүүдээс харагдаж байна. Дэлхийн ихэнх улс орон шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан мэдлэгийн эдийн засаг, дэвшилтэт болон өндөр технологийг хөгжүүлэх, хөрөнгө, нөөцийг төвлөрүүлэх замаар хөгжлийн бодлогоо тодорхойлж, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна. Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон АНУ-ын Корнеллийн их сургууль хамтран 2007 оноос эхлэн “Олон улсын инновацын индекс” судалгааг жил бүр эрхлэн гаргаж байгаа бөгөөд Монгол Улсын хувьд “Инновацын индекс 2020” судалгаагаар дэлхийн 131 улсаас 58-д эрэмбэлгэдсэн нь өмнөх оноос 5 байр ухарсан үзүүлэлт юм. Энэхүү индексийг тооцоходо инновацын нөөц боломж, инновацыг хэрэгжүүлэх явцад хүрсэн амжилт, практик үр дүн гэж хоёр хувааж үнэлдэг. Инновацын нөөц боломжоор манай улс 41.5 оноотой 65 дугаарт, харин инновацыг хөгжүүлэх явцад хүрсэн амжилт, практик үр дүнгээр 54 дүгээрт жагсан байна. Ерөнхий 7 бүлгээс институц, хүний капитал ба судалгаа, мэдлэг ба технологийн хөгжлеер муу үзүүлэлттэй байгаа бол зах зээлийн хөгжлийн үзүүлэлт болон бүтээлч сэтгэлгээний хөгжлеер сайн үзүүлэлттэй байна.

“Инновацын индекс 2020” судалгаанд дурдсанаар зах зээл талаасаа зээлийн орчин, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт сайтай, мэдлэг болон технологийн хувьд ашигтай загварууд зохион бүтээдэг, бүтээлч байдал талаасаа биет бус өв ихтэй байгаа нь инновац хөгжүүлэхэд давуу тал болж байна гэжээ.

Харин институцын хувьд бизнесийн салбарын төлберийн чадвар, боловсрол, шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалт болон төсвийн зарцуулалт орхигдсон, дээд боловсролын чанар, инновацыг кластер байдлаар хөгжүүлээгүй, технологийн салбарт “high-tech” болон “medium-high-tech”-ийн үйлдвэрлэл байхгүй, мэдлэгийн тархалтын хувьд оюуны өмчийн баримт, гаднаас “high-tech” импортлох, мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээний экспорт, гадаадын цэвэр хөрөнгө оруулалтын урсгал тааруу зэрэг байдал нь инновацын хөгжилд сул тал болж байна.

Инновац, өндөр технологийн асуудал бодлогын хувьд тогтвортой бус, нэгдсэн удирдлагад төвлөрч чадаагүй байна. Инновацын тухай хууль батлагдаад багагүй хугацаа өнгөрсөн ч хуулийн хэрэгжилт удаашралтай байгаа нь инновац, өндөр технологийн асуудал бодлогын хувьд тогтвортой бус, нэгдсэн удирдлагад төвлөрч чадаагүйтэй холбоотой. Хууль тоогоомж шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас зарим зүйл, заалтууд хүчингүй болсон. Тухайлбал, Инновацын тухай хуульд 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр венчур хөрөнгө оруулалтын талаарх цогц асуудлыг, мөн 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр инновацын сангийн талаарх асуудлыг хүчингүй болгосон. Инновацын тухай хуулийг хэрэгжүүлэх санхүүгийн гол хөдөлгүүр болсон дээрх хоёр асуудлыг хуулиас хассан нь Монгол Улсад үндэсний инновацын тогтолцоог бүрэлдүүлэх, инновацын үйл ажиллагааг төрөөс дэмжих, хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх, санхүүжүүлэх ажлуудыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүсгэжээ.

Судалгаа, хөгжүүлэлтийн зардал бага байгаа тул шинэ мэдлэгийг инновац болгож чадахгүй байна. Шинжлэх ухаан, судалгаа хөгжлийн зардалд зарцуулж байгаа зардал дорвitoй нэмэгдэхгүй байгаагаас тавьсан зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нь харагдаж байна. ДНБ-ий 1.0 хүрэхгүй хувийг зээлдэг судалгаа, хөгжүүлэлтийн зардал 2016-2018 онд 0.2 хувьтай байсан ч Ковид-19-ийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан 2020 онд 0.13 хувь болж буурсан байна. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тоо нэмэгдэж, 2020 онд 353 болсон ба тэдгээрийн 75.1 хувь нь суурь судалгааны ажил, 22.1 хувь нь хэрэглээний судалгааны ажил, 2.8 хувь нь туршилт, хөгжүүлэлтийн ажил байна. Түүнчлэн 2015 оны байдлаар 2 судалгааны ажил тутмын 1 нь шинжлэх ухаан, технологийн төсөл байсан бол 2019 онд төслийн тоо буурч, 3 судалгаа тутмын 1 нь шинжлэх ухаан, технологийн төсөл болсон байна. Иймд, цаашид шинжлэх ухаан, технологи, инновацын төсөл, грант ажиллуулах тоог нэмэгдүүлэх, танин мэдэхүйн агуулга

бүхий шинэ контент бүтээх ажлыг дэмжих чиглэлээр бодлого баримтлан ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.


Зураг 7777. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажил



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Шинжлэх ухаан, технологийн салбарын 33.3 хувийг шинжлэх ухааны, 21.8 хувийг нийгмийн шинжлэх ухаан, 20.8 хувийг байгалийн шинжлэх ухаан, 10.4 хувийг хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, 9.2 хувийг анагаахын шинжлэх ухаан, 4.5 хувийг хүмүүнлэгийн болон урлагийн шинжлэх ухаан бүрдүүлж байна.

Зураг 7878. Шинжлэх ухаан, технологийн салбарын зардлын бүтэц, хувь, 2020 он



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Салбар дундын судалгааны ажлыг хөгжүүлэх орчин сул, олон талт хамтын ажиллагаа дутмаг байна. Эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах орчин, дэд бүтцийг бүрдүүлэх, импортыг орлох болон экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих үүрэг бүхий “Шинжлэх ухааны парк” байгуулах бодит хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. Шинжлэх ухаан, технологийн чиглэлээр 2020 онд нийт 1,877 ажил хэрэгжсэнээс 53.7 хувь нь судалгаа хөгжүүлэлтийн ажил, 26.7 хувь нь судалгаа хөгжүүлэлтийн ажилд шууд хамааралгүй шинжлэх ухаан, технологийн үйлчилгээний ажил, 19.6 хувь нь шинжлэх ухаан, техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа байна. Нийт судалгаа хөгжүүлэлтийн ажлыг төрлөөр нь авч үзвэл 69.3 хувь нь суурь судалгааны ажил байна.

Монгол Улсад шинжлэх ухаан, технологийн чиглэлээр 2018 онд 59 байгууллагад 4,254 судлаач ажиллаж байсан бол 2020 онд 68 байгууллагад нийт 6,926 хүн ажиллаж байна.


Зураг 7979. Шинжлэх ухааны байгууллагад ажиллагчид, 2005-2020 он



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Тэдгээр 68 байгууллагын 53 (77.9 хувь) нь төрийн өмчийн, 15 (22.1 хувь) нь хувийн өмчийн байгууллага байна. Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага 31 байна. Нийт ажиллагсдын 6,109 (88.2 хувь) нь үндсэн, 5,033 (72.7 хувь) нь судлаачид, нийт судлаачдын 1,536 (30.5 хувь) нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Нийт ажиллагчдын дотор шинжлэх ухааны доктор 153, боловсролын доктор 1,697, академич 64, профессор 369, дэд профессор 564 байна.

Зураг 8080. Эрдэм шинжилгээний ажилтны тоо, 2015-2019 он



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Манай улсын хувьд, гол анхаарлаа судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэхийн тулд бизнесийн инкубацийг идэвхтэй дэмжих, Төрийн инновациын бодлогыг юуны өмнө бүрдүүлэх, УИТ бүрдүүлэх, мэдлэгт түшиглэсэн нийгмийг бүрдүүлж хөгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна. Уг бодлогын хэрэгжилтийн үр дүнд өрсөлдөөнийг дэмжих, оюуны өмчийг хамгаалах, төрийн хүнд суртлыг багасгах, татварын эрх зүйн бусад оновчтой зохицуулалт бүхий инновациын таатай орчин бүрдүүлэх, судалгаа, хөгжүүлэлт, инновациыг эрчимжүүлэх, хувийн секторт судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх, өндөр технологитой үйлдвэрийн газруудыг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан-боловсрол-бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, ЖДҮ-д өндөр технологийг нэвтрүүлэх сонирхол төрүүлэх зэрэг чиглэлээр далайцтай ажлуудыг хийж гүйцэтгэх хэрэгцээ тулгарч байна. Үнд, инновациын салбарын төсвийн болон төсвийн бус санхүүжилтийн хэмжээ маш бага, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавх сул, мөнгөн хөрөнгө хомдолтой, хөрөнгө оруулах чадвар сул, хөгжлийн түвшин үйлдвэржилтийн өмнөх шатанд байгаа, зээлийн хүү

өндөр, хэмжээ бага, хугацаа богино, эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудын цалин хөлс бага, мэргэжлийн чадварлаг боловсон хүчинүүд эдийн засгийн бусад салбарт шилжсэн, аж ахуйн нэгжүүдэд эрдэм шинжилгээ-судалгааны хэрэгцээ бага, өөрөөр хэлбэл мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хувийн хэвшил цөөн байна.

Хөдөлмөрийн дотоод шилжилтийг эрчимжүүлж, бүтэээмжийг бүх салбарт дээшлүүлэхгүй бол үр ашигтай үйлдвэрлэлийн түвшнийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэх боломжгүй байна.

Нийт эдийн засгийн хувьд хөдөлмөрийн бүтэээмжийг нэг ажиллагчид ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр тодорхойлдог бөгөөд 2020 оны байдлаар ДНБ өмнөх оноос 4.8 хувиар буурсан бол ажиллагсдын тоо өмнөх оноос 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. ДНБ-ий энэхүү бууралтаас шалтгаалан нэг хүнд ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 онд 8.3 сая төгрөг болж өмнөх оноос 5.5 хувиар, нэг ажиллагчид ноогдох ДНБ 21.6 хувь болж өмнөх оноос 6.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 29. Нэг ажиллагчид ногдох хөдөлмөрийн бүтэээмж (индекс 2015=100), 2015-2020 он

Он	ДНБ		Ажиллагчид		Нэг ажиллагчид ногдох ДНБ	
	Индекс	Өсөлт, %	Индекс	Өсөлт, %	Индекс	Өсөлт, %
2015	100.0		100.0		100.0	
2016	101.6	1.5	99.7	-0.3	101.9	1.8
2017	106.9	5.1	107.6	7.6	99.4	-2.5
2018	115.4	7.7	108.8	1.2	106.0	6.5
2019	122.8	6.2	99.6	-8.9	123.3	15.1
2020	117.0	-4.8	101.0	1.5	115.8	-6.3
Жилийн дундаж өсөлт, %		3.1		0.2		2.9

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Бизнесийн бус салбарын хөдөлмөрийн бүтэээмжийн өсөлт, эдийн засаг дахь нөлөө бага байгаа нь бүтэээмж салбаруудад харьцангуй байх, ажиллах хучин үр ашигтай хуваарилгдахгүй байх шалтгаан болж байна. Бизнесийн салбарын нэг ажилтанд ногдох ДНБ 21.5 сая төгрөг болж, өмнөх оноос 3.1 хувиар буурсан байна. Олон улсын нийтлэг аргачлалын дагуу бүтэээмжийг тодорхой салбаруудаар нэгтгэн тооцсон үр дүнгээс харахад манай улсын хувьд нийт эдийн засаг болон бизнесийн салбарын хөдөлмөрийн бүтэээмж ойролцоо байdag нь бизнесийн бус салбарын бүтэээмж нийт эдийн засагт бага нөлөөтэйг харуулж байна. Мөн нийт эдийн засгийн болон бизнесийн салбарын хөдөлмөрийн бүтэээмжийг харьцуулахад 2019-2020 онд бизнесийн бус салбарын бүтэээмж (цалин байж болно)-ийн өсөлтийн хувь бага байна.

Зураг 8181. Бизнесийн салбарын хөдөлмөрийн бүтэээмжийн хандлага, хувь (2015=100)



Эх сурвалж:

Хөдөлмөрийн хөлсний үнэлэмж бага, салбар хооронд харьцангуй байгаа нь нийт бүтэээмжид сөргөөр нөлөөлж байна. Ажил хөдөлмөр эрхэлсэн ч амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй, өрхийн орлогоос зарлага нь өндөр байдгаас хөдөлмөр эрхэлж байгаа

хүмүүс ядуучуудын эгнээнд орох эрсдэл байсаар байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалин хөлстэй ажиллагчид нийт ажиллагчдын 11.9 хувийг эзэлж, 19.9 хувь нь л 1.5 сая төгрөгөөс дээш хэмжээний цалин хөлс авч байна. Улсын хэмжээний дундаж цалин хөлстэй дүйцэх цалинтай ажиллагчид нийт ажиллагчдын 63.1 хувийг эзэлж байна.

Манай улсад хөдөлмөрийн цалин хөлс харьцангуй доогур түвшинд байгааг тайлбарлах нэг гол хүчин зүйл нь хөдөлмөрийн бүтээмж юм. Хөдөлмөрийн бүтээмж хамгийн бага байгаа хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдааны салбарт нийт ажиллагчдын харгалzan 28.8 хувь болон 16.5 хувь нь ажиллаж байна. Эдгэр бүтээмж bagатай салбаруудын дундаж цалин ч мөн бага байна. Уул уурхай, олборлолтын салбарын дундаж цалин 2020 онд 2.9 сая төгрөг бол харин хөдөө аж ахуйн салбар, бөөний болон жижиглэн худалдааны салбарынх 1.0 сая төгрөг байна.

Чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, байршуулах бодлого дутмаг байгаагаас хүмүүн капиталын хуриатлааас үүдэлтэй ёсөлтийг бий болгож чадахгүй байна. Ур чадвартай ажиллах хүчин хангалтгүй, ажилчид ур чадварын дутагдалтай байгаа нь бизнес эрхлэгчдийн нөөц бололцоог хязгаарлаж байна. Монголын бизнесийн орчны судалгаа-2020 болон Европын холбоноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төслийн судалгаанд дурдсанаар олон компаниуд боловсруулалт, экспорттын үйл ажиллагаанд шаардлагатай цогц ур чадвар, хэлний мэдлэг эзэмшсэн ажилтан олоход бэрхшээлтэй тулгардаг байна.


Дэлхийн банк (2020)-ны судалгаагаар Монгол Улс хүмүүн капиталын дуттуу, үр дүн муутай ашиглаж байгааг ур чадвар/боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн хооронд үүссэн эрэлт нийлүүлэлтийн зерүү, ур чадвартай боловсон хүчний гадаад шилжилт хөдөлгөөнтэй холбон тайлбарласан байна. Чадварлаг ажиллах хүчний гадагшлах урсгал нэмэгдсээр хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын хомсдолыг улам нэмэгдүүлж байна. "Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан-2019"-д дурдсанчлан чадварлаг боловсон хүчнийг татах, хадгалж үлдээх Монгол Улсын чадавх харьцангуй сул байна. Эдийн засгийн ёсөлтийг хурдасгахад өндөр ур чадвар бүхий боловсон хүчин шаардлагатай хэдий ч өндөр боловсролтой Монголчуудын баагүй хувь нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнууд болон БНСУ-д шилжин суурьшиж байна.

Зах зээл дахь төрийн оролцоо, зохицуулалтын үр ашиг хангалтгүй байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, тогтвортой, үр дүнтэй байдал, шүүх, хууль хяналтын хараат бус байдлаас шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжийн засаглалын үйл явцад итгэх итгэл буурч байна. Монгол Улсад засаглалын тогтвортой, үр дүнтэй байдал алдагдаж, хариуцлага, хяналт бүх түвшинд супарч, шударга ёсны болон хууль дээдлэх зарчим алдагдан төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж чанар, төрийн захиргаа, үйлчилгээнд хүнд суртал, мэргэшсэн бус тогтолцоо, харилцаа, хандлага газар авч, засаглалын үйл явцад аж ахуйн нэгж, иргэдийн итгэл сул байна.

Дэлхийн банкны засаглалын судалгааны иргэдийн дуу хоолой ба хариуцлага гэсэн үнэлгээнд Монгол Улсын индекс 57.1 байгаа бөгөөд 204 орноос 88-д эрэмбэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл бодлого тодорхойлох үйл явц дахь иргэдийн оролцоо дундаас ялимгүй дээгүүр байгаа юм.

Зураг 8282. Засаглалын үзүүлэлт



Эх сурвалж: Дэлхийн банкны засаглалын индекс

Шүүгч болон хууль хяналтын байгууллага хариуцлага хүлээх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, шүүгчид мэргэжлийн болон ёс зүйн хариуцлага тооцох механизмын үр нөлөө суларсны улмаас улмаас иргэдийн шүүх, хууль хяналтын байгууллагад итгэх итгэл суларч, шүүх засаглалын хараат бус байдлыг алдагдуулахад нөлөөлж байна. Дэлхийн банкны "Засаглалын судалгааны хуулийн засаглал" гэсэн үнэлгээнд Монгол Улсын индекс 44.1 байгаа бөгөөд 209 орноос 116-д эрэмбэлэгджээ. Ардчилсан засаглалын тулгуур нь хуулийн хэрэгжилтийг нийгмийн бүхий л хүрээнд хангах, иргэн, байгууллага бүр хуулийн өмнө тэгш байх бөгөөд ингэж хэмээн хүний хөгжлийг хангасан сайн засаглал тогтдог.

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд захиргааны хүнд суртал, дүрэм журам тодорхой бус, албан хаагчдын мэргэшсэн бус, шуурхай бус байдал, сөрөг хандлагаас үүдэлтэй бэрхшээл саад нийтлэг шинжтэй байна.

Засаглал сул байгаа нь олон сувгаар дамжин хөрөнгө оруулалтын орчныг муутгаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхэх, төсвийн сахилга батгуй байдлаас үүдэн улсын өрийг нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Засаглал, хууль эрх зүйн орчинг Засгийн газрын институцийн тогтолцоо уялдаа холбоо, Засгийн газрын үйл ажиллагаа, Бизнесийн эрхзүйн орчин гэсэн 3 дэд үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлогч 34 нарийвчилсан үзүүлэлтүүдээр авч үзсэн Монголын бизнесийн орчин 2020 судалгаанаас үзэхэд Засгийн газрын институцийн тогтолцоо уялдаа холбоо (2.60), Засгийн газрын үйл ажиллагаа (2.63), Бизнесийн эрх зүйн(2.75) үзүүлэлтүүд нь бүгд **муу үнэлгэдсэн** байна.


Дэд үзүүлэлтүүдийг нарийвчлан авч үзвэл засгийн газрын институцын тогтолцоо уялдаа холбоог тодорхойлогч үзүүлэлтүүдээс Төрийн бодлогын тогтвортой байдал (2.57), Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо (2.56), Бизнесийг дэмжсэн төрийн бодлого (2.54) нь **хамгийн муу үнэлгээг** авсныг онцгой анхаарах шаардлагатай. Харин засгийн газрын үйл ажиллагааг тодорхойлох үзүүлэлтүүдээс Төрийн байгууллагын үйлчилгээ (2.81), Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй байдал (2.80) үзүүлэлтүүд харьцангуй дунд талдаа зөргээр үнэлгэдсэн бол Төрийн байгууллагын хүнд суртал (2.38) Төрийн байгууллагын авлига, хээл хахууль (2.37) үзүүлэлтүүд бусдаас хамгийн доогуур **муу үнэлгээтэй** байгааг холбогдох байгууллагууд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Бизнесийн эрх зүйн орчны үзүүлэлтүүдээс Хөдөлмөрийн хууль (2.95) Компанийн тухай хууль (2.93), Татварын хууль (2.86) Байгаль орчныг хамгаалах зохицуулалтын бизнест үзүүлэх нөлөө (2.84) үзүүлэлтүүд бусдаас өндөр буюу дунд үнэлгээтэй бол Зерчлийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө (2.61), Тендерийн хууль эрх зүйн зохицуулалт (2.62) бусдаас доогуур буюу **муу талдаа үнэлгэдсэн** байна.

Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн давхардал, хийдэл, бүтээмжийн доогуур түвшин, хүнд суртал, зөвшөөрөл, хяналт шалгалт, зохицуулалтын шинжтэй асуудлууд нь ард иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд сергээр нөлөөлж, бүтээмжийг бууруулдаг гол хүчин зүйл болж байна. Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг, зохион байгуулалт нь оновчтой бус, сонгууль бүрийн дараа өөрчлөгдөх хандлагатайн улмаас Монгол Улсын хөгжлийн бодлогыг урт хугацаанд нь нэгтгэн зангидах, уядуулан хангах институтийн чадвых бэхжихгүй байна. Тухайлбал, 2018 оны байдлаар Монгол Улсын зохицуулалтын чадварыг тодорхойлох индекс 54.7 байгаа бөгөөд 209 орноос 95-т эрэмбэлэгдсэн. Индексийн хэмжүүр нь дундаас ялимгүй дээш гарсан байх бөгөөд засгийн газар, төрийн захиргааны байгууллагуудын бодлого тодорхойлик, хэрэгжүүлэх чадвых мэдэгдэхүйц сүл байгааг илтгэж байна. Иймд, төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэгт дун шинжилгээ хийж, оновчтой хуваарилан, төрийн алба мэргэшсэн, үр дүнтэй ажиллах хэлбэрээр зохион байгуулах, түүнд шаардлагатай эрх зүй, зохион байгуулалт, мэдлэг чадвар, технологи, хандлагын шинэчлэл хийх зүй ёсны шаардлага тулгамдаад байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг нэмэгдэх хандлагатай байна. 2018 онд Дэлхийн банкны засаглалын үнэлгээгээр авилгын индекс 39.9 байгаа бөгөөд 209 орноос 126 дугаар байранд жагсжээ. Үндсэндээ авлига, ашиг сонирхлын зөрчил газар авч энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжил, улс төрийн шинэчлэлд шууд чөдөр тушаа болсоор байна. "Транспаренси Интернэшил" байгууллагаас гаргасан 2020 оны Авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 35 оноо авч 111 дүгээр байранд жагсжээ. Энэ нь 2019 оноос зургаан байраар ухарсан үзүүлэлт бөгөөд тус онд 35 оноо авч 105 байранд жагсаж байв.

Зураг 83. Монгол Улсын авлигын индекс, 2013-2020 он



Эх сурвалж: Транспаренси Интернэшил

Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үндэсний тогтолцоог бүрдүүлэх нь хууль өөрчлөх, хяналт шалгалт тавих, хариуцлага хүлээлгэх төдийхнээр хязгаарлагдахгүй тул нийгмийн бүхий л хүрээнд авлигыг үл тэвчих хандлага тогтооход чиглэгдсэн шинэ үзэл баримтлал, арга зам санал болгох шаардлагатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулах, дасан зохицох чадвых бэхжүүлэхгүй бол салбаруудын өрсөлдөх чадварт сергээр нөлөөлж байна.

Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болох хөдөө аж ахуй, эрчим хүчний салбар байгаль, цаг уурын нөхцөл байдлаас өндөр хамааралтай байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг өсгөж, салбарын өрсөлдөх чадварыг бууруулж байна. Хөдөө аж

ахуйн салбар уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж байгаа нь энэ салбарын өрсөлдөх чадварт сергөөр нөлөөлж байна. Мал аж ахуйн салбарын хувьд малын тоо толгой өсөж, бэлчээрийн даац хэтэрч, хөрс, бэлчээр талхлагдан, цөлжих явц эрчимжсэнээс шалтгаалан нэг малаас авах ашиг шим буурч, салбарын өрсөлдөх чадвар муудсан байна. Газар тариалангийн салбарын гарцын түвшинд байгаль, цаг уурын нөхцөл байдал шууд нелөө үзүүлдэг тул уур амьсгалын өөрчлөлт үйлдвэрлэлийн бүтээмжийг бууруулж байна. Манай орны хувьд нүүрсэнд түшиглэсэн эрчим хүчний үйлдвэрлэл, нийлүүлэлт давамгайлдаг тул уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхийн нийтийн чиг хандлага, түүхий нүүрсний хэрэглээг халж эхэлсэнтэй холбоотойгоор салбарын тогтвортой үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт татах боломжид сергөөр нөлөөлж байна.

Хүлэмжийн хийн ялгарал, бэлчээр, хөрсний доройтол нь хүлэмжийн хийн ялгарлыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна. Монгол Улсын хувьд хүлэмжийн хий ялгаруулагч хамгийн том салбарт эрчим хүч, хөдөө аж ахуй ордог бөгөөд 2014 оны нийт хүлэмжийн хийн 50.1 хувийг эрчим хүч, 48.5 хувийг хөдөө аж ахуй, 0.95 хувийг аж үйлдвэр, 0.5 хувийг хог хаягдлын салбар тус тус ялгаруулж байна¹⁴. Хэдийгээр манай улс дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ ихээхэн өндөр буюу дэлхийн дунджаас 2.7 дахин их байна.

Хүлэмжийн хийн ялгарлаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ирээдүйд нэмэгдэхээр байна. Хүлэмжийн хийн ялгарлын нийт дүнг (суурь хувилбар) эрчим хүчний болон эрчим хүчний бус салбаруудаар 2010-2030 оны хооронд тооцож үзэхэд 2030 онд хүлэмжийн хийн ялгарлын түвшин 2010 оны үетэй харьцуулахад 2.8 дахин өсөх төлөвтэй байна. Мөн 2010 онд нийт хүлэмжийн хийн ялгарлын 54.4 хувийг эрчим хүчний салбар, 41.2 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байсан бол 2030 онд энэ хоёр салбарын эзлэх хувийн жин буурч, аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 4.1 хувиас 16.6 хувь болж өсөх хандлагатай байна.

¹⁴ Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний хороо (УАӨЗГМХ/РСС)-ноос гаргасан арга зүйг ашиглан 2017 онд хийсэн тооцоо (2014 он хүртэлх ялгарлыг тооцсон)

7.4. Зорилго, зорилт, үйл ажиллагаа

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар үндэсний өрсөлдөх чадварыг сайжруулахад тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан, шийдвэрлэх арга замуудад үндэслэн 4 зорилго, 9 зорилт, 39 үйл ажиллагааг тодорхойлоод байна.

Зорилго 1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

Энэхүү зорилгын хүрээнд төсвийн алдагдал, өрийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн төвлөрөл зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 2 зорилт, 6 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 1.1. Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангана.

- | |
|---------------------------------------------------------------------------------------|
| 1.1.1 Төсвийн төлөвлөлт, санхүүгийн удирдлагыг сайжруулна. |
| 1.1.2 Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг нэмэгдүүлнэ. |
| 1.1.3 Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулна. |
| 1.1.4 Баялгийн сангийн засаглал, менежментийг сайжруулна. |

Зорилт 1.2. Санхүүгийн салбарын эрсдэл даах байдлыг сайжруулна.

- | |
|------------------------------------------------------------------------------|
| 1.2.1 Санхүүгийн зах зээлд оролцогчдын төрөл, оролцоог нэмэгдүүлнэ. |
| 1.2.2 Санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. |

Зорилго 2. Бизнесийн орчныг сайжруулна.

Энэхүү зорилгын хүрээнд компанийн сул засаглал, хувийн хэвшлийн санхүүжилт, худалдааны үр ашигтой байдал зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 3 зорилт, 13 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 2.1. Компанийн засаглалыг сайжруулна.

- | |
|------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2.1.1 Санхүүгийн хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлнэ. |
| 2.1.2 Хувьцаа зээмшигчдийн засаглалыг сайжруулна. |
| 2.1.3 Компанийн удирдлагын үр чадвар, ашиг сонирхлосс ангид байдлыг дээшлүүлнэ. |
| 2.1.4 Бизнесийн байгууллагуудын чадавхыг сайжруулж, өрсөлдөөнийг дэмжинэ. |
| 2.1.5 Үндэсний болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ. |

Зорилт 2.2. Санхүүжилтийн таатай орчныг бүрдүүлнэ.

- | |
|-----------------------------------------------------------------------|
| 2.2.1 Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ. |
| 2.2.2 Гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. |
| 2.2.3 Бизнесийн зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулна. |
| 2.2.4 Хувийн хэвшилд олгох дотоодын зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ. |
| 2.2.5 Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлнэ. |

Зорилт 2.3. Худалдааны зохицуулалт, үр ашгийг сайжруулна.

- | |
|---------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2.3.1 Олон болон хоёр талт худалдааны хэлэлцээр байгуулж, хэрэгжилтийг хангаж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. |
| 2.3.2 Худалдааг хөнгөвчилж, зардал болон хугацааг хэмнэнэ. |
| 2.3.3 Цахим худалдааны экспортыг нэмэгдүүлнэ. |

Зорилго 3. Эдийн засгийг төрөлжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд үр ашигтой дэд бүтэц, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын сул өрсөлдөх чадвар зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 2 зорилт, 8 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 3.1. Тэргүүлэх салбаруудын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

- | |
|--------------------------------------------------------------------------------------------------|
| 3.1.1 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ. |
|--------------------------------------------------------------------------------------------------|

3.1.2	Хөдөө аж ахуйн болон эрдэс баяягийн түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.
3.1.3	Боловсруулах үйлдвэрлэлийн шинэ бүтээгдэхүүн, салбаруудыг нэмэгдүүлнэ.
3.1.4	Соёл, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаанд сууриссан бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
3.1.5	Аялал жуулчлалын салбарын өрсөлдөхүйц байдал, үр ашгийг дээшлүүлнэ.
3.1.6	Олон улсад танигдсан үндэсний брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.
Зорилт 3.2. Дэд бутцийн чанар, үр ашгийг сайжруулна.	
3.2.1	Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын үр ашгийг нэмэгдүүлнэ.
3.2.2	Тээвэр, логистикийн аюулгүй байдал, хяналт үйлчилгээний чанарын шаардлагыг ханган, зорчигч ачаа тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

Зорилго 4. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд судалгаа, хөгжүүлэлтийн хангалтгүй санхүүжилт, салбар дундын хамтын ажиллагаа, түншлэл, шинжлэх ухаан, технологийн хоцрогдлын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн 2 зорилт, 12 үйл ажиллагааг төлөвлөлөө.

Зорилт 4.1. Шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан мэдлэгийн засаг, дэвшилтэй болон өндөр технологийг хөгжүүлнэ.	
4.1.1	Судалгаанд сууриссан их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагыг хөгжүүлнэ.
4.1.2	Нээлттэй, нэгдсэн, терелжсэн өндөр технологийн лабораториудыг байгуулж салбар дундын болон салбар дамнасан судалгааны ажлыг хэрэгжүүлнэ.
4.1.3	Шинжлэх ухаан, технологийн судалгааны санхүүжилтийн оновчтой эх үүсвэрийг бүрдүүлж, нэмэгдүүлнэ.
4.1.4	Ногоон устэрөгчийн үйлдвэрлэл, хэрэглээг дэмжинэ.
4.1.5	Сансар судлалыг хөгжүүлнэ.
4.1.6	Үндэсний хиймэл дагуул хеерген ашиглана.
4.1.7	Үндэсний эрдэмтэн, судлаачид мэргэжилтнүүдийн чадавхыг ашиглан бичил, микро ангиллын хиймэл дагуул, пуужингийн технологийг хөгжүүлнэ.
4.1.8	Биотехнологийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжиж, генетик нөөцийн үр шимиийн хүртээмжийг нэмэгдүүлна.
Зорилт 4.2. Үндэсний инновацын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.	
4.2.1	Инновацын олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлж, олон улсын патентын тоог нэмэгдүүлнэ.
4.2.2	Инновацын судалгаа хөгжүүлэлтийг нэмэгдүүлнэ.
4.2.3	Инновацыг засийн засгийн эргэлтэд оруулна.
4.2.4	Мэдээлэл, харилцаа холбооны өндөр технологи инновацын кластер байгуулна.

“Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөлмөрийн дотоод шилжилтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн оновчтой хуваарилалтыг бий болгох, бүтээмжийг бүх салбарт дээшлүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүтээмжид сууриссан цалин хөлсний оновчтой тогтолцоог бүрдүүлэх чиглэлийн зорилго зорилтуудыг тусган хэрэгжүүлснээр үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилго хангагдах боломж бүрдэнэ.

“Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөлмөрийн эрэлтэд нийцсэн ур чадвартай боловсон хүчин бэлтгэх, хувь хүний ур чадвар, боловсролын түвшнийг нэмэгдүүлэх чиглэлийн зорилго зорилтуудыг тусган хэрэгжүүлснээр үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилго хангагдах боломж бүрдэнэ.

“Засаглалын зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд авлигыг устгах, хуулийг бүх нийтээр даган мерддэг болох, шүүхийн шударга тогтолцоо иргэд, хувийн хэвшлийг дэмжсэн төрийн бодлого,

зохицуулалтын үр дүн, үр нөлөөг сайжруулах чиглэлийн зорилго зорилтуудыг тусган хэрэгжүүлснээр үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилго хангагдах боломж бүрдэнэ.

“Байгаль орчны зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд барилга, аж үйлдвэр, тээвэр, эрчим хүч, хөдөө аж ахуйн салбаруудад хаягдал багатай, байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг эдийн засгийн хөшүүргээр дэмжиж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, бүтээмжийг өсгөх чиглэлийн зорилго зорилтуудыг тусган хэрэгжүүлснээр үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилго хангагдах боломж бүрдэнэ.

Мөн “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-гийн 12 бүлэг 103 шалгуур үзүүлэлтийг агуулгын хувьд холбогдох зорилтот хөтөлбөрүүдийн төсөлд бүрэн тусгасан болно.

7.5. Хүрэх үр дүн

Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлсон үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй үндсэн асуудлуудыг багцлан үзэж, тэдгээрийг шийдвэрлэх бодлогын хувилбарыг боловсруулж, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж дүгнэхээс гадна системийн динамик загварчлалын арга зүйг ашиглан Vensim программ дээр 1,000 хувьсагч параметртэй загвар боловсруулан, түүн дээрээ үр дүнг тооцоолон гаргалаа.

Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийг 2023-2030 онд хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулахад чиглэсэн төсвийн оновчтой бодлого хэрэгжүүлж, санхүүгийн удирдлагыг сайжруулан хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхээс гадна баялгийн сангийн зохистой менежментийг хэрэгжүүлж, өрийн дарамтыг бууруулан тогтвортой байдлыг хангана. Мөн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, оролцогчдыг нэмэгдүүлснээр санхүүгийн зах зээлийг тэлж, салбарын эрсдэл даах чадварыг сайжруулан цаашдын тогтвортой байдлыг хангана. Ингэснээр төсвийн болон санхүүгийн тогтвортой байдалд суурилсан макро здийн засгийн тогтвортой байдлыг хангах боломж бүрдэнэ.

- Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх дээд хэмжээг 40 хувьд, Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн ДНБ-д эзлэх хэмжээг 4 хувьд тус тус хүргэн төсвийн хөрөнгө оруулалтын менежментийн үнэлгээ болон зардал, санхүүгийн удирдлагын үзүүлэлтийг сайжруулснаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 0-д хүргэх буюу тэнцвэржүүлсэн орлого, зарлагыг тэнцуулнэ.
- Хамтын, индексэд суурилсан болон биржээр арилжаалагдаг сангийн тоог 20, даатгалын бүтээгдэхүүний тоог 730, финтек үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоог 132-т тус тус хүргэнснээр санхүүгийн салбарын нийт активын ДНБ-д эзлэх хэмжээг 40 хувьд хүргэнэ.
- Инфляцыг зорилтот түвшинд хадгалж, здийн засгийн жилийн дундаж өсөлтийг 6 хувьд хүргэнэ.

2. Компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдийн засаглалыг сайжруулж, санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэн, бизнесийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлнэ. Хөрөнгийн зах зээлийг тэлж, гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар бизнесийн санхүүжилтийн төрөл, хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ худалдааны боломжийг нэмэгдүүлнэ. Ингэснээр компанийн сайн засаглал, санхүүжилтийн оновчтой, хүртээмжтэй тогтолцоо, үр ашигтай худалдааны нөхцөлөөр хангагдсан өрсөлдөх чадвар бүхий бизнес эрхлэх таатай орчин бүрдэнэ.

- Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувийг 32, гадаадын шууд хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувийг 25, дотоодын хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувийг 16 хувьд хүргэн ЖДУ-ийн зээл, санхүүжилтийг нэмэгдүүлснээр хөрөнгө оруулалт болон хөрөнгийн зах зээл ДНБ-ий 32 хувьтай тэнцэнэ.
- Худалдааны чиглэлээр байгуулсан гэрээ хэлэлцээрийн тоог 4-өөр нэмэгдүүлж, нийт экспортын хэмжээг 29,660 сая ам.долларт хүргэх ба түүний 15 хувь нь уул уурхайн бус бүтээгдэхүүн байна.

3. Эдийн засгийн тэргүүлэх салбарын боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Тээвэр логистик, мэдээллийн технологи, харилцаа холбооны сүлжээний үр ашгийг сайжруулж салбаруудыг дэмжих замаар эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлнэ.

- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг 60 хувьд, уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг 30 хувьд тус тус хүргэнээр боловсруулах аж үйлдвэрийн салбар ДНБ-ий 14.6 хувийг бүрдүүлнэ.
- Нийт экспортод эзлэх хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эзлэх хувийг 9 хувьд хүргэнэ.
- Соёлын бүтээлч үйлдвэрлэл ДНБ-ий 4 хувийг, тоон контент үйлдвэрлэл 4 хувийг тус тус бүрдүүлнэ.
- Барилгын материалын хэрэгцээний 60 хувийг дотоодоос хангана.
- Мэдээлэл, харилцаа холбооны салбар ДНБ-ий 28 хувийг бүрдүүлнэ.

4. Судалгаа хөгжлийн зардалд зарцуулж байгаа төсвийн болон төсвийн бус санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн судалгааны тоо, чанарыг сайжруулан шинжлэх ухаан-боловсрол бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийг нэмэгдүүлж, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулан, мэдлэгийн эдийн засаг, шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх замаар үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ.

- Сансар судлалын туршилт, хөгжүүлэлтийн бааз байгуулж, холбооны хиймэл дагуул 1, бага оврын хиймэл дагуул 1-ийг тус тус хөөргене.
- Олон улсын итгэмжлэл бүхий нээлттэй 11 судалгааны төв, лаборатори байгуулна.
- Судалгааны төв, лаборатори, баазыг нэмэгдүүлэх, хувийн салбарын судалгаа хөгжүүлэлтийн зарцуулалтыг нэмэгдүүлэх замаар нийт боловсруулах үйлдвэрлэлд дунд, өндөр технологийн боловсруулах үйлдвэрийн эзлэх хувийг 9 хувьд хүргэнэ.
- Судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг ДНБ-ий 3 хувьд хүргэн нэмэгдүүлнэ.

Дээрх үр дүнгүүд хангагдсанаар эдийн засгийн өндөр бүтээмжтэй, тогтвортой есөлтөөр тэтгэгдсэн хүн амын дундаж давхаргыг нэмэгдүүлэн, Монгол Улсын *өрсөлдөх чадварын үзүүлэлтээр дэлхийд 20 байраар урагшилж 82 дугаар байрт* эрэмбэлэгдэнэ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНД
ОРОЛЦОХ АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС**

Хэлэлцэх асуудал: "Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их хурлын нэгдсэн чуулган, байнгын хороодоор хэлэлцүүлэхтэй холбоотой ажлын хэсгийн нэрс:

№	Нэр	Албан тушаал	Холбоо барих утас
1	Л.Оюун-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд	99099553
2	С.Амарсайхан	Монгол Улсын Шадар сайд	99112169
3	Ц.Нямдорж	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	99115834
4	Б.Жавхлан	Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч	99113555
5	Б.Бат-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	99116177
6	Г.Сайханбаяр	Батлан хамгаалахын сайд	94100050
7	Б.Батцэцэг	Гадаад харилцааны сайд	99113560
8	Х.Нямбаатар	Хууль зүй, дотоод хэргийн сайд	99114118
9	А.Ариунзаяа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	91917074
10	Б.Мөнхбаатар	Барилга, хот байгуулалтын сайд	99112721
11	Л.Энх-Амгалан	Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжлийн сайдын үүрэг хариуцагч	88112318
12	Л.Халтар	Зам, тээврийн хөгжлийн сайд	99114340
13	Ч.Номин	Соёлын сайд	99119494
14	Г.Ёндөн	Уул уурхай, хунд үйлдвэрийн сайд	99093694
15	З.Мэндсайхан	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	99119480
16	Н.Тавинбэх	Эрчим хүчний сайд	99118651
17	С.Энхболд	Эрүүл мэндийн сайд	88884600
18	Б.Лхагвасурэн	Монголбанкны ерөнхийлөгч	99114196
19	Д.Сумъяабазар	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	99110899
20	С.Наранцогт	Эдийн засаг, хөгжлийн дэд сайд	99003447
21	Б.Баатарзориг	Төрийн албаны зөвлөлийн дарга	99114528
22	Б.Батдаваа	Үндэсний статистикийн хорооны дарга	99047002
23	Д.Баярсайхан	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	99110178
24	Х.Батжаргал	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99114286
25	Г.Манлайжав	Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга	94110001
26	Д.Жаргалсайхан	Биеийн тамир, спортын Улсын хорооны дарга	99119093
27	Ж.Ганбаяр	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга	99107116
28	Д.Эрдэнэбаяр	Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга	99097578
29	Д.Сүрэнчимэг	Удирдлагын академийн захирал	99094767